

Монгол Улс

Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон зудыг тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх төслийн мэдээлэл цуглуулах судалгааны ажил

**(Нийтлэг сонгон шалгаруулалтын тендер
(иж бүрэн үнэлгээний аргаар шалгаруулах тендер))**

Ажлын гүйцэтгэлийн тайлан (төсөл)

2023 оны 3-р сар

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА)**

Ориентал Консалтанц Глобал ХК

3R
JR
23-003

Монгол Улс

**Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ
(уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга
хэмжээ) болон зудыг тэсвэрлэх чадавхыг
бүрдүүлэх төслийн мэдээлэл цуглуулах
судалгааны ажил**

**(Нийтлэг сонгон шалгаруулалтын тендер
(иж бүрэн үнэлгээний аргаар шалгаруулах тендер))**

Ажлын гүйцэтгэлийн тайлан (төсөл)

2023 оны 3-р сар

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА)**

Ориентал Консалтанц Глобал ХК

Гарчиг

Зургийн жагсаалт
Хүснэгтийн жагсаалт
Товчилсон үгийн тайлбар

Хуудас

1-р бүлэг Судалгааны тойм

1.1	Судалгааны үндэслэл болон зорилго.....	1-1
1.2	Судалгааны явц болон арга	1-2
1.3	Судалгааны хугацаа	1-3
1.4	Судалгааны багийн бүрэлдэхүүн.....	1-5
1.5	Судалгаанд хамрагдсан аймаг болон сум.....	1-5
1.5.1	Судалгаанд хамрагдсан орон нутгийн тухай үндсэн мэдээлэл.....	1-5
1.5.2	Судалгаанд хамрагдсан аймгийн тухай товч.....	1-6
1.5.3	Судалгаанд хамрагдсан сумыг сонгосон нь	1-7
1.5.4	Судалгаанд хамрагдсан сумын тухай товч	1-10

2-р бүлэг Монгол орны уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой өнөөгийн нөхцөл байдал болон арга хэмжээ

2.1	Холбогдох яам агентлаг, засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй бодлого үүрэг зэрэг.....	2-1
2.1.1	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ)	2-1
2.1.2	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)	2-1
2.1.3	Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ).....	2-2
2.1.4	Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)	2-3
2.2	Зудын урьдчилсан төлөв байдлын өнөөгийн нөхцөл, түвшин, урьдчилсан мэдээлэл түгээлтийн нөхцөл, зохион байгуулалт.....	2-3
2.2.1	Зарлан мэдээлэх системийн өнөөгийн нөхцөл байдал.....	2-3
2.2.2	Дунд хугацааны урьдчилсан мэдээ.....	2-4
2.2.3	Богино хугацааны урьдчилсан мэдээ.....	2-5
2.2.4	Шуурхай мэдээ	2-6
2.3	Бусад урьдчилсан төлөв байдлын систем.....	2-6
2.3.1	PRISM.....	2-6
2.4	Монгол орны мэдээлэл холбооны технологийн өнөөгийн нөхцөл байдал	2-7
2.4.1	Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) 2021 оны статистик мэдээллээр МонголХарилцаа холбооны дэд бүтцийн нөхцөл байдал.....	2-7
2.4.2	Өнөөгийн мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглалтын байдал	2-8
2.4.3	Мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл	2-9
2.5	Зудаас бусад цаг уурын гамшиг.....	2-11
2.6	Цаашид шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлууд	2-11

3-р бүлэг Малчдын зудын үед авдаг арга хэмжээ

3.1	Малчдын ахуй амьжиргааны нөхцөл байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, зохицох гэх мэт	3-2
3.1.1	Мал аж ахуйг голлосон малчдын аж амьдралын хэв маяг	3-2
3.1.2	Зудаас урьдчилан сэргийлэх мэдээ хүлээн авсан малчдын авах арга хэмжээ	3-3
3.1.3	Малчдын чухалчлан үздэг зудыг урьдчилан таамаглах мэдээ	3-7

3.2	Малчдын мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл.....	3-8
3.2.1	Мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл.....	3-8
3.2.2	Малчдын мэдээлэл хүлээн авах арга	3-9
3.2.3	Малчдын мэдээлэл хүлээн аах хэрэгслийг эзэмшиж буй байдал	3-9
3.3	Малчдын орлого.....	3-10
3.3.1	Эдийн засгийн байдал.....	3-10
3.3.2	Малын борлуулалтын нөхцөл байдал.....	3-11
3.3.3	“Зудыг урьдчилсан таамаглаад малаа олноор нь төхөөрсний үр дүнд, махны үнэ огцом буурсан” болон “Мал төхөөрөх, түгээлтийн чанарын менежмент муу байгаа нь үнэ бууруулж байна”	3-20
3.4	Малчдын мал борлуулалтад тулгарч буй асуудал	3-21
3.5	Засаг захиргаанаас малчдад гамшгаас урьдчилан сэргийлэх, дасан зохицох арга хэмжээ авахад үзүүлдэг дэмжлэг, тулгарч буй асуудал.....	3-23
4-р бүлэг Мал аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ		
4.1	Малчдын махны үйлдвэрлэл, түгээлтийн холбогдолтой төрийн бодлого	4-1
4.1.1	Монгол Улсын Засгийн газрын баримтлах чиглэл	4-1
4.1.2	Хүнс, мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хууль тогтоомж	4-2
4.2	Малчдын мах үйлдвэрлэлийн өнөөгийн байдал ба хэрэгцээ	4-5
4.2.1	Орон нутаг дахь мах үйлдвэрлэл	4-5
4.2.2	Орон нутаг дахь махны түгээлт	4-5
4.3	Махны нийлүүлэлтийн гинжин хэлхээний өнөөгийн байдал ба хэрэгцээ.....	4-7
4.3.1	Гарал үүслийг мөшгих тогтолцоо (traceability system)-ны хөгжүүлэлт	4-7
4.3.2	Махыг борлуулсаны дараах хөргүүртэй тээвэрлэлтийн өнөөгийн байдал.....	4-8
4.3.3	Махны экспорт	4-10
4.4	Цаашид тулгамдаж буй асуудал.....	4-11
5-р бүлэг Хандивлагч байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага		
5.1	Энэхүү судалгаанд хамрагдсан салбарт хэрэгжиж буй донор орнуудын хамтын ажиллагаа.....	5-1
5.2	Хандивлагч байгууллагуудын хэрэгжүүлж буй холбогдох төсөл, хөтөлбөрийн агуулга.....	5-2
5.3	Япон улсын Байгаль орчны яамнаас үзүүлж буй дэмжлэг.....	5-10
6-р бүлэг Төслийн үнэлгээний үр дүн		
6.1	Одоо байгаа төлөвлөгөөнд өгөх үнэлгээ.....	6-1
6.1.1	Зудын урьдчилан таамаглах нарийвчлалыг сайжруулах, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр өгөөжтэй ашиглах.....	6-1
6.1.2	Нарны эрчим хүч ашигласан мах хөргөх, хадгалах систем (PV систем)-ийг нэвтрүүлэх тухай	6-2
6.1.3	Хүнсний аюулгүй байдлыг өндөр хэмжээнд хангах шаардлагатай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба түгээлтийг сайжруулах.....	6-6
6.2	Энэхүү судалгааны үр дүн ба тулгамдаж буй асуудлын эсрэг авах арга хэмжээ	6-8
7-р бүлэг Шинээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал		
7.1	Төслийн хүрээ	7-1
7.2	Үйл ажиллагаа 1: Зудын урьдчилсан мэдээний ашиглалтын чадавхыг бэхжүүлэх	7-3

7.2.1	Үйл ажиллагаа 1-1: Мэдээ илгээгч болон хүлээн авагч талын аль аль нь мэдээлэл дамжуулсныг нягтлах боломжтой SMS функцийг сайжруулж засаг захиргаа болон малчдын хоорондын мэдээлэл харилцааг бэхжүүлэх.....	7-3
7.2.2	Үйл ажиллагаа 1-2: Малчдын мэдээллийн сан байгуулж мэдээлэл дамжуулах үр ашгийг нэмэгдүүлэх	7-5
7.3	Үйл ажиллагаа 2: Малын тэжээл бэлтгэлийг сайжруулж мал аж ахуйн чадавхыг бэхжүүлэх.....	7-6
7.3.1	Үйл ажиллагаа 2-1: Сумын түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж бэлчээрийг зохистой ашиглах	7-7
7.3.2	Үйл ажиллагаа 2-2: Хадлангийн газрыг тодорхой болгож хадлан бэлдэх, тэжээлийн ургамал тариалах замаар малын тэжээлийг төрөлжүүлж тэжээл бэлтгэлийн тогтвортой байдлыг хангах.....	7-7
7.3.3	Үйл ажиллагаа 2-3: Ургамал хамгааллыг хэрэгжүүлж бэлчээрийн нөхөн сэргэлтийг хангах, хяналт мониторингийг хэрэгжүүлэх.....	7-8
7.4	Үйл ажиллагааг 3: Технологийн шинэчилсэн журамд нийцсэн махны хангалт нийлүүлэлтийн тогтолцоог байгуулах	7-9
7.4.1	Үйл ажиллагаа 3-1: Шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулахыг сумын түвшинд байгуулж, шинэлэг чанарыг хадгалах технологи бүхий махны нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгох ..	7-10
7.4.2	Үйл ажиллагаа 3-2: Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбосон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх	7-11
7.4.3	Үйл ажиллагаа 3-3: Хүнсний технологич бэлтгэх.....	7-12
7.5	Төслийн зардал.....	7-13
7.6	Хамтран ажиллах байгууллагууд.....	7-14
7.6.1	Зудын мэдээлэл дамжуулах, хамтран ашиглах	7-14
7.6.2	Тэжээл бэлтгэл.....	7-15
7.6.3	Малын хангалт нийлүүлэлтийн эргэлт.....	7-15

8-р бүлэг Бусад хамтын ажиллагааны агуулга

8.1	Тэжээлийн төв байгуулах	8-4
8.2	Экспортонд гаргах зориулалттай махны шинэ байдлыг хадгалах, хөргөх агуулахыг хоёр шатлалтай зээлээр байгуулах.....	8-6
8.3	Өндөр үр ашигтай малын байрыг байгуулах.....	8-8
8.4	Зудын эрсдлийг хянах чадварыг бэхжүүлэх төсөл.....	8-10

Зургийн жагсаалт

Хуудас

Зураг 1-1	CN-д төлөвлөж буй үйл ажиллагаа болон энэхүү ажлын судалгааны агуулга.....	1-2
Зураг 1-2	Таван хошуу малын тоо.....	1-6
Зураг 1-3	Судалгаанд хамрагдсан аймаг.....	1-7
Зураг 1-4	Судалгаанд хамрагдсан сумын байршил	1-9
Зураг 2-1	ХХААХҮЯ-ны бүтэц	2-1
Зураг 2-2	БОАЖЯ-ны бүтэц	2-2
Зураг 2-3	ЦУОСМХ-ийн бүтэц	2-2
Зураг 2-4	ОБЕГ-ын бүтэц	2-3
Зураг 2-5	УЦУОСМХ-ээс гаргадаг зудын эрсдэлийн зураг	2-5
Зураг 2-6	удын эрсдэлийн зураг шинэчлэгдэх байдал	2-6
Зураг 2-7	PRISM-ийн дэлгэц	2-7
Зураг 3-1	Малчдын судалгаанд оролцож байгаа нь.....	3-1
Зураг 3-2	Бэлчээрт жилд нүүдэллэх тоо давтамж.....	3-2
Зураг 3-3	Бэлчээрт нүүдэллэх зай	3-2
Зураг 3-4	Зудаас урьдчилан сэргийлэх мэдээ хүлээн аваад юу хийх вэ	3-4
Зураг 3-5	Зудын урьдчилсан мэдээ хүлээн авсны дараа малчдын хэрэгжүүлдэг арга хэмжээ.....	3-6
Зураг 3-6	Малчдын мэдээлэл хүлээн авсан, дамжуулсан жишээ	3-8
Зураг 3-7	Малчдын мэдээлэл хүлээн авах хэрэгсэл (2022 оны 11 сар).....	3-9
Зураг 3-8	Хонь, ямаагаа борлуулдаг газар.....	3-15
Зураг 3-9	Хонь, ямаагаа борлуулдаг хэлбэр	3-15
Зураг 3-10	Хонь, ямаа борлуулдаг улирал.....	3-17
Зураг 3-11	Хонь, ямаа борлуулдаг зорилго	3-17
Зураг 3-12	Махны зах зээлийн үнэ, улирлын өөрчлөлт	3-20
Зураг 3-13	Гулууз махны жин (кг), худалдаалах үнэ (төг)-ийн харилцан хамаарал.....	3-21
Зураг 3-14	Мал борлуулахад тулгарч буй асуудал.....	3-23
Зураг 3-15	Тэжээлийн агуулах (Сум, Аймаг, Улс)	3-24
Зураг 4-1	Махны түгээлтийн шат дараалал.....	4-6
Зураг 4-2	Мандалговь дахь махны худалдаа	4-7
Зураг 4-3	QR код ашиглан гарал үүслийг мөшгих тогтолцоог нэвтрүүлсэн байдал	4-8
Зураг 4-4	УБ хотын махны зах ба махны компани	4-9
Зураг 4-5	Хөлдөөгчтэй агуулахын ашиглах зориулалт	4-10
Зураг 4-6	Хөлдөөгчтэй агуулахын хяналт тавих этгээд.....	4-10
Зураг 6-1	Туршилтаар ашиглаж буй PV систем.....	6-3
Зураг 6-2	Нарны эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмж.....	6-3
Зураг 6-3	Шаардлагатай тоног төхөөрөмж	6-4
Зураг 7-1	Шинээр хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагааны ерөнхий агуулгын бүдүүвч.....	7-2
Зураг 7-2	Үйл ажиллагааны ерөнхий агуулга	7-2
Зураг 7-3	SMS функцийн сайжруулалтын үр дүн	7-4
Зураг 7-4	Үйл ажиллагаа 2-ын ерөнхий агуулга.....	7-6
Зураг 7-5	Үйл ажиллагаа 3-ын ерөнхий агуулга.....	7-10
Зураг 7-6	Газар үүслийн мэдээллийн системийн бүтэц, зохион байгуулалт	7-12

Хүснэгтийн жагсаалт

Хуудас

Хүснэгт 1-1	Нэгдүгээр ээлжийн судалгааны хуваарь	1-3
Хүснэгт 1-2	2-р ээлжийн судалгааны хуваарь	1-4
Хүснэгт 1-3	Гишүүдийн бүрэлдэхүүн болон орон нутагт ажилласан хугацаа.....	1-5
Хүснэгт 1-4	2009/2010 оны зуданд хамгийн олон толгой мал хорогдсон аймаг, аймаг тус бүрийн малчин өрхийн тоо болон өрх тутмын малын тоо	1-6
Хүснэгт 1-5	Судалгаанд хамрагдсан сумыг сонгох шалгуур үзүүлэлт	1-7
Хүснэгт 1-6	Судалгаанд хамрагдсан сумдын хоршооны үйл ажиллагаа	1-8
Хүснэгт 1-7	Дундговь аймаг дахь малын тоо толгой хорогдсон байдал.....	1-8
Хүснэгт 1-8	Говь-Алтай аймаг дахь малын тоо толгой хорогдсон байдал	1-9
Хүснэгт 1-9	Судалгаанд хамрагдсан сумдууд.....	1-10
Хүснэгт 2-1	Монгол улсын мэдээллийн технологийн нэвтрэлтийн түвшин	2-7
Хүснэгт 2-2	Монгол улсын харилцаа холбооны оператор тус бүрийн.....	2-8
Хүснэгт 2-3	Малчдын мэдээлэл технологийн төхөөрөмж эзэмшилтийн хувь (n=212)	2-9
Хүснэгт 2-4	Гар утасны аппликейшны харьцуулалт	2-10
Хүснэгт 3-1	Сумын оролцогчдын тоо болон судалгааг зохион байгуулсан өдөр	3-1
Хүснэгт 3-2	Өвөлжөөтэй эсэх	3-3
Хүснэгт 3-3	Тэжээлийн агуулахтай эсэх	3-3
Хүснэгт 3-4	Зудыг урьдчилан таамаглахад тодорхойлох хүчин зүйлүүдийг малчдын хувьд эн тэргүүнээр нь дугаарласан байдал (n=208).....	3-7
Хүснэгт 3-5	Малчдын мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл.....	3-8
Хүснэгт 3-6	Малчдын мэдээлэл хүлээн авах арга.....	3-9
Хүснэгт 3-7	Сум тус бүрийн малчин өрхөд ноогдох нийт орлого.....	3-10
Хүснэгт 3-8	Сум тус бүрийн малчин өрхийн зардал (үйл ажиллагааны зардал).....	3-10
Хүснэгт 3-9	Сум тус бүрийн малчдын жилийн орлого	3-11
Хүснэгт 3-10	Малчин өрхөд ноогдох зээл, зээлдүүлэгч, зээлийн зориулалт.....	3-11
Хүснэгт 3-11	Сум тус бүрийн малчин өрхөд ноогдох эзэмшиж буй малын тоо толгой, малын төрөл харьцаа	3-12
Хүснэгт 3-12	Малчин өрхөд ноогдох хувьдаа хэрэглэх, бэлэглэх, худалдах малын тоо	3-12
Хүснэгт 3-13	Мал борлуулах үнэ	3-13
Хүснэгт 3-14	Малчин нэг өрхөд ноогдох борлуулалтын хэмжээ, харьцаа малын төрлөөр	3-13
Хүснэгт 3-15	Малын төрөл тус бүрээр борлуулдаг газар болон борлуулах хэлбэр	3-14
Хүснэгт 3-16	Малын төрөл тус бүрээр борлуулдаг улирал болон борлуулах зорилго.....	3-16
Хүснэгт 3-17	Малчин өрхөд ноогдох сүүний хэрэглээ, борлуулах хэмжээ.....	3-18
Хүснэгт 3-18	Сүүний борлуулах үнэ.....	3-18
Хүснэгт 3-19	Малчин өрхөд ноогдох бусад мал аж ахуйн бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээ, нэгж үнэ.....	3-19
Хүснэгт 3-20	Малчин өрхөд ноогдох тэжээл (өвс)-ийн хэмжээ, худалдаж авсан тэжээлийн хэмжээ болон үнэ	3-19
Хүснэгт 4-1	"Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-аас (шинэ дүрэм).....	4-1
Хүснэгт 5-1	Монгол дахь кластер болон хариуцсан байгууллагуудын жагсаалт	5-1
Хүснэгт 6-1	УАНС-д дэвшүүлсэн CN төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа болон энэхүү судалгааны хүрээнд нягтлагдсан агуулга	6-1
Хүснэгт 6-2	Монголд авах боломжтой нарны эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмж	6-3
Хүснэгт 6-3	Хөлдөөгчтэй контейнерын цахилгааны зардлын тооцоо	6-5
Хүснэгт 6-4	Хүний нөөцийн зардлын тооцоо	6-7
Хүснэгт 6-5	Хөлдөөгчтэй контейнерын орлого, зарлагын тооцоо (төг).....	6-8
Хүснэгт 6-6	Одоо байгаа төлөвлөгөөний тухай судалгааны үр дүн ба шинээр дэвшүүлэх үйл ажиллагааны санал.....	6-9

Хүснэгт 7-1	SMS статусын мэдээллийн төрөл.....	7-3
Хүснэгт 7-2	Багийн даргын хөтлөх хяналтын эксел хүснэгт.....	7-4
Хүснэгт 7-3	SMS функцийг сайжруулахад шаардагдах хөрөнгө оруулалт	7-5
Хүснэгт 7-4	Багийн засаг дарга нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтад шаардагдах хөрөнгө оруулалт.....	7-6
Хүснэгт 7-5	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалт.....	7-7
Хүснэгт 7-6	Малын тэжээл бэлтгэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт.....	7-8
Хүснэгт 7-7	Малын тэжээл бэлтгэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт.....	7-9
Хүснэгт 7-8	Сумын түвшинд мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулах байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалт.....	7-11
Хүснэгт 7-9	Гарал үүслийн мэдээллийн системд шаардагдах хөрөнгө оруулалт	7-12
Хүснэгт 7-10	Хүнсний технологич бэлтгэхэд шаардагдах хөрөнгө оруулалт	7-13
Хүснэгт 7-11	Төслийн нийт зардал (1 аймагт ногдох).....	7-14
Хүснэгт 8-1	Судалгааны гол үр дүн , тодорхой болсон асуудлууд ба Япон улсын дэмжлэгээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал.....	8-1
Хүснэгт 8-2	Санал болгож буй дэмжлэг үйл ажиллагаа.....	8-4

Товчилсон үгсийн тайлбар

ADB	Asian Development Bank	Азийн хөгжлийн банк (АХБ)
ADMEM	Aimag (District) Department for Meteorology and Environment Monitoring	Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар
ADPC	Asian Disaster Preparedness Center	Азийн гамшгаас урьдчилан сэргийлэх төв (АГУСТ)
AEMD	Aimag (District) Emergency Management Department	Аймгийн онцгой байдлын газар
CP	Counter part	Хамтрагч байгууллага
DB	Database	Мэдээллийн сан
EMDC	Emergency Management Department of the Capital City	Нийслэлийн онцгой байдлын газар (НОБГ)
ERI	Economic Research Institute	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн
FAO	Food and Agriculture Organization of the United Nations	Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
FB	Facebook	Фэйсбүүк
GAVS	General Authority for Veterinary Services	Мал эмнэлгийн ерөнхий газар
GCF	Green Climate Fund	Уур амьсгалын ногоон сан
GDP	Gross Domestic Product	Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)
GIS	Geographic Information System	Газарзүйн мэдээллийн систем
IFC	International Finance Corporation	Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)
IFRC	International Federation of Red Cross and Red Crescent Societies	Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэг
IRIMHE	Information and Research Institute of Meteorology, Hydrology and Environment	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
JICA	Japan International Cooperation Agency	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)
MAS	Mongolian Academy of Sciences	Монгол улсын Шинжлэх ухааны Академи
MCUD	Ministry of Construction and Urban Development	Барилга, хот байгуулалтын яам
MET	Ministry of Environment and Tourism	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
MNT	Mongolian tögrög	Монгол төгрөг
MOFALI	Ministry of Food and Agriculture Light Industry	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
MOU	Memorandum of Understanding	Ойлголцлын санамж бичиг
MRCS	Mongolian Red Cross Society	Монголын Улаан Загалмай Нийгэмлэг (МУЗН)

MULS	Mongolian State University of Life Sciences	Хөдөө аж Ахуйн Их Сургууль
MUST	Mongolian University of Science and Technology	Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС)
NAMEM	National Agency for Meteorology and Environment Monitoring	Цаг уур, орчны шинжилгээний газар
NEMA	National Emergency Management Agency	Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)
NGO	Non-Governmental Organization	Төрийн бус байгууллага (ТББ)
NUM	National University of Mongolia	Монгол улсын их сургууль (МУИС)
SDGs	Sustainable Development Goals	Тогтвортой хөгжлийн зорилтууд
SMS	Short Message Service	Гар утасны мессеж үйлчилгээ
UB	Ulaanbaatar	УБ
UNDP	United Nations Development Programme	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)
USAID	United States Agency for International Development	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)
USD	United States Dollar	Америк доллар (ам.доллар)
WB	World Bank	Дэлхийн Банк
WG	Working Group	Ажлын хэсэг
WHO	World Health Organization	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)
WV	World Vision	Дэлхийн зөн

1-р бүлэг Судалгааны тойм

1.1 Судалгааны үндэслэл болон зорилго

Монгол оронд (цаашид Монгол гэх) “Зуд” хэмээх хүйтний улиралд цаг агаарын тааламжгүй нөхцлийн улмаас үүдэх гамшиг нь малчдын амьдралд асар их нөлөө үзүүлдэг. Зуд гэдэг нь “Өвөл, хаврын улиралд бэлчээрийн өвс болон усны хүрэлцээ хангамж дутмагаас болж малын тарга хүч алдагдаж олон зуун толгой мал үхэж үрэгддэг байгалийн гамшиг юм” гэж тодорхойлсон байдаг ба малын хорогдол нь малчдын орлогыг асар ихээр бууруулдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хур тунадасны хэмжээ буурах хандлага нь зуны улиралд гантай байснаас хатуу өвөл болж зуд тохиолдох нөхцөл бүрддэг гэж үздэг.

Түүнчлэн малчид зуднаар олон тооны малаа алдсан тохиолдолд нийслэл хот руу нүүх үзэгдэл олон жилийн турш үргэлжилсэн бөгөөд нийслэл УБ хотод (цаашид УБ гэх) хүн амын хэт төвлөрөл бий болж агаарын бохирдол, дэд бүтцийн дутмаг байдал зэрэг нийслэлд олон тулгамдсан асуудал, хүндрэлүүд бий болсоор ирсэн ба зудын хохирлыг бууруулах нь Монгол орны хувьд нэн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Өнөөг хүртэл ЖАЙКА уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээний хүрээнд “Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхыг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл (2017 оны 11-р сараас-)”, “Нүүдэлчин Монголчуудын уламжлалт мэдлэгт тулгуурлан бэлчээрийн тэжээлийн ургамлыг зүй зохистой ашиглах замаар бэлчээрийг сайжруулах (2021~2025 он)” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд “Мал эмнэлэг, Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл (2014~2020 он), “Төрийн болон Хувийн хэвшлийн малын эмч нарын практик чадавхыг бэхжүүлэх ” (2020~2025 он) зэрэг төслөөр дамжуулан малын эмч нар болон мал аж ахуйн салбарын мэргэжилтэн, хүний нөөц бэлтгэх үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн бөгөөд мөн “Хөдөө Аж Ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл” нь (2020 оноос хойш хэрэгжиж буй) үйлдвэрлэл, боловсруулалт, нийлүүлэлт, борлуулалттай холбоотой нэмүү өртгийн гинжин хэлхээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн Японы Байгаль орчны яамнаас Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд “Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө боловсруулахтай холбоотой дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (2019 он)” (судалгаа) хэрэгжүүлсэн.

Эдгээрийн зэрэгцээ ЖАЙКА-аас малчид зудын хохирлоос урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийх, бууруулах зорилгоор хамтран ажиллах боломж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ боловсруулахад гадны санхүүжилт (Уур амьсгалын ногоон сан (GCF)) ашиглах боломжийг судалсаар ирсэн.

Өнөөдрийг хүртэл 2 удаагийн судалгаа хэрэгжүүлсэн ба ① Зуд урьдчилсан төлөв байдлыг тодорхойлох аргыг нарийвчлах, тэдгээрийг ашиглах чадавхыг бэхжүүлэх, ② Зудын урьдчилсан төлөв байдлыг тодорхойлсон үр дүнг ашиглах, ③ Нарны эрчим хүч (Photovoltaic) дээр суурилсан махны хөргүүрийн систем (цаашид PV систем гэх) нэвтрүүлэх, ④ Хүнсний аюулгүй байдлыг хангасан мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг сайжруулах гэсэн 4 чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлнэ хэмээн төлөвлөж Уур амьсгалын ногоон санд Concept Note (CN) хүргүүлж, дараагийн шатны төслийн санал төлөвлөн судалж байна.

Энэхүү ажлыг дээрх үндэслэлд тулгуурлан төслийн саналыг бодит, үр ашигтай боловсруулахын тулд ялангуяа малчдын гамшгаас сэргийлэх, дасан зохицох арга хэмжээ голлосон мэдээлэл цуглуулахыг зорив.

Монгол орны зудын гамшигтай холбоотой өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, зудын урьдчилсан төлөв байдалд нийцсэн малчдын дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай төслийн агуулгыг хэлэлцэв. Тодруулбал хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор ЖАЙКА-аас хамтран ажиллах боломж мөн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой гадны санхүүжилтийг (Уур амьсгалын ногоон сан (GCF) зэрэг) ашиглах боломжийг судлах зорилготой.


1.2 Судалгааны явц болон арга

Энэхүү ажил нь дээр дурдсан 4 үйл ажиллагааны чиглэл буюу өөрөөр хэлбэл ① Зуд болохыг урьдчилан тодорхойлох нарийвчлэлийг сайжруулах, тэдгээрийг ашиглах чадавхыг бэхжүүлэх, ② Зудыг урьдчилан тодорхойлсон үр дүнг ашиглах, ③ Нарны эрчим хүч (Photovoltaic) ашигласан махны хөргүүрийн систем (цаашид PV систем гэх) нэвтрүүлэх, ④ Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг сайжруулах зэрэгтэй холбоотой тулгамдсан асуудлыг тодруулах зорилгоор мэдээлэл цуглуулав.

Зураг 1-1-д CN-д төлөвлөж буй үйл ажиллагаа ба “Малчдын зудад дасан зохицох чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдлэг, үйл ажиллагааг тодруулах”, “Зудын урьдчилсан төлөв байдлын талаарх мэдээллийг хүлээн авах, дамжуулахтай холбоотой тулгамдаж буй асуудал”, “PV систем (нарны эрчим хүч) нэвтрүүлэхтэй холбоотой асуудлууд, үр ашиг, тогтвортой байдлын тойм”, “Малчдын махны үйлдвэрлэлийг тойрсон асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөндлөнгийн оролцоог дахин судлах” зэргийг багтаалаа.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ холбогдох тайлан, номоос гадна орон нутгийн судалгаанд Монгол талын холбогдох байгууллагууд, зорилтот аймгийн холбогдох албан тушаалтнууд болон сумын малчидтай ярилцлага хийсэн.

Судалгааны зорилго ба агуулга



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 1-1 CN-д төлөвлөж буй үйл ажиллагаа болон энэхүү ажлын судалгааны агуулга

1.3 Судалгааны хугацаа

Нэгдүгээр ээлжийн судалгааны ажлыг 2022 оны 10-р сарын 10 (даваа) ~ 11-р сарын 9 (лхагва) хүртэлх 31 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бол хоёрдугаар ээлжийн судалгааг 2022 оны 12-р сарын 14 (лхагва) ~ 12-р сарын 28 (лхагва) хүртэл 15 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1-1 Нэгдүгээр ээлжийн судалгааны хуваарь

Сар, өдөр		Уулзалт хийсэн байгууллага
10/10	Даваа	Нарита→УБ (УБ)
10/11	Мягмар	ЖАЙКА Монгол дахь төлөөлөгчийн газар, ХХААХҮЯ (Бодлого төлөвлөлтийн газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар)
10/12	Лхагва	Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Уур амьсгалын өөрчлөлтийн газар)
10/13	Пүрэв	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (ХАА-н цаг уурын судалгааны хэлтэс)
10/14	Баасан	МУИС, ШУТИС (Тана лаборатори), Цахим хөгжил, харилцаа холбооны яам
10/15	Бямба	Материал цэгцлэх
10/16	Ням	Материал цэгцлэх
10/17	Даваа	Уур амьсгалын ногоон сан - Focal Point, ОБЕГ
10/18	Мягмар	Мандалговь аймгийн ХХААГ болон Онцгой байдлын газар
10/19	Лхагва	Дундговь аймгийн малчин өрхийн судалгаа
10/20	Пүрэв	Семинар (УБ)
10/21	Баасан	【Дундговь аймаг】 Уб→Мандалговь 【УБ】 Дэлхийн зөн
10/22	Бямба	【Дундговь аймаг】 Малчин өрхийн судалгаа (Гурвансайхан сум)
10/23	Ням	【Дундговь аймаг】 Малчдын оролцох семинарийн бэлтгэл
10/24	Даваа	【Дундговь аймаг】 Малчдын семинар (Гурвансайхан сум) 【УБ】 (АГУСТ)
10/25	Мягмар	【Дундговь аймаг】 Малчдын семинар (Адаацаг сум) 【УБ】 IT парк
10/26	Лхагва	【Дундговь аймаг】 Махны худалдаа эрхлэгчдийн судалгаа, Дундговь аймгийн Статистикийн газар, Дундговь аймгийн цаг уурын алба, Хэвлэл мэдээллийн байгууллагууд
10/27	Пүрэв	【Дундговь аймаг】 Дундговь аймгийн ХХААГ болон ОБГ, Махны үйлдвэр (Мал нядалгааны үйлдвэр, Малчин өрхийн судалгаа (Мандалговь сум) 【УБ】 ШУТИС
10/28	Баасан	【Дундговь аймаг】 Мандалговь→УБ 【УБ】 УАӨСХАТ (Батжаргал), FARMDO компани
10/29	Бямба	Материал цэгцлэх
10/30	Ням	Материал цэгцлэх
10/31	Даваа	Монхорус ХХК
11/1	Мягмар	Уур амьсгалын ногоон сан - Region office, Gmobile, Spotter, UNITEL,
11/2	Лхагва	Мэдээлэл, харилцаа холбооны судалгаа/мах нийлүүлэлтийн судалгаа
11/3	Пүрэв	Судалгааны үр дүнгийн нэгтгэл
11/4	Баасан	Хүчит шонхор махны зах, PlescomХХК,
11/5	Бямба	Материал цэгцлэх

Сар, өдөр		Уулзалт хийсэн байгууллага
11/6	Ням	Материал цэгцлэх
11/7	Даваа	Судалгааны үр дүнгийн нэгтгэл
11/8	Мягмар	ХХААХҮЯ (Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар), Мал эмнэлгийн ерөнхий газар, Монголын Махны Холбоо,
11/9	Лхагва	УБ→Нарита

Хүснэгт 1-2 2-р ээлжийн судалгааны хуваарь

Сар, өдөр		Уулзах байгууллага
12/14	Лхагва	Нарита→УБ
12/15	Пүрэв	Холбогдох хууль, журмын талаар мэдээлэл цуглуулах
12/16	Баасан	Жи-Мобайл
12/17	Бямба	Материал цэгцлэх
12/18	Ням	Материал цэгцлэх
12/19	Даваа	ЖАЙКА Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч, Мал эмнэлгийн газар
12/20	Мягмар	УЦУОШХ, БОАЖЯ, ХХААХҮЯ
12/21	Лхагва	Семинарийн бэлтгэл
12/22	Пүрэв	Семинар (УБ), Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч, Мал эмнэлгийн газар
12/23	Баасан	ОБЕГ 【Говь-Алтай аймаг】 УБ→Алтай хот
12/24	Бямба	【Говь-Алтай аймаг】 Аймгийн ХХААГ
12/25	Ням	【Говь-Алтай аймаг】 Алтай↔Бигэр сум , Сумын засаг дарга болон бусад,
12/26	Даваа	【Говь-Алтай аймаг】 Алтай→Арвайхээр(Өвөрхангай аймаг)
12/27	Мягмар	【Говь-Алтай аймаг】 Арвайхээр→УБ
12/28	Лхагва	УБ→Нарита

1.4 Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийн бүрэлдэхүүнийг доорхи хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт 1-3 Гишүүдийн бүрэлдэхүүн болон орон нутагт ажилласан хугацаа

Хариуцах салбар	Нэр	Томилолтын хугацаа
Ажлын хэсгийн ахлагч/Нийгмийн судалгаа①	Овада Киётака	2022 оны 10-р сарын 10~2022 оны 10-р сарын 21 2022 оны 12-р сарын 19~2022 оны 12-р сарын 28
Нийгмийн судалгаа②	Комияма Хироши	2022 оны 10-р сарын 17~2022 оны 10-р сарын 28
Мэдээлэл харилцаа холбооны судалгаа	Такатори Исао	2022 оны 10-р сарын 24~2022 оны 11-р сарын 4 2022 оны 12-р сарын 14~2022 оны 12-р сарын 26
Зах зээлийн судалгаа ①	Үэхара Арицүнэ	2022 оны 10-р сарын 10~2022 оны 11-р сарын 9 2022 оны 12-р сарын 14~2022 оны 12-р сарын 28
Зах зээлийн судалгаа ②	Ота Ёоко	2022 оны 10-р сарын 10~2022 оны 11-р сарын 4

1.5 Судалгаанд хамрагдсан аймаг болон сум

1.5.1 Судалгаанд хамрагдсан орон нутгийн тухай үндсэн мэдээлэл

Монгол орны таван хошуу малын ихэнх нь (адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа) өнөөг хүртэл уламжлалт нүүдлийн мал аж ахуй хэлбэртэй байна. 1920-иод оноос хойш 1990 он хүртэл нийт малын тоо толгой 20 саяас 26 сая хүртэл хэлбэлзэж ирсэн боловч 1990 оноос хойш өмч хувьчлалын бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор малчин иргэдийн тоо эрс өсч үүнтэй зэрэгцээд малын тоо толгой огцом өссөн. 1999 оны эцэс гэхэд 33 сая 570 мян/толгой хүрсэнээс 1999/2000 он, 2000/2001 он, 2001/2002 онуудад 3 өвөл дараалсан томоохон зуд тохиолдож тус 3 жилийн хугацаанд 11 сая 170 мянган том мал хорогдсон¹ тоон үзүүлэлт гарсан байдаг. Үүний улмаас 2002 оны эцсийн мал тооллогын дүнгээр 23 сая 900 мянган толгой болтлоо буурчээ.

Дээрх 3 жил дараалсан зудын хохирлын улмаас малчин иргэдийн тоо 2005 он хүртэл буурсаар байсан бөгөөд нийт малын тоо толгой 2003 оноос сэргэж эхлэн 2009 оны эцэс гэхэд 44 сая 20 мянган толгойд хүрчээ. Үүнээс 2009/2010 онд хатуу өвөл болсон ба маш хүйтэн, цас ихтэй сүүлийн 10 жилд болоогүй томоохон хэмжээний зуд тохиолдож 2010 онд улсын хэмжээнд 10 сая 32 мянган толгой том мал хорогджээ. 2010 оноос хойш томоохон хэмжээний зуд тохиолдоогүй байгаа боловч 2016 оноос хойш жил бүр шахуу зуд, шороон шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихсэж 2018 онд 2 сая 640 мянга (өмнөх жилийн тоо толгойн 4.0%), 2020 онд 2 сая 60 мянга (мөн ижил 2.9%), 2021 онд 3 сая 10 мянган (мөн 4.5%) мал хорогдсон гэж бүртгэгджээ².


2011 оноос хойш малын тоо толгой өссөөр байгаа бөгөөд 2019 онд түүхэнд хамгийн олон буюу 70.97 сая толгой мал тоологдсон байна. Судалгааны дүнгээс харахад Монгол орны бэлчээрт тогтвортой мал аж ахуй эрхлэх боломжтой малын тоо толгой нь хонин толгойд шилжүүлснээр³ 60~70 сая бөгөөд 2021 оны байдлаар Монгол улсын хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа малын тоо хонин толгойгоор 120 сая малтай тэнцэж бэлчээрийн даац хэтэрсэн байдалтай байгаа нь Монголын мал аж ахуйн салбарт томоохон зудын гамшиг тохиолдлоо гэхэд гайхах зүйлгүй юм.

Доор энэхүү үйл ажиллагааны хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг болон сумын мал аж ахуйн өнөөгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тусгав.

¹ Уг хорогдсон малын тоонд өвчин болон ослын улмаас хорогдсон малын тоог оруулсан.

² Цаг уурын аюулт үзэгдэл бага тохиолдсон жилд малын хорогдол 1-2% байна.

³ 1 адуу 7 хоньтой, 1 үхэр 6 хоньтой, 1 тэмээ 5 хоньтой, 1 ямаа 0.9 хонин толгойтой тэнцэнэ.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Зураг 1-2 Таван хошуу малын тоо

Дараах хэсэгт судалгаанд хамрагдсан аймаг, сумын мал аж ахуйн өнөөгийн нөхцөл байдлын тухай дурдав⁴.

1.5.2 Судалгаанд хамрагдсан аймгийн тухай товч

Судалгаанд хамрагдах аймгуудыг зудын хамгийн их хохиролтой аймгуудаас сонгосон. Хүснэгт 1-4 2009/2010 оны зуднаар хорогдсон малын тоо толгой хамгийн олон байсан 4 аймгийг үзүүлэв. Хамгийн олон мал хорогдсон дарааллаар нь авч үзэхэд Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Дундговь аймаг байна. Зудын эсрэг арга хэмжээний дасан зохицох үйл ажиллагааны нэг нь малын тоо толгойг бууруулах явдал гэж үзвэл олон малтай малчин өрхийг соносноор арга хэмжээ хэрэгжүүлсний дараах үр дүнг мэдэх боломжтой. Дээрх 4 аймгаас өрх тутамд ноогдох малын тоогоороо олон аймгийг дарааллаар нь харвал Дундговь, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай гэсэн дараалалтай байна. (Хүснэгт 1-4)

Эдгээр үзүүлэлтийг үндэслэн судалгаанд хамрагдах аймгаар Дундговь аймгийг сонгосон.

Хүснэгт 1-4 2009/2010 оны зуданд хамгийн олон толгой мал хорогдсон аймаг, аймаг тус бүрийн малчин өрхийн тоо болон өрх тутмын малын тоо

	Аймаг	Хорогдсон малын тоо		Малчин өрхийн тоо (мян.өрх)	Өрх тутмын малын тоо (толгой)
		Малын тоо (мян.толгой)	Хувь (%)		
1	Өвөрхангай аймаг	1,439.19	42%	19.81	203
2	Завхан аймаг	1,418.27	45%	13.87	271
3	Говь-Алтай аймаг	1,190.39	48%	10.97	273
4	Дундговь аймаг	929.08	46%	8.94	355

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жич: Хорогдсон малын тоо толгойг 2010/2008 оны малын тооны зөрүүгээр тооцсон болно. Малчин өрхийн тоо болон өрх тутмын малын тоо толгой 2022 оны байдлаар үзүүлэв.

⁴ Mongolia Guide-ын мэдээллийг авч хэрэглэв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 1-3 Судалгаанд хамрагдсан аймаг

Дундговь болон Говь-Алтай аймаг хоёулаа говийн бүсэд байрладаг бөгөөд голлон бэлчээрийн өвс тэжээлд түшиглэдэг нь малын тэжээлийн нөхцөл ижил байна. Нөгөө талаар УБ хотоос Дундговь аймаг 300 км, Говь-Алтай аймаг 1000 км алслагдмал, махны нийлүүлэлтийн нөхцөл байдал хоёр аймаг ихээхэн ялгаатай. Дундговь аймаг нь аймагтаа нядалсан малаа УБ хот руу нийлүүлэх боломжтой. Харин Говь-Алтай аймаг УБ -ийн зах зээлд мах нийлүүлэхдээ хөргүүртэй тээврийг үндсэндээ ашиглаж байна. Эдгээр мах нийлүүлэлтийн ялгаатай нөхцөл байдлаас авч үзсэн ч тус хоёр аймгийг сонгох шалтгааны нэг болсон байна.

1.5.3 Судалгаанд хамрагдсан сумыг сонгосон нь

Судалгаанд хамрагдсан сумын хувьд Дундговь аймаг, Говь-Алтай аймгаас тус бүр хоёр сум (нийт 4 сум) сонгосон. Хүснэгт 1-5-д үзүүлсэний дагуу судалгаанд хамрагдах сумыг сонгох шалгуур үзүүлэлтийг тогтоож сонгосон ба аймгийн ХХААГ-ын албан тушаалтан, мэргэжилтэн нартай доорх шалгуур үзүүлэлтийг тогтоож бүс нутгийн суурь нөхцлийг агуулсан бусад сумдууд дотроос зудын хохирол их, малчдын хоршооны үйл ажиллагаа идэвхтэй сумдаас нэр дэвшүүлж хэлэлцэн тодруулсны үндсэн дээр сонгосон болно.

Хүснэгт 1-5 Судалгаанд хамрагдсан сумыг сонгох шалгуур үзүүлэлт

Сонгох шалгуур үзүүлэлт	Зорилтот сумын сонгогдсон бодит нөхцөл
<input type="checkbox"/> Байгалийн гамшгийн эрсдэл ихтэй	Өнөөг хүртэл томоохон зудын хохирол амссан байгаль цаг уурын эрсдэл өндөр бүс нутаг
b) Малчдын мэдээлэл хүлээж авах арга хэрэгсэлийн нөхцөл байдал, малчдын үзэл бодол	Малчдын хоршооны үйл ажиллагаа идэвхтэй, малчид хамтарч ажилладаг.
<input type="checkbox"/> Мал нядалгааны үйлдвэрийн нөхцөл байдал	Судалгаанд хамрагдсан аймгийн сумдад мал нядалгааны газар ихэвчлэн байхгүйн учраас сонгох шалгуур үзүүлэлт болоогүй.
d) Аймгийн засаг захиргааны үзэл бодол, тогтвортой хариуцах бүтэц зохион байгуулалт, төсвийн байдал	Аймгийн захиргааны зүгээс аймгийн ХХААГ-ын мал аж ахуйн албаны мэргэжилтэн нарын саналыг авсан.

Эх сурвалж: Судалгааны баг

Ийнхүү Дундговь аймгаас Адаацаг, Гурвансайхан сум, Говь-Алтай аймгаас Бигэр, Цогт сумыг сонгосон. Хүснэгт 1-5-д судалгаанд хамрагдсан сумын хоршооны үйл ажиллагааг нэгтгэв. Мөн Хүснэгт 1-7 болон Хүснэгт 1-8-д аймаг тус бүрийн малын хорогдлын хэмжээ, бүртгэлтэй хоршоо, аж ахуйн нэгжийн тоог нэгтгэн үзүүлэв. Үүнээс үзэхэд 2020-2021 оны байдлаар малын хорогдлын хэмжээ хамгийн их байгаа нь Дундговь аймгийн Гурвансайхан сум, Говь-Алтай

аймгийн Цогт сум байна. Цогт сумын хоршооны тоо аймгийн хэмжээнд хамгийн олон байна. Дундговь аймгийн Адаацаг сумын малын хорогдлын хэмжээ аймгийн хэмжээнд хамгийн цөөн ба хоршоо болон аж ахуйн нэгжийн тоо ч цөөн байна. Гэсэн хэдий ч Хүснэгт 1-6-д үзүүлсэнчлэн 2014 онд улсын тэргүүний хоршоогоор шагнагдсан гэх мэт хоршооны үйл ажиллагаа идэвхтэй байна. Говь-Алтай аймгийн Бигэр сумын малын хорогдлын хэмжээ их биш боловч аж ахуйн нэгжийн тоогоор аймагтаа 3-т ордог ба Хүснэгт 1-6-д үзүүлсэний дагуу мах үйлдвэрлэл, жимс жимсгэний тариалалт, дарс үйлдвэрлэл түлхүү хөгжсөн байна.

Хүснэгт 1-6 Судалгаанд хамрагдсан сумдын хоршооны үйл ажиллагаа

Зорилгот сум	Агуулга
Адаацаг сум	<ul style="list-style-type: none"> Өвс бэлтгэл болон малын гаралтай түүхий эд буюу арьс шир, ноос цуглуулах, борлуулах зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ба 2014 онд улсын тэргүүний хоршоо шагнал авсан⁵.
Гурвансайхан сум	<ul style="list-style-type: none"> Хоршоо нь малчдаас мал авч УБ хотын махны компанид гэрээтэй нийлүүлж борлуулдаг. 2021оны элсэн шуурганаар аймаг дотроо хамгийн олон мал хорогдсон сумын нэг бөгөөд зуд зэрэг байгаль цаг уурын гамшиг, эрсдэл ихтэй нутаг юм.
Бигэр сум	<ul style="list-style-type: none"> Мах үйлдвэрлэлийн хэмжээ өндөр, жимс жимсгэнэ тариалдаг, вино үйлдвэрлэдэг зэрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас бэлчээрийн доройтол тулгамдаж буй асуудлын нэг болсон.
Цогт сум	<ul style="list-style-type: none"> Бүртгэлтэй хоршооны тоогоороо улсад хамгийн олон. Ялангуяа ямааны тоо толгой олон сум юм.

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 1-7 Дундговь аймаг дахь малын тоо толгой хорогдсон байдал

Сумын нэр	Малын хорогдлын хувь	Тоо	
	2020/2021	Хоршоо	ААН
Дэлгэрцогт	81%	1	29
Дэрэн	82%	5	25
Говь-Угтаал	79%	7	31
Цагаандэлгэр	85%	2	26
Баянжаргалан	77%	2	50
Өндөршил	88%	9	48
Гурвансайхан	76%	3	47
Өлзийт	87%	6	49
Хулд	92%	6	54
Луус	90%	2	40
Дэлгэрхангай	80%	6	34
Сайхан-Овоо	86%	10	46
Эрдэнэдалай	87%	6	56
Адаацаг	92%	3	44
Сайнцагаан	84%	33	721


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Судалгааны баг

⁵ <https://news.mn/r/688082/>

Хүснэгт 1-8 Говь-Алтай аймаг дахь малын тоо толгой хорогдсон байдал

Сумын нэр	Малын хорогдлын хувь		Тоо	
	2020/2021	Хоршоо	ААН	
Алтай	67%	3	41	
Баян-Уул	103%	2	41	
Бигэр	87%	3	55	
Бугат	82%	5	41	
Дарви	103%	3	31	
Дэлгэр	94%	6	69	
Жаргалан	94%	7	35	
Тайшир	87%	2	28	
Тонхил	100%	2	37	
Төгрөг	91%	5	31	
Халиун	89%	7	36	
Хөхморьт	105%	2	32	
Цогт	77%	12	69	
Цээл	91%	4	42	
Чандмань	86%	8	53	
Шарга	93%	4	44	
Эрдэнэ	83%	4	30	
Есөнбулаг	95%	11	796	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Судалгааны баг



Дундговь аймаг

Говь-Алтай аймаг

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 1-4 Судалгаанд хамрагдсан сумын байршил

1.5.4 Судалгаанд хамрагдсан сумын тухай товч

Хүснэгт 1-9 Судалгаанд хамрагдсан сумдууд

Аймаг	Сум		Байршил
Дундговь	Адаацаг	(Адаацаг)	Аймгийн төвөөс баруун хойд зүгт 120 км
	Гурвансайхан	(Гурвансайхан)	Аймгийн төвөөс зүүн зүгт 75 км
Говь-Алтай	Бигэр	(Бигэр)	Аймгийн төвөөс зүүн урд зүгт 108 км
	Цогт	(Цогт)	Аймгийн төвөөс урд зүгт 187 км

Эх сурвалж: Судалгааны баг

(1) Дундговь аймаг

Дундговь аймаг нь говийн нутгийн хойд хэсэгт оршдог бөгөөд аймгийн хойд хэсгээрээ хуурай хээр тал, өмнөд хэсгээрээ говийн бүс нутагт хамаардаг. 74,690км² талбай нутаг дэвсгэртэй, 47,542 хүн амтай (2021 он). Аймгийн төв болох Мандалговь нь УБ хотоос 260 км зайд, далайн түвшнээс дээш 1,393 м-г оршдог. Аймгийн нийт малын тоо 3.170.000 толгой (2021 он), тариалалтын талбай 471 га (үүнээс тэжээлийн ургамал 195.8 га, үр тариа 35 га, төмс 142.6 га) байна (2020 он). Дундговь аймгийн эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд нүүрс, зэсийн хүдэр, төмрийн хүдэр, хайлуур, жонш зэрэг уул уурхайн ашигт малтмалын нөөц ихтэй.

1) Адаацаг сум

Сумын төв нь аймгийн төвөөсөө баруун хойд зүгт 104 км зайтай ба УБ хотоос 221 км хуурай хээр талын бүс нутагт байрладаг байна. Газар нутгийн хэмжээ 3,309км², 2,794 хүн амтай (2021 он). Нийт өрхийн тоо 804, үүнээс 550 нь малчин өрх байна. 2.540.000 толгой малтай бөгөөд 14000 адуу, 6600 үхэр, 800 тэмээ, 120,000 хонь, 110,000 ямаатай байна (2021 он). Тариалангийн талбай 2.6 га (үүнээс тэжээлийн ургамал 1.8 га, үр тариа 0 га, төмс 0.3 га) байна (2020 он).

2) Гурвансайхан сум

Сумын төв нь аймгийн төвөөс зүүн хойд зүгт 71км, УБ хотоос 322 км бөгөөд голдуу хуурай хээрийн бүсэд байрладаг. Нутаг дэвсгэрийн хэмжээ 5,416км², 2,149 хүн амтай (2021 он). Нийт өрхийн тоо 687 ба үүнээс 510 нь малчин өрх байна. Нийт 228000 толгой малтай (8700 адуу, 4500 үхэр, 2300 тэмээ, 123000 хонь, 89000 ямаа) (2021 он). Тариалангийн талбай төмс 2.6га, (үүнээс тэжээлийн ургамал 1.3 га, үр тариа 0 га, төмс 0.6 га) байна (2020 он).

(2) Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймаг нь Монгол улсын баруун урд зүгт байрладаг ба өмнөд хэсгээрээ БНХАУ-тай улстай хиллэдэг. Аймгийн төв болох Алтай хот нь УБ хотоос 1001 км зайд байрладаг. Далайн түвшнээс дээш 1940 м өндөрт орших ба аймгийн төв хэсгээр 3000м Алтайн нуруу нэвтлэн өнгөрдөг. Монгол улсад газар нутгаараа хоёрт ордог бөгөөд говь болон Алтайн нурууны нэрээр нэрлэгдсэн. Хүн амын дийлэнх нь нуур, гол мөрөнтэй зүүн хойд хэсэгтээ төвлөрөн амьдардаг. Үзэсгэлэнтэй байгальтай хэдий ч газарзүйн онцлогоос шалтгаалан мал аж ахуй эрхлэхэд хамгийн хүндрэлтэй бүс нутаг хэмээн тооцогддог. Нийт нутаг дэвсгэр 141.4 мянган хавтгай дөрвөлжин км, 58,735 хүн амтай (2021 он). Аймгийн нийт малын тоо 2,990,000 толгой (2021 он), газар тариалангийн 1040.7 га (үүнээс тэжээлийн ургамал 117.1 га, үр тариа 410 га, төмс 88.4 га) байна (2020 он).

1) Бигэр сум

Тус сумын төв нь аймгийн төвөөсөө зүүн урагш 108 км, УБ хотоос 960 км зайд байрладаг. Сумын төв нь нутгийн хойд болон өмнөд хэсгээрээ уулсаар хүрээлэгдсэн тэгш тал дээр байрладаг. Нутаг дэвсгэрийн хэмжээ 3,826км², 2,265 хүн амтай. (2021 он). Нийт 655 өрхтэй бөгөөд үүнээс малчин өрх нь 450 байна. Нийт 116000 толгой малтай (адуу 4,400, үхэр 4,600,

тэмээ 2,000, хонь 24,000, ямаа 81,000) (2021 он). Газар тариалангийн талбай 1.5 га (үүнээс тэжээлийн ургамал 0.8 га, үр тариа 0.2 га, төмс 0.3 га) байгаа ба түүнээс гадна жимс жимсгэнэ 12.4 га-д тариалж байна (2020 он).

2) Цогт сум


Сумын төв нь аймгийн төвөөс зүүн урагшаа 188 км, УБ хотоос 1,050 км зайд байрладаг. Сумын хойд хэсгээр Алтайн нуруу үргэлжилдэг. Сумын газар нутаг нь хойноосоо урагш сунаж тогтсон ба өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг. Нутаг дэвсгэрийн хэмжээ 16,618км², 3,568 хүн амтай (2021 он). Нийт 1,044 өрхтэй, үүнээс 720 нь малчин өрх байна. Нийт 222000 толгой малтай (адуу 4,500, үхэр 4,600, тэмээ 3,700, хонь 45,000, ямаа 164,000) (2021 он). Тариалангийн талбай 378.4 га (үүнээс тэжээлийн ургамал 17 га, үр тариа 174 га, төмс 7.1 га) ба түүнээс гадна жимс жимсгэнэ 6.7 га-д тариалж байна (2020 он).

2-р бүлэг Монгол орны уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой өнөөгийн нөхцөл байдал болон арга хэмжээ

2.1 Холбогдох яам агентлаг, засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй бодлого үүрэг зэрэг

2.1.1 Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ)

ХХААХҮЯ нь аж үйлдвэрийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, нөөц баялгийг үр ашигтай ашиглах, импортын бүтээгдэхүүнийг орлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар орлого болон үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх гол зорилготой юм. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамгийн өндөр ач холбогдол бүхий хэлтэс нь Бодлого төлөвлөлтийн газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар юм. Ялангуяа хүнсний мах нийлүүлэлтийн асуудлыг Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцдаг. Зураг 2-1-т ХХААХҮЯ-ны бүтцийг үзүүлэв.




Эх сурвалж: ХХААХҮЯ-ны вэб хуудас⁶

Зураг 2-1 ХХААХҮЯ-ны бүтэц

2.1.2 Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)

БОАЖЯ нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн өсөлт болон нийгмийн хөгжлийг хангах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт хамгаалалт, байгалийн нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангахыг эрхэм зорилго болгодог. Энэхүү үйл ажиллагаатай хамгийн холбоотой байгууллага нь Уур амьсгалын ногоон сангийн үйл ажиллагаа хариуцсан хэлтэс болох Уур амьсгалын өөрчлөлтийн газар юм. Зураг 2-2 БОАЖЯ-ны байгууллагын бүтцийг үзүүлэв.

⁶ <https://mofa.gov.mn/home> (2023 оны 2-р сарын 11)




Эх сурвалж: БОАЖА-ны вэб хуудас⁷

Зураг 2-2 БОАЖА-ны бүтэц

2.1.3 Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ)

УЦУОСМХ-ийн эрхэм зорилго нь шинжлэх ухаанд суурилсан ус, цаг уур, уур амьсгал байгаль орчны судалгаа түүнчлэн урьдчилсан мэдээллээр хангах явдал юм. Энэхүү үйл ажиллагаатай холбоотой хэлтэс нь цаг уурын мэдээллээр хангадаг хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтэс юм. Зураг 2-3-т УЦУОСМХ-ийн бүтцийг үзүүлэв.



Эх сурвалж: УЦУОСМХ -ийн вэб хуудас⁸


Зураг 2-3 УЦУОСМХ-ийн бүтэц

⁷ <https://met.gov.mn/> (2023 оны 2-р сарын 11)

⁸ <https://irimhe.namem.gov.mn/index.php> (2023 оны 2-р сарын 11)

2.1.4 Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)

ОБЕГ нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байгууллага юм. Гамшгийн эрсдлийн удирдлагын газар нь гамшгийн эрсдлийн мэдээллийг нэгтгэж, түгээх чиг үүрэгтэй ба зудын эрсдлийн мэдээллийн чиглэлд энэхүү судалгаатай уялдана. Зураг 2-4-т ОБЕГ-ын бүтцийг үзүүлэв.



Зураг 2-4 ОБЕГ-ын бүтэц

2.2 Зудын урьдчилсан төлөв байлдлын өнөөгийн нөхцөл, түвшин, урьдчилсан мэдээлэл түгээлтийн нөхцөл, зохион байгуулалт

2.2.1 Зарлан мэдээлэх системийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол улсын эрт зарлан мэдээлэл түгээх эрх бүхий байгууллага болох ОБЕГ нь ОБЕГ-ын даргын А/68 (2019 оны 3-р сарын 13) дугаар тушаалд заасан зарлан мэдээлэх системтэй холбоотой зааврын дагуу зуд гэх зэрэг 24 төрлийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрт зарлан сэрэмжлүүлэх мэдээг түгээдэг. Мөн УЦУОШГ нь (Ус, цаг уур, орчны шинжилгээний газар) урьдчилан мэдээлэх хэлтэстэй бөгөөд УЦУОШГ-аас гал түймэр, хөрсний гулсалт, ган гачгийн урьдчилсан мэдээ, хүчтэй салхи шуурга гэх мэт цаг агаартай холбоотой бусад сэрэмжлүүлэх мэдээг бэлтгэдэг. Мэдээллийг УЦУОШГ-аас гаргаж холбогдох яам агентлаг, ОБЕГ, орон нутаг дахь цаг уурын алба, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж малчдад хүргэдэг. Мөн, ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн (ООГХ) газар хөдлөлтийн ажиглалтыг хариуцдаг бөгөөд газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдсэн тохиолдолд ОБЕГ зэрэг төрийн байгууллагуудад цаг алдалгүй мэдээ илгээх үүрэгтэй байдаг.

Энэхүү систем нь 2012~2014 онд бий болсон. Уг систем нь ООГХ-ээс илгээсэн газар хөдлөлтийн мэдээг хүлээн авч нийслэл хотод дуут дохио дуугаргахын зэрэгцээ телевиз, радио, үүрэн холбооны операторуудаар дамжуулан гар утсанд мэдээлэл илгээж иргэд олон нийтэд хүргэдэг. Зудын аюулыг зарлан мэдээлэх системийг тодорхой бүс нутагт турших шатандаа явж байна.

Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо (LTS-2) нь Мерси Кор Монгол олон улсын байгууллагын боловсруулсан систем бөгөөд зайнаас тандан судлах аргаар бэлчээрийн биомассыг тодорхойлох зэргээр зудын эрсдлийг 5 үе шаттай үзүүлэлтээр илэрхийлдэг бөгөөд төсөл дууссаны дараа ОБЕГ-ын зарлан мэдээлэх төвд хүлээлгэн өгсөн. Гэвч 2022 оны 12 сарын

байдлаар зудын эрсдэлийн зургийн мэдээлэл зэрэг зарим мэдээллийн сангийн холбоос ажиллахгүй нэвтрэх боломжгүй байна.

Цаг агаарын гамшгийн талаарх бусад мэдээллийг вэб хуудас, үндэсний радио, телевиз, утас зэрэг төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл болон орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр түгээдэг. Яаралтай өргөн нэвтрүүлгийн систем (EBS) МҮОНТ, UBS телевиз, CBS (Cell Broadcast System) зэрэгт яаралтай зарлан мэдээлэх төвөөс мэдээ илгээдэг. CBS нь иргэдийн гар утсанд мөн мессеж илгээх боломжтой.

Зарлан мэдээллийн дэд бүтцийн хувьд 2020 оны 7-р сарын байдлаар 21 аймагт 256 дуут дохио ажиллаж байгаагийн 44% нь 30-аас дээш жилийн насжилттай байна. Эдгээр дуут дохио нь Орос, Хятад, Солонгос, Японоос ирсэн бөгөөд дуут дохио төхөөрөмж харилцан тохирохгүй, систем нь нэгдмэл бус байна. Эдгээр дохио нь зөвхөн дохиоллын дууг л дамжуулдаг болохоос нарийвчилсан анхааруулга дамжуулдаггүй. Мөн зарлан мэдээлэх систем доголдож мэдээлэл дамжуулах боломжгүй болсон тохиолдолд ачааны машиныг хөдөлгөөнт удирдлагын төв болгон ашигладаг.

2.2.2 Дунд хугацааны урьдчилсан мэдээ



Дунд хугацааны урьдчилсан мэдээгээр УЦУОСМХ нь жил бүрийн 10-р сард зудын эрсдэлийн мэдээлэл гаргадаг. Энэ нь УЦУОСМХ-ийн вебсайт⁹ болон фэйсбүүк, мессеж зэргээр зудын эрсдэлийн зураг хэлбэрээр түгээдэг. Мөн эдгээр зудын эрсдэлтэй холбоотой мэдээллийг телевиз радиогоор цацаж малчдад өргөн хэмжээнд түгээдэг. Зудын эрсдэлийн зургийг боловсруулахдаа дараах 8 хүчин зүйлээр дүгнэж 5 шатлалаар үнэлдэг. (1.Нэн их, 2.Их, 3.Дунд зэрэг, 4.Бага, 5. Хамгийн бага)

- ① Зуны хур тунадас
- ② Бэлчээрийн даац
- ③ Бэлчээрийн ургацын хэмжээ
- ④ Хур тунадасны дундаж
- ⑤ Цасны дундаж хэмжээ
- ⑥ Цасны зузаан
- ⑦ 11-р сарын агаарын температур болон өвлийн хур тунадасны урьдчилсан төлөв
- ⑧ 11-р сарын хур тунадас болон тухайн өвлийн хур тунадасны төлөв байдал

Эдгээр мэдээллээс малчид зуны бэлчээрийн байдал (①、③) болон агаарын температур (⑦) цасны зузаан (⑥) зэргийг түлхүү ажигладаг.

УЦУОСМХ-ээс гаргасан доорхи зудын эрсдэлийн зурагт судалгаанд хамрагдсан 4 сумыг улаанаар дугуйлсан ба 2021 оны 1-р сарын байдлаар бүгд “Нэн их эрсдэлтэй” (тод хүрэн) ангилалд хамрагдсан байна. (Зураг 2-5 дээд тал) Харин 2022 оны 12-р сард Говь-Алтай аймгийн Цогт сумын хойд хэсэг "Нэн их", Бигэр сум "Дунд (шар)", Дундговь аймгийн хоёр сум "Хамгийн бага (саарал)" эрсдэлтэй гэж гарсан байна. (Зураг 2-5 доод талд). Ийм байдлаар зудын эрсдэлийн зургийн мэдээллийг тухайн жилийн нөхцөл байдлын дагуу шинэчилж боловсруулдаг.

⁹ <http://tsag-agaar.gov.mn/eng>




Дээд талын зураг: 2021 оны 1-р сар/Доод талын зураг 2022 оны 12-р сар
 Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 2-5 УЦУОСМХ-ээс гаргадаг зудын эрсдэлийн зураг

2.2.3 Богино хугацааны урьдчилсан мэдээ

УЦУОСМХ нь зудын эрсдэлийн зургийг жил бүрийн 11-р сард гаргаж өвлийн нөхцөл байдалд үндэслэн шинэчилдэг. Эдгээр шинэчлэгдсэн мэдээллийг богино хугацааны урьдчилсан мэдээ болгон дамжуулдаг. Богино хугацааны урьдчилсан мэдээг аймгийн цаг уурын албаны фэйсбүүк хуудас болон цахим хуудсаар дамжуулан түгээдэг. Зураг 2-6-д 2022 оны 10-р сарын 20-ноос 2022 оны 12-р сарын 1 хүртэлх зудын эрсдэлийн зураг шинэчлэгдэх байдлыг харуулж байна.



Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 2-6 удын эрсдэлийн зураг шинэчлэгдэх байдал

2.2.4 Шуурхай мэдээ

Цаг агаарын онцгой нөхцөлд шуурхай мэдээ мэдээлдэг. Шуурхай мэдээг дамжуулахдаа утсаар залгах болон мессеж илгээх мөн фэйсбүүкийн группийг ихээхэн ашигладаг. Шороон шуурга зэрэг онцгой байдлын шуурхай мэдээллийг аймгийн цаг уурын албанаас илгээж, аймгийн цаг уурын алба → аймгийн онцгой байдлын газар → сумын Засаг дарга → Малчид гэсэн дарааллын дагуу хүргэж байна.


2.3 Бусад урьдчилсан төлөв байдлын систем

2.3.1 PRISM

“PRISM” нь WFP -ийн боловсруулсан нээлттэй программ хангамж бөгөөд дэлхийн 80 гаруй оронд хэрэглэгддэг ба тэр дундаа Индонез, Шри-Ланка, Камбож, Монгол улсад идэвхтэй ашиглагддаг. Энэ нь эрсдэлийг газрын зураг дээр илэрхийлж, хараад ойлгох боломжтой систем юм. Зудын эрсдэлийг хүн ам, цаг агаарын нөхцөл зэрэг хүчин зүйл дээр үндэслэн дөрвөн үе шаттайгаар харуулсан (Зураг 2-7).

Гэвч харамсалтай нь зудын эрсдэлийн зураг зэрэг зарим холбоосууд одоогоор ашиглагдах боломжгүй байна. Үүний шалтгаан нь PRISM-ийн зарим функцэд асуудал гарч програмыг засварлах шаардлагатай болсон боловч дотоодод ашиглагдаж байгаа “Perl” програмчлалын хэлийг мэддэг боловсон хүчин байхгүйн улмаас залруулах боломжгүй байгаа нь тодорхой болсон.

Дашрамд дурдахад Монгол улсад хамгийн олон програмисттай програмчлалын хэл бол "JAVA" (IT Park-аас) юм.



Эх сурвалж: PRISM-ийн вэб хуудас¹⁰

Зураг 2-7 PRISM-ийн дэлгэц¹¹

2.4 Монгол орны мэдээлэл холбооны технологийн өнөөгийн нөхцөл байдал

2.4.1 Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) 2021 оны статистик мэдээллээр МонголХарилцаа холбооны дэд бүтцийн нөхцөл байдал

Улсад мэдээллийн технологийн нэвтрэлтийн түвшинг дараах байдлаар мэдээлжээ.

Хүснэгт 2-1 Монгол улсын мэдээллийн технологийн нэвтрэлтийн түвшин

Мэдээлэл Холбооны Технологи	Нэвтрэлтийн түвшин
Мобайл сүлжээний хүн амын хамрах хүрээ	100%
4G сүлжээний хамрах хүрээ	99%
Гар утасны нэвтрэлтийн түвшин	80%
Гэрээсээ интернетэд нэвтрэх хурд	80%
Дээрхтэй ижил (орон нутагт)	25%
Өрхийн компьютер эзэмшиж буй үзүүлэлт	33%
Нэг хүнд ногдох гар утас эзэмших хувь	140%
Нэг хүнд ногдох өндөр хурдны гар утас ашиглалтын хувь	116%
Интернет хэрэглэгчийн хувь (2021)	84%
Сошиал сүлжээний үйлчилгээ ашиглагчдын үзүүлэлт	86%
Мобайл сүлжээний татаж авах дундаж хурд	16.53MBPS
Сошиал сүлжээний үйлчилгээ ашиглагчдын үзүүлэлт (13 наснаас дээш)	117.7%
Банкны данс эзэмшигчдийн хувь	93%
Кредит карт эзэмшигчдийн хувь	3.2%

Эх сурвалж: ITU -ын тайланд үндэслэн судалгааны баг бэлтгэв.

¹⁰ <https://prism-mongolia.org/?hazardLayerIds=DzudRiskMap>

¹¹ prism-mongolia.org

Монгол Улсад харилцаа холбооны дөрвөн компани байдгаас Мобиком, Юнител компаниудын хэрэглэгчийн хувь өндөр байна (Хүснэгт 2-2). Хамгийн том компани болох Мобиком (Японы KDDI зэрэг компаниудын хөрөнгө оруулалттай) нь хот суурин газарт дийлэнх хувийг эзэлдэгээс улсын хэмжээнд зах зээлд өндөр байр суурь эзэлдэг ба Юнител/Жи-мобайл нь малчдад хөдөө орон нутагт илүү олон хэрэглэгчтэй байдаг байна.

LTE (4G) үйлчилгээ 2016 онд нэвтэрч эхэлсэн бөгөөд LTE-д нийцэх шинэ суурь станцуудыг дэс дараатайгаар нэвтрүүлж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэдээлснээр 2022 оны эцэс гэхэд бүх сум, багийн төвүүдэд 3G, 4G үйлчилгээгээр хангагдсан байгаагийн зэрэгцээ үүрэн холбооны оператор компани бүр 3G, 4G үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжтой болж байна.

Хүснэгт 2-2 Монгол улсын харилцаа холбооны оператор тус бүрийн

хэрэглэгчийн эзлэх хувийн өөрчлөлт

	Хэрэглэгчдийн тоо (мян)	Мобиком	Юнител	Скайтел	Жи-Мобайл
2018 оны 6-р сар	4,085	37.32%	34.03%	16.51%	11.98%
2019 оны 6-р сар	4,360	38.95%	34.57%	15.44%	11.04%
2020 оны 6-р сар	4,423	37.59%	32.94%	17.67%	11.80%
2021 оны 6-р сар	4,509	37.82%	33.49%	17.81%	10.87%
2022 оны 6-р сар	4,750	38.66%	33.84%	17.04%	10.10%

Эх сурвалж: Монголын Цахилгаан Холбооны Зохицуулах Газар

Дээр дурдсанчлан гар утасны сүлжээний хүн амын хамрах хүрээ 100%, үүнээс 4G сүлжээний хамрах хүрээ 99% байна. Учир нь УБ хот, сумын төв зэрэг хот суурин газрууд илүүтэй хамрагдаж, малчдын суурьшсан бүс нутаг ихэвчлэн хамрагдаж байгаа хэдий ч 2G байгаа кейс их байна. Ялангуяа өвөлжөөний газруудад нэвтрэх боломжгүй байдаг.

Ерөнхийдөө 3G болон 4G-ийн суурь станцууд 5км~20 км радиуст цацдаг бол 2G нь 30 км~ 50 км-ийн радиуст ашиггдах боломжтой байдаг.

Суурь станц болон хамрах хүрээ хоорондын хамаарлыг авч үзвэл хамрах зай нь 10 км, 60 км гэсэн 2 төрөл байх ба аль аль нь 100ш суурь станц суурилуулна гэж тооцоход хэвийн тасалдахгүй байх нөхцөл бий болох талбай нь ойролцоогоор 25,000 км², 860,000 км² (Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 1,560,000 км²) юм. Юнител компани 2023, 2024 онуудад 4G дэмжих 200 антен шинээр барихаар төлөвлөж байгаа хэдий ч өргөтгөх боломжтой хамрагдах талбай хязгаарлагдмал байна. Бусад оператор компаниуд 3G, 4G-ээс гадна 2G-ийн хамрах хүрээг өргөжүүлэхээр 2G суурь станцуудыг суурилуулж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам одоогийн байдлаар 2G үйлчилгээг зогсоох төлөвлөгөөгүй байгаа бөгөөд оператор компаниуд ч мөн 2G үйлчилгээг зогсоох төлөвлөгөө байхгүй байна. Өнөөгийн нөхцөлд малчдын хөдөөгийн бүс нутаг буюу хүн ам цөөтэй хэдий ч утасны сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлж, хэрэглэгчид төдийгүй нийт нутаг дэвсгэрийн хамрах хүрээг 100% болгохын тулд 2G сүлжээг өргөтгөх нэн тэргүүний зорилт гэж үзэж байна (Цахим хөгжил, харилцаа холбооны яам).

2G сүлжээний хувьд дуудлага, мессежийг ямар ч асуудалгүйгээр ашиглах боломжтой хэдий ч ухаалаг гар утасны програм (Play Store эсвэл Apple Store-оос татаж авсан програм) болон вэб дээр өгөгдөл дамжуулахад бэрхшээлтэй байдаг.

2.4.2 Өнөөгийн мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглалтын байдал

Малчдын мэдээлэл хүлээн авах (IT) төхөөрөмж эзэмшиж буйгаас хамгийн өндөр хувьтай байгаа нь телевизор, дараа нь гар утас, ухаалаг утас (Хүснэгт 2-3) байна.

Хүснэгт 2-3 Малчдын мэдээлэл технологийн төхөөрөмж эзэмшилтийн хувь (n=212)

No	Төрөл	Дэлгэрсэн байдал, хувь	Үндсэн зориулалт
1	Телевиз	85%	Цаг агаарын мэдээ хүлээн авахад ашигладаг
2	Радио хүлээн авагч	27%	Цаг агаарын мэдээ хүлээн авахад ашигладаг
3	Суурин утас	21%	Гэртээ ашигладаг суурин утсыг сумын Засаг даргаас мэдээ авахад ашигладаг
4	Гар утас (Ухаалаг гар утаснаас бусад)	79%	Малаа бэлчээхэд биедээ авч явах бөгөөд гэр бүл, найз нөхөдтэй холбоо барихад ашигладаг
5	Ухаалаг гар утас	47%	Аймгийн төв болон сумын төвд очихдоо авч явах бөгөөд Фэйсбүүк болон цаг агаарын аппликэйшн үзэхэд ашигладаг

Эх сурвалж: Судалгааны баг

Хэдийгээр малчдын тал хувь нь ухаалаг гар утас эзэмшдэг ч энгийн гар утас түгээмэл хэвээр байна. Үүний шалтгаан нь харьцангуй сүлжээ сайтай байдгийн дээр батарей ашиглалтын хугацаа урт байдаг.

Ухаалаг гар утас эзэмшигчдийн хувьд хээр бэлчээрт, ялангуяа өвлийн улиралд хэрэглэхэд хүндрэлтэй байдаг талаар малчид хэлж байв. Энэ нь гэртээ сүлжээтэй боловч бэлчээрт сүлжээгүй болдог, батерей амархан дуусдаг, өвлийн хүйтэнд лити-ион батерейны цэнэг зарцуулалт ихсэж, мэдрэгчтэй дэлгэцийн ажиллах чадвар мууддаг гэх мэт шалтгаантай байна. Эдгээрээс шалтгаалан энгийн гар утас хэрэглэхэд амар байдаг боловч нөгөөтэйгүүр ухаалаг гар утастай малчдын тоо нэмэгдэж байна. Судалгаа хийж байх явцад ч энгийн гар утас ашиглахын зэрэгцээ аймгийн болон сумын төв орохдоо ухаалаг гар утсаа авч явж Фэйсбүүк болон цаг агаарын мэдээний аппликэйшн үздэг гэж байв. Малчид хэзээ, хэр удаан хугацаагаар ухаалаг гар утас ашиглаж мэдээлэл хүлээн авдаг талаар тухайн малчин тус бүрийн амьдралын хэв маягаас хамаарч ихээхэн өөр өөр байх тул яг бодитоор ухаалаг гар утсаа хэр хэмжээгээр ашигладгийг уг судалгаагаар тогтоож чадаагүй боловч цаашид ухаалаг гар утас залуучуудын дунд голчлон өргөн ашиглагдах төлөвтэй байна.

Радио хүлээн авагчийг ихэвчлэн гадаа авч явж ашигладаг байсан боловч сүүлийн жилүүдэд гар утасны хэрэглээгээр солигдож хэрэглэгчдийн тоо дөрөвний нэг орчим болтлоо буурчээ.

Малчдын 20 орчим хувь нь жи-мобайлын суурин утас ашигладаг (энэ нь CDMA450 стандартыг ашигладаг бөгөөд Монголд 2G ангилалд багтдаг). Мессеж хүлээн авах боломжтой ба загвараасаа хамаараад монгол хэлтэй ч байдаг. Жи-Мобайл 2G терминалууд нь тусгай стандартын терминалын антен суурилуулснаар үндсэн станцаас 60 км-ээс дээш зайд ч сүлжээ барих боломжтой. Бидний ярилцсан малчны гэрт багийн дарга суурин утас руу залгаж сумын төв дээр судалгаа авах мэдээллийг өгсөн байсан.

Түүнчлэн багийн дарга нь өөрийн багт бүртгэлтэй малчдын утасны дугаарыг аймгийн цаг уурын алба, аймгийн онцгой байдлын албанд мэдээлдэг. Малчдын мэдээллийг сар бүр шинэчилж мессеж илгээхэд ашигладаг. Малчид мессеж, фэйсбүүкээр мэдээлэл хүлээж авсан эсэх нь тодорхойгүй байдаг учраас утас нь өнөөгийн нөхцөлд мэдээлэл зайлшгүй хүрсэн эсэхийг баталгаажуулах боломжтой цорын ганц хэрэгсэл юм.

2.4.3 Мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл

Зудын урьдчилсан төлөв байдлын мэдээллийг дамжуулахад илгээгч талын сервер дээрх орчин ба хэрэглэгчийн ашиглаж байгаа харилцаа холбооны хэрэгсэл (гар утас, ухаалаг утас) дээр ч зохих орчинг бүрдүүлэх шаардлагатай учраас үүнтэй уялдуулан мэдээлэл дамжуулах аргачлалыг тодорхой болгох шаардлагатай.

Үүний тулд хуучин байгаа аппликейшныг ашиглан вэбээр мэдээлэл дамжуулдаг байхаар тооцож байна. Малчдын гар утаснаас ашиглах аппликейшний онцлогуудыг доор тоймлон харуулав. Аппликейшн хөгжүүлснээр ухаалаг гар утасны аппликейшн, вэб програмууд, фэйсбүүк гэх мэт нийтлэг ухаалаг гар утасны аппликейшнүүд, мессеж үйлчилгээ ямар байх талаар харьцуулав. Эдгээрийг бүгдийг гар утасны сүлжээнд суурилсан мэдээлэл дамжуулах платформ болгон ашиглах боломжтой.

Хүснэгт 2-4 Гар утасны аппликейшны харьцуулалт

	Мессеж	Ерөнхий апп (Жишээ нь: фэйсбүүк)	Ухаалаг гар утасны апп	Вэб апп
Илгээх мэдээ	△; Зөвхөн текст. Тэмдэгтийн тоо хязгаартай (url хавсаргаснаар шууд вэб -ийн дэлгэц, зураг дүрс зэрэгтэй линкээр холбогдох боломжтой. Гагцхүү удаан хурдаар нээгдэхгүй байх тохиолдол их)	○; Текст, зураг, дуу, дүрс бичлэг	○;Текст, зураг, дуу, дүрс бичлэг	○; Текст, зураг, дуу, дүрс бичлэг
Мэдэгдэл	○	○	○;Хөгжүүлэх шаардлагатай	△; Зөвхөн нэвтрэх үед
Мессеж уншсан эсхийг баталгаажуулах	○; Хөгжүүлэх боломжтой	○; Хөгжүүлэх боломжтой (фэйсбүүкийн хувьд)	○; Хөгжүүлэх боломжтой	○; Хөгжүүлэх боломжтой
Сүлжээний орчин	○;Бүх гар утасны сүлжээнд ажиллана.	△;2G сүлжээний зарим функц дээр ашиглах боломжтой	△;2G сүлжээнд ашиглах боломжгүй	×;2G сүлжээнд бараг ашиглах боломжгүй
(2 талд) Терминалаас өгөгдөл оруулах	○;Боломжтой (тоо г.м энгийн өгөгдөл, хөгжүүлэх шаардлагатай)	Боломжтой (Сэтгэгдэл ашиглах г.м. Өгөгдөл хувиргахад хэцүү)	○;Боломжтой, (хөгжүүлэх шаардлагатай)	○; Боломжтой, (хөгжүүлэх шаардлагатай)
Гар утас	○;Бүх сүлжээний гар утас (Монголын хувьд жи-мобайлын CDMA450 суурин утас ч орно)	○; Бүх сүлжээний гар утас (Вэб функцтэй бол. Монголын хувьд жи-мобайлын CDMA450 суурин утас болохгүй. Сүлжээний нөхцлөөс хамааран вэб ашиглах боломжгүй)	△; Ухаалаг гар утас (Хязгаартай тохиолдол бий)	○; Бүх сүлжээний гар утас болон PC (Web функцтай тохиолдолд. Жи-мобайлын CDMA450 суурин утаснаас бусад)
Терминал суулгах	○;Шаардлагагүй	△;Шаардлагатай. (Урьдчилад суулгасан байж болно)	×; Үндсэндээ шаардлагатай	○; Шаардлагагүй (хөтөч суулгасан байх)
Гар утасны аппликейшн хөгжүүлэх ачаалал	○;Байхгүй	○;Байхгүй	×;Их (загвар болон үйлдлийн систем бүрд дэмжлэг шаардлагатай)	△; Дунд (хөтөч бүрд дэмжлэг шаардлагатай)

	Мессеж	Ерөнхий апп (Жишээ нь: фэйсбүүк)	Ухаалаг гар утасны апп	Вэб апп
Засвар үйлчилгээ	○;Засвар үйлчилгээ шаардлагагүй	○;Тухайн аппликейшны программын хувилбар шинэчлэлтээс хамаарна	×; Загвар, үйлдлийн систем нэмэх эсвэл үйлдлийн системийн хувилбарыг шинэчлэх үед баталгаажуулах, залруулах шаардлагатай.	△; Хөтчийн хувилбарыг шинэчлэх үед баталгаажуулалт, залруулга шаардлагатай. ”

Эх сурвалж: Судалгааны баг

Одоогийн байдлаар малчдын амьдарч буй нутаг, бэлчээрийн бүсэд 3G ба түүнээс дээш сүлжээний орчин бүрдэнэ гэж үзэхэд хараахан хүндрэлтэй байгаа бөгөөд малчдын эзэмшиж буй энгийн гэр утас ухаалаг гар утаснаас олон байгаа тул мессеж ашиглах нь илүү бодитой харагдаж байна. Мэдээж цаашдаа эдгээр сүлжээний орчин сайжрахын хирээр ухаалаг гар утастай малчдын тоо нэмэгдэх нь тодорхой бөгөөд энэ тохиолдолд ч мессеж илгээх системийг үргэлжлүүлэн тогтвортой ашиглах боломжтой.

2020 оны "Монгол Улсын зудын эсрэг авах арга хэмжээ (Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон дасан зохицох чадавхыг бэхжүүлэх судалгаа (гамшгаас урьдчилан сэргийлэх/Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ), (Мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ/Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ)" хоёр талд аппликейшн санал дэвшүүлж байгаа боловч төхөөрөмж эзэмшиж буй байдал, сүлжээний орчныг харгалзан үзэхэд талаас илүү хувь малчид ашиглах боломжгүй.

2.5 Зудаас бусад цаг уурын гамшиг

2022 оны 3-р сарын 14-нд томоохон хэмжээний шороон шуурга болсон. Элсэн шуурганы улмаас Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Дундговь зэрэг аймагт их хэмжээний хохирол учирсан. Дундговь аймагт есөн малчин нас барж, 300 гаруй мянган мал хорогджээ. Дундговь аймгийн малын нийт тоо 2021 онд 3 сая 170 мянган тоо толгой байсан бол энэ шороон шуурганы улмаас нийт малын 10% нь нэг өдрийн дотор хорогдсон байна. Хэдийгээр шороон шуурга жил бүр болдог ч сүүлийн жилүүдэд ийм хэмжээний гамшиг тохиолдсон нь маш ховор тохиолдол юм. Дундговь аймгийн Онцгой байдлын газарт яаралтай тусламжийн 400 гаруй дуудлага ирсэн бөгөөд есөн малчин амь насаа алдсан байна. Өдөр тутмын мэдээлэл цуглуулах, шуурхай мэдээлэл түгээх, онцгой байдлын үед мэдээлэл дамжуулах зэрэгт багийн дарга маш том үүрэг гүйцэтгэдэг. Ярилцлагад хамрагдсан Гурвансайхан сумын 3-р багийн даргын ярианаас үзэхэд шуурхай мэдээ түгээхийн тулд малчдад шууд утсаар мэдэгдсэн байна. Багийн дарга 250 малчнаас 70-д нь утсаар шууд мэдэгдэж, тухайн утсаар хэлсэн тухайн малчид цаашаа үлдсэн 180 хүнд дамжуулсан. ОБЕГ, ХХААХҮЯ, аймгийн Барилгын хэлтсээс бүрдсэн багийн гамшигийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаагаар мониторингд хамрагдсан малчдын 90 хувь нь шороон шуурганы талаарх мэдээллийг аймгийн Онцгой байдлын хэлтсээс телевиз, мессежээр урьдчилан авсан болохыг тогтоожээ. Мэдээг шуурга болохоос 4 хоногийн өмнөөс илгээж байсан ба гэнэтийн цаг агаарын өөрчлөлтөд ихэнх малчид арга хэмжээ авч чадаагүй, бэлчээрт малтайгаа гарсан малчдын ихэнх нь хохирол амссан байна.

2.6 Цаашид шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлууд

Зудын урьдчилсан төлөв байдлын мэдээ зэрэг дунд болон урт хугацааны урьдчилсан мэдээг янз бүрийн замаар дамжуулдаг бөгөөд илгээгч тал шаардлагатай мэдээллээр бүрэн хангаж

байгаа нь тодорхой байна. Малчид зэрэг хүлээн авагч тал дамжуулж байгаа өгсөн мэдээг өөрийн туршлагадаа үндэслэн дүгнэж ашигладаг. Сүүлийн жилүүдэд ухаалаг гар утасны аппликейшнүүдийн цаг агаарын мэдээний үнэн зөв байдал сайжирч, малчид дүгнэлт хийхэд шаардлагатай мэдээллийн чанар сайжирсан. Хэдийгээр нарийвчлал сайтай бодит мэдээлэл түгээлт сайжирсан ч малчид өөрсдөө арга хэмжээ авах чадавхтай байх эсэх (малчдын судалгаанаас) нь чухал байна. Ийм учраас зудын дунд болон урт хугацааны урьдчилсан мэдээний хувьд урьдчилсан төлөв байдлын нарийвчлалыг сайжруулахаас илүүтэй малчид өөрсдөө эсвэл засаг захиргааны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувилбаруудыг нэмэгдүүлж эрсдэлийн эсрэг чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

Нөгөөтэйгүүр дээр дурдсан элсэн шуурганы хохирлоос харахад богино хугацааны, шуурхай мэдээлэлд дараахь хүндрэлтэй асуудлууд байна.

- ① Яаралтай үед мэдээлэл түгээх янз бүрийн арга зам байдаг ч шийдвэрлэх мөчид малчдад мэдээлэл түгээгч нь багийн дарга буюу хувь хүнээс шалтгаалж байгаа учраас стандартчилагдсан техник дамжуулалтын механизм шаардлагатай байна.
- ② Гар утас нь цаг хугацаа шаарддаг арга хэрэгсэл бөгөөд шуурхай мэдээллийг дамжуулах хэрэгсэл болох тал дээр олон асуудалтай байдаг. Цаашлаад малчдад мэдээлэл дамжуулах боломжтой байсан ч малтайгаа бэлчээрт явах зэргээр гэрээсээ холдсон тохиолдолд гамшгаас шууд зайлсхийх боломжгүй гэх мэт мэдээлэл хүлээж авах тал дээр олон асуудал хөндөгдөж байна.
- ③ Малчдаас хэн нь мэдээлэл хүлээж авсан болон хүлээж аваагүй эсэхийг нягтлах нь одоогийн байдлаар утсаар залгаж тодруулахаас өөр аргагүй бөгөөд ялангуяа өвлийн улиралд олон малчид сүлжээгүй нутагт байдаг.
- ④ Багийн дарга 200 гаруй малчин өрхийг хариуцдаг ч бодит байдал дээр үнэндээ 100 орчим өрхтэй л холбоо барьж чаддаг. Үлдсэн хүмүүст малчид хоорондоо мэдээлэл дамжуулахад найдахаас өөр аргагүй тул хохирол учрахаас өмнө цаг тухайд нь мэдээлэл хүргэх боломжгүй нөхцөл үүсдэг байна.
- ⑤ Мессеж зэргээр нэг талын мэдээлэл дамжуулалт нь хохирлын нөхцлийг тодорхойлох боломжгүй арга хэмжээ авахад хүндрэлтэй байна.

3-р бүлэг Малчдын зудын үед авдаг арга хэмжээ

Малчдын зудаас урьдчилан сэргийлэхэд тохирсон авах арга хэмжээг ойлгож мэдэхийн тулд судалгаа авлаа. Малчдаас авсан судалгаа нь урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд үндэслэсэн ярилцлагын судалгаа болон сэдэвчилсэн бүлгийн хэлэлцүүлгийг судалгаанд хамрагдсан сум тус бүрд явуулав. Малчдын судалгаанд оролцогчид нь сумын тамгын газраас сонгогдсон сумын албан хаагч, сумын төвийн оршин суугч, сумын төвөөс арван километрийн зайнд амьдрагч айл өрх байв. Хүснэгт 3-1 сумын оролцогчдын тоо болон судалгааг зохион байгуулсан өдөр. Зураг 3-1 малчдын судалгаанд оролцож байгааг үзүүлэв. Оролцогчдын тоонд нийт малчин өрхийн 10% орчмыг хамруулав. Цогт сумын хувьд малчин өрхийн тоо олон бөгөөд оролцогчдын тоо нь нийт малчин өрхийн 6.4%-тай дүйх боловч сум орон нутаг нь хойноос урагшаа урт нарийхан газар зүйн онцлог тогтоцтой тул сумын төвийн орших хойд хэсгийн малчид голчилж оролцов. Оролцогчдын дотор сумын төвд оршин суудаг, хүүхдүүддээ малаа өгсөн хүн ч байв. Иймээс, доор үзүүлж буй судалгааны дүнгийн тухайд судалгааны асуултанд хариулт өгсөн хүмүүсийн тоо (n тоо) нь янз бүр байна.

Хүснэгт 3-1 Сумын оролцогчдын тоо болон судалгааг зохион байгуулсан өдөр

Аймаг	Сум	Малчин өрхийн тоо	Оролцогчдын тоо	Зохион байгуулсан өдөр
Дундговь	Адаацаг сум	658 өрх	47 хүн	2022 он 10 сар 25 өдөр
	Гурван сайхан сум	558 өрх	56 хүн	2022 он 10 сар 24 өдөр
Говь - Алтай	Бигэр сум	584 өрх	51 хүн	2022 он 11 сар 3 өдөр
	Цогт сум	909 өрх	58 хүн	2022 он 11 сар 4 өдөр

Эх сурвалж: Судалгааны баг



Адаацаг сум

Гурван сайхан сум

Бигэр сум

Цогт сум

Эх сурвалж: Судалгааны баг


Зураг 3-1 Малчдын судалгаанд оролцож байгаа нь

3.1 Малчдын ахуй амьжиргааны нөхцөл байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, зохицох гэх мэт

3.1.1 Мал аж ахуйг голлосон малчдын аж амьдралын хэв маяг

(1) Бэлчээрт жилд нүүдэллэх тоо давтамж, нүүдлийн зай


Бэлчээрт жилд нүүдэллэх тоо давтамж нь сум тус бүр харилцан адилгүй. (Зураг 3-2) Адаацаг суманд жилд таваас дээш нүүдэллэдэг 17 өрх айл (44%) болон ихэнх нь хамгийн ихдээ 20 удаа нүүдэллэдэг гэж хариулсан малчид ч байсан. Гурвансайхан сумын дийлэнх нь жилдээ 2 удаа нүүдэллэдэг байна. Бигэр сумын ихэнх нь жилдээ 3 удаа нүүдэллэдэг бол Цогт сумын ихэнх нь жилдээ 4 удаа нүүдэллэдэг байна.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-2 Бэлчээрт жилд нүүдэллэх тоо давтамж

Бэлчээрт нүүдэллэх зай Адаацаг сум, Гурвансайхан сум, Бигэр сумын дийлэнх нь 100 км хүрэхгүй байсан бол Гурвансайхан сум, Цогт суманд 1000 км дээш нүүдэллэдэг малчин ч байв. Нүүдлийн хамгийн их зай нь (км) Адаацаг сум, Гурвансайхан сум, Бигэр сум, Цогт сум тус бүр 500, 1500, 280, 1000 байв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-3 Бэлчээрт нүүдэллэх зай

(2) Өвөлжөөтэй эсэх

Адаацаг сум, Гурвансайхан сум, Бигэр сумын ихэнх малчид өвөлжөөтэй бол Цогт сумаас судалгаанд оролцогчдын 39% (33 хүний 13 нь) өвөлжөөгүй гэж хариулсан байна. Цогт сумын урагш хойш уртаашаа сунасан хэлбэр нь малчдын нүүдэллэх зай урт болоход нөлөөлсөн.

Хүснэгт 3-2 Өвөлжөөтэй эсэх

Сум (хариулсан тоо)	Өвөлжөө	
	Байгаа	Байхгүй
Адаацаг (n=32)	32	0
Гурвансайхан (n=43)	43	0
Бигэр (n=43)	41	2
Цогт (n=33)	20	13

Эх сурвалж: Судалгааны баг

(3) Тэжээлийн агуулах

Бигэр сумын судалгаанд хамрагдсан бүх малчид малын тэжээлийн агуулахтай байгаа бол харин Адаацаг сум, Цогт сумын малчдын тал орчим хувь нь, Гурвансайхан сумын малчдын дөнгөж 35 хувь нь л малын тэжээлийн агуулахтай байна.


Хүснэгт 3-3 Тэжээлийн агуулахтай эсэх

Сум (хариулсан тоо)	Тэжээлийн агуулах	
	Байгаа	Байхгүй
Адаацаг (n=32)	18	14
Гурвансайхан (n=43)	15	28
Бигэр (n=43)	43	0
Цогт (n=33)	15	18

Эх сурвалж: Судалгааны баг

3.1.2 Зудаас урьдчилан сэргийлэх мэдээ хүлээн авсан малчдын авах арга хэмжээ

Зудаас урьдчилан таамаглах мэдээ хүлээн авсан малчдын авах арга хэмжээ гэдэгт хариулсан хариултын дотор дийлэнх нь “Тэжээлээ бэлтгэх”, “Малаа махлан зарах”, “Өвөлжөөгөө дулаалах”, “Нүүдэллэн оторт явах” гэжээ (Зураг 3-4). Ялангуяа “Тэжээлээ бэлтгэж базаах” гэдэг нь судалгаанд хамрагдсан бүх сумын 70% дээш малчид зудын эсрэг арга хэмжээний шаардлагатай чухал арга хэмжээ гэж хариулжээ.




Эх сурвалж: Судалгааны баг


Зураг 3-4 Зудаас урьдчилан сэргийлэх мэдээ хүлээн аваад юу хийх вэ

Малчдын зудаас урьдчилан таамаглахад авах арга хэмжээ нь сум тус бүр янз бүр байгаа ч, бүх сумуудын хувьд “Тэжээлээ бэлтгэх” нэгдүгээрт, “Малын тэжээлээ бэлтгэх” нь хамгийн чухал шаардлагатай гэдэг нь тодорхой болж байна. Бусад чиг хандлагаас үзвэл Адаацаг сум, Цогт сумынхан хоёрдугаарт дийлэнх нь “Малаа махлан зарах” нэмбэл талаас илүү хувийг эзэлнэ. Гурвансайхан сум, Бигэр сумынхны хувьд “Малаа нядлаад борлуулах” гэдэг хариултаас илүү гуравдугаарт бичигдсэн “Өвөлжөөгөө дулаалах” гэж олонх нь хариулсан байна. “Нүүдэллэн оторт явах”¹² нэмбэл Адаацаг сумынхны 90 дээш хувь, бусад сумын 50 дээш хувийг эзэлж байна.


¹² Отор гэдэг нь хол газар удаан хугацаагаар малаа маллан нүүдэллэхийг хэлнэ.




① Адаацаг сум (Дундговь аймаг)



② Гурвансайхан сум (Дундговь аймаг)



③ Бигэр сум (Говь-Алтай аймаг)



④ Цогт сум (Говь-Алтай аймаг)

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-5 Зудын урьдчилсан мэдээ хүлээн авсны дараа малчдын хэрэгжүүлдэг арга хэмжээ

3.1.3 Малчдын чухалчлан үздэг зудыг урьдчилан таамаглах мэдээ

Зудыг урьдчилан таамаглахад тодорхойлох хүчин зүйлүүдийн дотор, малчдын эн тэргүүнд чухалчлан авч үздэг хүчин зүйлүүдийн дэс дарааллыг Хүснэгт 3-4 харуулав. Хүснэгтийн дэс дараалал, харьцаа нь, хүчин зүйл тус бүрийн эн тэргүүний гэж хариулсан дэс дугаар, харьцааг харуулж байгаа.

Малчдын чухалчлан авч үздэг зудаас урьдчилан таамаглах хүчин зүйл нь “Бэлчээрийн зуншлагын нөхцөл байдал”, тэгээд “Хур тунадасны хэмжээ” тус бүр 27.1%, 26.4% болсон байна. Мөн “Малын тарга тэвээрэг” тухайд хоёрдугаарт гэж хариулсан хэмжээ 32.3% болсон нь үүнийг ч чухалчилдаг байна. “Малын тарга тэвээрэг” болон “Бэлчээрийн өвсний хэмжээ” аль аль нь нэгдүгээрт гэж хариулсан нь 10 хувийг давж байна. Үүнээс үзвэл малчид зуны бэлчээрийн нөхцөл байдлыг чухалчлан үздэг бөгөөд малын тарга тэвээрэг болон хур тунадасны хэмжээг жишиж үзэх зэрэг туршлагаараа тухайн жилийн өвлийн нөхцөлийг урьдчилан таамагладаг гэж бодож болох нь.

Нөгөөтэйгүүр, малчдаас “урьдчилан сэргийлэх мэдээллийн нарийвчлалыг сайжруулахаас илүүтэйгээр зудын эсрэг авах арга хэмжээг боловсронгуй болгох хэрэгтэй” (малчдаас авсан судалгаанаас) гэсэн санал гарсан. Эрсдэлийн мэдээ нь зохистой арга хэмжээ авахад хэрэг болох ч, малчдын зудын эсрэг авах арга хэмжээг чанаржуулахад үлэмж нэмэр болох малын тэжээл бэлтгэж төрлийг нь олон болгох, хашаа саравчаа сайжруулахад чиглэсэн, үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 3-4 Зудыг урьдчилан таамаглахад тодорхойлох хүчин зүйлүүдийг малчдын хувьд эн тэргүүнээр нь дугаарласан байдал (n=208¹³)

Байр	Бэлчээрийн зуншлагын нөхцөл байдал	Малын тарга тэвээрэг	Малын нөхцөл байдал	Бэлчээрийн өвсний хэмжээ	Хур тунадас	Агаарын хэм	Гангийн урьдчилсан мэдээ	Цасны хэмжээ	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ агаарын хэм	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ цасны хэмжээ	Бусад
1	27.1%	11.4%	1.4%	15.7%	26.4%	0.7%	2.1%	4.3%	5.7%	5.0%	0.0%
2	11.3%	32.3%	4.8%	22.6%	16.1%	0.0%	1.6%	3.2%	4.0%	4.0%	0.0%
3	15.6%	11.5%	15.6%	21.3%	12.3%	5.7%	8.2%	4.9%	4.9%	0.0%	0.0%
4	18.2%	10.7%	12.4%	12.4%	16.5%	7.4%	9.9%	6.6%	3.3%	2.5%	0.0%
5	5.4%	9.8%	16.3%	9.8%	8.7%	12.0%	17.4%	8.7%	6.5%	5.4%	0.0%
6	6.8%	13.7%	6.8%	2.7%	2.7%	15.1%	16.4%	20.5%	11.0%	4.1%	0.0%

Эх сурвалж: Судалгааны баг

¹³ Малчдын судалгаа хийсэн 4 сумын нийт тооноос тооцож нэгтгэв. Малгүй зарим хэсэг оролцогч байсан тул судалгаанд оролцсон хүний тоо (n=212) ба авсан судалгааны тоо (n=208)-ны хооронд зөрүү үүсч байна.

3.2 Малчдын мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл

3.2.1 Мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл

Малчдын хувьд цаг агаар, гамшгийн мэдээ нь агуулгаасаа хамаараад, дунд болон урт хугацааны урьдчилан сэргийлэх, богино хугацааны урьдчилан сэргийлэх, яаралтай урьдчилан сэргийлэх гэж 3 төрөлд хуваадаг. Хүснэгт 3-5

Хүснэгт 3-5 Малчдын мэдээлэл хүлээн авах, дамжуулах хэрэгсэл

	Дунд болон урт хугацааны урьдчилан сэргийлэх	Богино хугацааны урьдчилан сэргийлэх	Яаралтай урьдчилан сэргийлэх
Урьдчилан сэргийлэх хугацаа	3 сарын өмнө	1 сарын өмнө	7 хоногийн өмнө
Агуулга	Зудын эрсдэлийн зураглал гаргах	Зудын эрсдэлийн зураглал шинэчлэх	Цаг агаарын гэнэтийн өөрчлөлт
Дамжуулагч	Зурагт, радио	Зурагт, радио цахим хуудас, ухаалаг утасны апп Facebook	SMS Утас FB Хуудас Аймгийн ЦУОШГ, ОБА
Дамжуулах хэрэгсэл	Зурагтын малчдын суваг болон радиогийн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ (өдөр бүрийн үдээс хойш 3 цагт) сонсох Багын дарга мэдээний товхмол тараах	Ухаалаг утасны апп (Windy гэх мэт) хандах Аймгийн ЦУОШ Г, малчдын FB группээ шалгах SMS илгээсэн мэдээг хүлээн авах	Аймгийн ЦУОШГ, ОБА SMS ээр мэдээг багын даргад илгээх. Багын дарга малчин бүртгэй утсаар холбоо барих. Мэдээлэлийг хүлээн авсан малчид мессеж болон утсаар таньдаг малчдад мэдээллийг дамжуулан түгээх.

Эх сурвалж: Судалгааны баг



Зүүн: Адаацаг сумын даргын илгээсэн аймгийн ОБГ-аас ирсэн мессеж

Баруун: Гурвансайхан сумын малчдын ухаалаг утасны апп

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-6 Малчдын мэдээлэл хүлээн авсан, дамжуулсан жишээ

3.2.2 Малчдын мэдээлэл хүлээн авах арга

Малчид дараах байдлаар мэдээлэл хүлээн авдаг. Мөн малчид харилцан хоорондоо ихэвчлэн утсаар мэдээлэл солилцдог. Утсаар холбогдох боломжгүй үед хувийн ажлаар сумын төв орохдоо Фэйсбүүкт орох, сумын төвд танил талаасаа мэдээлэл авах гэх зэргээр мэдээлэл хүлээн авдаг.


Хүснэгт 3-6 Малчдын мэдээлэл хүлээн авах арга

No	Мэдээлэл дамжуулах хэрэгсэл	Дунд, урт хугацаа	Яаралтай	Хүлээн авах арга
1	Зурагт, радио	○	○	Хуваарьт цаг агаарын мэдээ, малчдын суваг зэргийг сонсох
2	Бичгээр	○		Багийн даргын тараасан материалыг хүлээн авах
3	Утас (Утсаар ярих)		○	Багийн дарга малчин бүрд, малчид хоорондоо аймаг дотроо холбогдох. Холбогдох хэрэгсэл нь гэрийн суурин утас, малчдын гар утас, ухаалаг утас.
4	SMS	○	○	Аймгийн ЦУОШГ, ОБГ, багын даргаас хүлээн авах. Холбогдох хэрэгсэл нь гэрийн суурин утас, малчдын гар утас, ухаалаг утас.
5	Facebook	○	○	Аймгийн ЦУОШГ, ОБГ илгээх.

Эх сурвалж: Судалгааны баг

3.2.3 Малчдын мэдээлэл хүлээн авах хэрэгслийг эзэмшиж буй байдал

Судалгаанд оролцсон малчдын 50 хувиас дээш нь гар утас эзэмшдэг. (Зураг 3-7) Онцгойлон Дундговь аймгийн Гурвансайхан сумын малчдын 83% гар утас эзэмшдэг. Ухаалаг утас эзэмшдэг хувь нь 36% - 57% байна. Суурин утас эзэмшдэг хувь нь ухаалаг утаснаас бага, Говь-Алтай аймгийн Цогт сумын 3 хувиар хязгаарлагдаж байна.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-7 Малчдын мэдээлэл хүлээн авах хэрэгсэл (2022 оны 11 сар)

3.3 Малчдын орлого

3.3.1 Эдийн засгийн байдал

(1) Орлого, зарлага

Нэг өрхөд ноогдох орлого нь (борлуулалтын хэмжээ) бүтээгдэхүүн тус бүрийн харьцаа “Мал, мах” өндөр хувьтай, удаад нь “Ноолуур” байна (Хүснэгт 3-7). Говь-Алтай аймгийн Бигэр сумын хувьд “Ноолуур”-ын борлуулалтын хэмжээ нь “Мал, мах”-наас илүү өндөр байна. Борлуулалтын орлогод “Сүү, сүүн бүтээгдэхүүн”-ий эзлэх хувь нь аль ч суманд 8 хувиас бага байна.

Зардал (үйл ажиллагааны зардал)-д хамгийн их хувийг эзэлж байгаа нь “Түлш шатахууны зардал” бөгөөд удаах нь “Өвс тэжээл худалдаж авах” болон “Зээлийн хүү” орж байгаа ч Бигэр сумын хувьд эсрэгээр байна (Хүснэгт 3-8).

Нийт орлогоос зардлыг хасаад жилийн орлого 10,700,000 - 13,200,000 төгрөг, сард хуваавал 890,000 - 1,100,000 төгрөг болж байна (Хүснэгт 3-9). Энэ нь тухайн орон нутгийн төрийн албан хаагчийн сарын цалин болох 500,000 - 600,000 төгрөгтэй харьцуулбал өндөр байгаа юм.

Малчдын орлого бол мал болон мал аж ахуйн бүтээгдэхүүнээс хамааралтай, тэдгээрийн үйлдвэрлэлийн хэмжээ нь байгалийн гамшгийн эрсдэлээс шалтгаалан гэнэт буурах, зардал нэмэгдэх зэрэг тогтворгүй байдал нь асуудал дагуулдаг.

Хүснэгт 3-7 Сум тус бүрийн малчин өрхөд ноогдох нийт орлого

Сум (хариулсан хүний тоо)	Нийт орлого (борлуулалтын хэмжээ) дээд эгнээ: мөнгөн дүн (мян.төг), доод эгнээ: эзлэх хувь (%)				
	Нийт	Мал, мах	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Ноолуур	Бусад мал аж ахуйн бүтээгдэхүүн
Адаацаг (n=44)	18,358 100%	9,544 52.0%	985 5.4%	7,257 39.5%	571 3.1%
Гурвансайхан (n=52)	17,325 100%	9,363 54.0%	1,200 6.9%	5,935 34.3%	827 4.8%
Бигэр (n=44)	15,647 100%	7,734 49.4%	1,120 7.2%	6,625 42.3%	169 1.1%
Цогт (n=43)	15,193 100%	6,278 41.3%	968 6.4%	7,654 50.4%	293 1.9%

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 3-8 Сум тус бүрийн малчин өрхийн зардал (үйл ажиллагааны зардал)

Сум (хариулсан хүний тоо)	Зардал (үйл ажиллагааны зардал) дээд эгнээ: мөнгөн дүн (мян.төг), доод эгнээ: эзлэх хувь (%)						
	Нийт	Өвс, тэжээл	Мал эмнэлэг, эм	Шатахуун	Дулаалга, түлш	Малын даатгал, малын татвар	Зээлийн хүү
Адаацаг (n=44)	5,154 100%	1,340 26.0%	316 6.1%	1,555 30.2%	754 14.6%	272 5.3%	916 17.8%
Гурвансайхан (n=52)	6,308 100%	1,866 29.6%	202 3.2%	2,558 40.6%	376 6.0%	263 4.2%	1,044 16.5%
Бигэр (n=44)	4,951 100%	1,204 24.3%	403 8.1%	1,078 21.8%	863 17.4%	261 5.3%	1,142 23.1%
Цогт (n=43)	4,036 100%	1,023 25.3%	113 2.8%	1,050 26.0%	685 17.0%	283 7.0%	883 21.9%

Эх сурвалж: Судалгааны баг

Тэмдэглэл: Зээлийн хүү нь жилийн 18 хувиар тооцов.

Хүснэгт 3-9 Сум тус бүрийн малчдын жилийн орлого

(нэгж: мян.төг)

Сум (хариулсан хүний тоо)	Жилийн орлого (нийт орлого-зардал)
Адаацаг (n=44)	13,203
Гурвансайхан (n=52)	11,017
Бигэр (n=44)	10,696
Цогт (n=43)	11,157

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Зээл

Малчин өрхийн авдаг зээлийн дүнгийн дундаж хэмжээ нь 5,000,000 – 6,000,000 төгрөг (200-240 мянган иен) бөгөөд ихэнхдээ банкнаас зээл авдаг (Хүснэгт 3-10). Зээлийн хугацаа ойролцоогоор 1-3 жил байдаг ба 2 жилийн хугацаатай зээл нийт зээлийн 54 хувийг эзэлдэг. Малчдын судалгаанаас зээлийн хүү ойролцоогоор жилд 18- 24% байдаг. Зээл авч байгаа зорилго бол дийлэнх нь амьжиргааны зардалд зориулах, удаах нь тэжээлийн зардалд зориулж байна. Бигэр сумын хувьд тэжээлийн зардалтай харьцуулбал сургалтын зардал нь өндөр байна.

Хүснэгт 3-10 Малчин өрхөд ноогдох зээл, зээлдүүлэгч, зээлийн зориулалт

(нэгж: мян төг, %,%)

Сум (хариулсан хүний тоо)	Зээлийн хэмжээ	Зээлдүүлэгч			Зээлийн зориулалт				
		Банк	Хувь хүн	Бусад	Сургалтын зардал	Амьжиргааны зардал	Тэжээлийн зардал	Өвөлжөө	Машин төхөөрөмж
Адаацаг (n=44)	5,091	100%	0%	0%	11%	44%	35%	9%	2%
Гурвансайхан (n=52)	5,798	100%	0%	0%	12%	44%	30%	11%	2%
Бигэр (n=44)	6,345	90%	8%	3%	26%	37%	22%	11%	4%
Цогт (n=43)	4,906	100%	0%	0%	16%	49%	21%	9%	5%

Эх сурвалж: Судалгааны баг

3.3.2 Малын борлуулалтын нөхцөл байдал

(1) Малын тоо толгой

Судалгаанд хамрагдсан сум тус бүрийн өрхийн малын тоо толгой, аль ч сумын хонь, ямаа нь нийт малын 90 орчим хувийг эзэлж байна (Хүснэгт 3-11). Адаацаг сум, Гурвансайхан сумын хонь, ямааны тоо толгой ойролцоо, ямаанаас илүү хонины тоо толгой бага зэрэг их байна. Бигэр сум болон Цогт сумын хониноос илүү ямааны тоо толгой олон, ямаа нь хониноос бараг хоёр дахин илүү олон байна. Энэ нь Бигэр сум болон Цогт сум нь Алтайн нуруунд оршдог тул, уулархаг газраар бэлчихдээ сайн ямааны тоо толгой ихэссэн гэж үзэж болно. Мөн Дундговь аймаг, Говь - Алтай аймгийн тээврийн нөхцөл байдал ялгаатай, Говь - Алтай аймагт махаа хөлдөөхгүй бол тээвэрлэх боломжгүй зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн. Адаацаг сумын адууны тоо толгой нь бусад сумуудтай харьцуулахад их байна. Энэ нь Адаацаг сум бусад сумдаас илүү хойд зүгт оршдог нь, ойт хээрийн бүстэй ургамал нь төстэй тул, адуу өсгөн үржүүлэхэд тохиромжтойг харуулж байна.

Хүснэгт 3-11 Сум тус бүрийн малчин өрхөд ноогдох эзэмшиж буй малын тоо толгой, малын төрөл харьцаа

(нэгж: тоо толгой, %)

Сум (хариулсан хүний тоо)	Нийт	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Адаацаг (n=44)	417.6 100.0%	35.1 8.4%	14.1 3.4%	1.4 0.3%	194.2 46.5%	172.8 41.4%
Гурвансайхан (n=52)	380.4 100.0%	9.1 2.4%	10.1 2.6%	0.8 0.2%	200.9 52.8%	159.4 41.9%
Бигэр (n=44)	284.6 100.0%	12.2 4.3%	15.9 5.6%	4.1 1.5%	77.1 27.1%	192.2 67.5%
Цогт (n=43)	357.2 100.0%	6.2 1.7%	10.4 2.9%	3.7 1.0%	126.0 35.3%	214.2 60.0%

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Малаа хэрэглэх, бэлэглэх, борлуулах

Нэг өрхөд ноогдох хувьдаа хэрэглэх малын тоо толгой, хонь 8-10, ямаа бол Адаацаг сум болон Гурвансайхан сум 8-9, Бигэр сум болон Цогт суманд 12-14 байна (Хүснэгт 3-12). Бэлэглэх бол хонь 3 толгой орчим, ямаа 3-6 байна. Борлуулах тоо толгой нь Адаацаг сум болон Гурвансайхан суманд хонь хамгийн олон 33-42, ямаа 19-23 байна. Бигэр суманд бол хонь борлуулах тоо толгой бусад сумуудтай харьцуулахад бага 5 орчим байхад, Цогт суманд 14 байна. Бигэр сум болон Цогт суманд ямаа борлуулах тоо толгой нь олон 26-38 байна. (Хүснэгт 3-12)

Хүснэгт 3-12 Малчин өрхөд ноогдох хувьдаа хэрэглэх, бэлэглэх, худалдах малын тоо

(нэгж: тоо толгой)

Сум (хариулсан хүний тоо)	Адуу			Үхэр			Тэмээ			Хонь			Ямаа		
	Хувьдаа хэрэглэх	Бэлэглэх	Борлуулах	Хувьдаа хэрэглэх	Бэлэглэх	Борлуулах	Хувьдаа хэрэглэх	Бэлэглэх	Борлуулах	Хувьдаа хэрэглэх	Бэлэглэх	Борлуулах	Хувьдаа хэрэглэх	Бэлэглэх	Борлуулах
Адаацаг (n=44)	0.9	0.3	2.2	0.8	0.1	1.5	0.0	0.0	0.0	9.6	3.0	33.0	8.1	2.4	18.8
Гурвансайхан (n=52)	0.5	0.3	0.8	0.4	0.5	1.2	0.0	0.0	0.1	9.5	5.4	41.8	8.7	3.7	22.5
Бигэр (n=44)	0.7	0.9	1.3	1.0	0.6	2.5	0.1	0.0	0.4	7.6	3.9	4.5	12.7	5.5	26.4
Цогт (n=43)	0.2	0.1	0.6	0.7	0.2	0.7	0.1	0.1	0.2	9.9	2.2	13.6	13.9	5.8	37.3

Эх сурвалж: Судалгааны баг

(3) Малаа борлуулах үнэ

Нэг толгой малын борлуулах үнэ, адуу 794,000- 910,000 төгрөг, үхэр 917,000- 1,270,000 төгрөг, тэмээ 950,000-1,166,000 төгрөг, хонь 112,000- 126,000 төгрөг, ямаа 87,000-102,000 төгрөг байна (Хүснэгт 3-13). Нийслэлийн зах зээлийн үнийг гулууз махны нэгжийн үнээс хөрвүүлбэл хонины үнэ 200-250 мянган төгрөг (орон нутагт авсан судалгаагаар), малчдын борлуулах үнэ УБ хотын зах зээлийн үнийн тал орчим хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 3-13 Мал борлуулах үнэ

(нэгж: мян.төг/толгой)

Сум (хариулсан хүний тоо)	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Адаацаг (n=44)	910.0	1,039.3	-	125.2	98.5
Гурвансайхан (n=52)	861.4	1,270.5	1,000.0	118.2	93.8
Бигэр (n=44)	905.6	1,154.5	1,166.7	112.5	102.2
Цогт (n=43)	793.8	916.7	950.0	126.1	87.3

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: Цогт сум гэмээний хариулт байхгүй

Борлуулах үнэ болон малын тоо толгойноос тооцоолон, нэг өрхөд ноогдох борлуулалтын хэмжээнд эзлэх харьцаа малын төрлөөр Адаацаг сум, Гурвансайхан суманд хонь хамгийн олон нийт хэмжээний тал хувийг эзэлж байна (Хүснэгт 3-14). Бигэр суманд үхэр, ямаа нь нийт борлуулалтын 70 хувиас илүүг эзэлж, ямаанаас илүү үхрийн борлуулалтын хэмжээ их байна. Цогт суманд ямааны борлуулалт нийт хэмжээний тал хувийг эзэлж байна.

Хүснэгт 3-14 Малчин нэг өрхөд ноогдох борлуулалтын хэмжээ, харьцаа малын төрлөөр

(нэгж: мян.төг, %)

Сум (хариулсан хүний тоо)	Нийт	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Адаацаг (n=44)	9,544.4	2,002.0	1,559.0	0.0	4,131.1	1,852.2
	100.0%	21.0%	16.3%	0.0%	43.3%	19.4%
Гурвансайхан (n=52)	9,363.1	689.1	1,524.5	100.0	4,939.1	2,110.3
	100.0%	7.4%	16.3%	1.1%	52.8%	22.5%
Бигэр (n=44)	7,734.3	1,177.2	2,886.4	466.7	506.3	2,697.8
	100.0%	15.2%	37.3%	6.0%	6.5%	34.9%
Цогт (n=43)	6,277.9	476.3	641.7	190.0	1,715.1	3,254.9
	100.0%	7.6%	10.2%	3.0%	27.3%	51.8%

Эх сурвалж: Судалгааны баг

(4) Малын төрөл тус бүрээр борлуулдаг газар, борлуулалтын хэлбэр


Малын төрөл тус бүрийн борлуулах газар борлуулах хэлбэрийг Хүснэгт 3-15-д үзүүлэв. Үүний дотор хонь болон ямааны борлуулах газрын талаар Зураг 3-8-д үзүүлэв. Адаацаг сум УБ хотод хамгийн их борлуулдаг бол Гурвансайхан сум аймгийн төвдөө борлуулах нь хамгийн их байна. Говь - Алтай аймгийн Бигэр сум, Цогт сум нь сумын төвдөө хамгийн их борлуулдаг. Борлуулах хэлбэрийн хувьд Адаацаг сум, Гурвансайхан сум ч малаа төхөөрөөд борлуулах нь нийт хэмжээний 90 орчим хувийг эзэлж байгаа бол, Бигэр сум болон Цогт суманд хонио амьдаар нь бас төхөөрөөд борлуулах тоо ойролцоо. Бигэр суманд ямаа 80 орчим хувийг амьдаар нь, Цогт суманд амьдаар нь борлуулах нь төхөөрөөд борлуулахыг багахан давж гарсан байна (Зураг 3-9).

Хүснэгт 3-15 Малын төрөл тус бүрээр борлуулдаг газар болон борлуулах хэлбэр

Малын төрөл	Сум (хариулсан хүний тоо)	Борлуулах газар				Борлуулах хэлбэр	
		УБ	Аймгийн төв	Сумын төв	Бусад	Амьдаар нь	Төхөөрөөд
Адуу	Адаацаг (n=22)	40%	20%	20%	20%	43%	57%
	Гурвансайхан (n=13)	0%	62%	31%	8%	17%	83%
	Бигэр (n=13)	10%	0%	50%	40%	75%	25%
	Цогт (n=5)	25%	0%	75%	0%	50%	50%
Үхэр	Адаацаг (n=14)	46%	23%	7%	23%	29%	71%
	Гурвансайхан (n=10)	9%	45%	18%	27%	10%	90%
	Бигэр (n=9)	0%	0%	78%	22%	75%	25%
	Цогт (n=3)	0%	0%	0%	100%	100%	0%
Тэмээ	Адаацаг (n=5)	20%	0%	0%	80%	100%	0%
	Гурвансайхан (n=1)	0%	100%	0%	0%	0%	100%
	Бигэр (n=6)	0%	0%	83%	17%	67%	33%
	Цогт (n=1)	-	-	-	-	100%	0%
Хонь	Адаацаг (n=28)	65%	23%	4%	8%	23%	77%
	Гурвансайхан (n=32)	3%	63%	22%	12%	10%	90%
	Бигэр (n=7)	0%	14%	57%	29%	50%	50%
	Цогт (n=16)	10%	20%	60%	10%	50%	50%
Ямаа	Адаацаг (n=23)	57%	24%	9%	9%	26%	74%
	Гурвансайхан (n=29)	5%	55%	34%	7%	14%	86%
	Бигэр (n=15)	0%	13%	53%	33%	79%	21%
	Цогт (n=21)	7%	13%	73%	7%	57%	43%


Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: Цогт сум тэмээний хариулт байхгүй



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-8 Хонь, ямаагаа борлуулдаг газар



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-9 Хонь, ямаагаа борлуулдаг хэлбэр

(5) Борлуулалтын улирал болон борлуулалтын зорилго

Хүснэгт 3-16-д малын төрөл тус бүрийн борлуулдаг улирал болон борлуулах зорилгыг, Зураг 3-10-т хонь ямааны борлуулдаг улиралыг үзүүлэв. Борлуулах улирал нь Бигэр сумын хонийг тооцолгүйгээр намар, өвлийн улиралд нийт хэмжээний 70 орчим хувийг эзэлж байна (Зураг 3-10). Бигэр сумын хувьд амьдаар борлуулах нь түгээмэл бөгөөд (Зураг 3-9) борлуулалтын ихэнхийг нь зун хийсэн байна (Зураг 3-16). Гурвансайхан сум, Цогт сум жилийн турш борлуулдаг байна.


Зээлээ буцаан төлөх, өөрсдийн амьжиргааны зардалд нэмэрлэх зорилгоор малаа борлуулах нь нийт хэмжээний 60-аас дээш хувийг эзэлж байна. Бигэр сум хонины борлуулалтын 100 хувийг зээлийн буцаан төлөлтөд зориулсан байна. Адаацаг сум нь 11- 13 хувийг тэжээл авахад зориулсан нь хоршооны тэжээлийн бэлтгэлтэй холбож ойлгож болно.

Хүснэгт 3-16 Малын төрөл тус бүрээр борлуулдаг улирал болон борлуулах зорилго

Малын төрөл	Сум (хариулсан хүний тоо)	Борлуулах улирал					Борлуулах зорилго					
		Хавар	Зун	Намар	Өвөл	Жилийн турш	Сургалтын төлбөр	Зээлийн буцаан төлөлт	Амьжиргааны зардал	Тэжээл бэлтгэл	Төхөөрөмж худалдаж авах	Бусад
Адуу	Адаацаг (n=22)	0%	0%	71%	24%	50%	27%	41%	23%	5%	0%	5%
	Гурвансайхан (n=13)	10%	0%	80%	0%	10%	22%	44%	22%	0%	0%	11%
	Бигэр (n=13)	0%	0%	44%	44%	22%	31%	38%	31%	0%	0%	0%
	Цогт (n=5)	0%	0%	40%	40%	20%	20%	40%	40%	0%	0%	0%
Үхэр	Адаацаг (n=14)	0%	0%	64%	29%	7%	23%	31%	15%	23%	0%	7%
	Гурвансайхан (n=10)	0%	0%	50%	50%	0%	30%	60%	10%	0%	0%	0%
	Бигэр (n=9)	13%	0%	37%	50%	0%	33%	44%	22%	0%	0%	0%
	Цогт (n=3)	0%	0%	0%	100%	0%	67%	0%	33%	0%	0%	0%
Тэмээ	Адаацаг (n=5)	0%	0%	50%	50%	0%	0%	50%	50%	0%	0%	0%
	Гурвансайхан (n=1)	0%	0%	0%	0%	100%	0%	100%	0%	0%	0%	0%
	Бигэр (n=6)	25%	0%	75%	0%	0%	20%	20%	60%	0%	0%	0%
	Цогт (n=1)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хонь	Адаацаг (n=28)	4%	14%	54%	29%	0%	15%	33%	33%	11%	0%	7%
	Гурвансайхан (n=32)	10%	7%	63%	10%	10%	14%	52%	28%	0%	3%	3%
	Бигэр (n=7)	0%	50%	25%	25%	0%	0%	100%	0%	0%	0%	0%
	Цогт (n=16)	0%	6%	38%	38%	19%	21%	28%	43%	0%	0%	0%
Ямаа	Адаацаг (n=23)	5%	18%	50%	27%	0%	4%	22%	43%	13%	9%	9%
	Гурвансайхан (n=29)	0%	19%	52%	15%	14%	8%	50%	38%	0%	4%	0%
	Бигэр (n=15)	0%	10%	20%	70%	0%	25%	75%	0%	0%	0%	0%
	Цогт (n=21)	0%	10%	43%	38%	10%	13%	47%	40%	0%	0%	0%


Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: Цогт сум гэмээний хариулт байхгүй



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-10 Хонь, ямаа борлуулдаг улирал



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-11 Хонь, ямаа борлуулдаг зорилго

(6) Сүү, сүүн бүтээгдэхүүн

Сүүний хувийн хэрэглээ, борлуулах хэмжээний дотор хамгийн их нь Адаацаг суманд айраг, Гурвансайхан суманд ямааны сүү, Бигэр суманд үнээний сүү, Цогт суманд ямааны сүү байна (Хүснэгт 3-17). Бигэр суманд үнээний сүү болон ямааны сүү бараг ижил хэмжээтэй байна. Цогт суманд айраг хувьдаа ихэнхийг нь хэрэглээд борлуулах хэмжээ нь бага байна. Үнээний сүүг борлуулах нь их хувьдаа хэрэглэх нь бага байна. Гурвансайхан сум, Бигэр суманд хонины сүүг борлуулдаггүй байна.

Хүснэгт 3-17 Малчин өрхөд ноогдох сүүний хэрэглээ, борлуулах хэмжээ

(дээд эгнээ: хувийн хэрэглээ, доод эгнээ: борлуулалт) (нэгж: литр)

Сум (хариулсан хүний тоо)	Айраг	Үнээний сүү	Хоормог	Хонины сүү	Ямааны сүү
Адаацаг (n=44)	300.7	34.3	20.2	5.6	76.1
	130.0	21.7	12.7	5.7	65.9
Гурвансайхан (n=52)	87.9	6.2	12.5	1.2	265.5
	71.9	2.3	6.2	0.0	183.3
Бигэр (n=44)	2.2	301.5	57.5	0.0	227.8
	0.0	68.2	40.9	0.0	61.1
Цогт (n=43)	10.6	1.3	0.1	2.2	108.3
	0.9	23.3	2.8	11.6	125.8

Эх сурвалж: Судалгааны баг

Сүүний үнийн тухайд Адаацаг сум, Гурвансайхан суманд айраг илүү үнэтэй, Бигэр сум, Цогт суманд хоормог илүү үнэтэй байна.

Хүснэгт 3-18 Сүүний борлуулах үнэ

(нэгж: төгрөг/литр)

	Айраг	Үнээний сүү	Хоормог	Хонины сүү	Ямааны сүү
Адаацаг (n=44)	4,643	3,137	4,000	3,000	3,727
Гурвансайхан (n=52)	4,571	4,000	3,000	—	4,357
Бигэр (n=44)	2,000	2,700	7,667	—	3,125
Цогт (n=43)	2,450	2,700	4,500	3,500	3,374

Эх сурвалж: Судалгааны баг

(7) Бусад мал аж ахуйн бүтээгдэхүүн

Бусад ихээр борлуулдаг мал аж ахуйн бүтээгдэхүүний хувьд Адаацаг сум, Гурвансайхан сумын хонины ноос, удаах нь ноолуур байна. Бигэр сумын ноолуур хамгийн их, дараа нь хонины ноос, тэмээний ноос байна. Нэгжийн үнэ өндөр нь ноолуур, аль ч суманд килограмм тутамд 100,000 төгрөгийн үнэтэй байна. Дундговь аймаг тэмээний брэндийг хөгжүүлж тэмээний ноосны үнэ Говь- Алтай аймагтай харьцуулахад 2 дахин өссөн байна. Адууны шир, үхрийн шир, хонь ямааны нэхийний нэгжийн үнэ харьцангуй өндөр, малчдын орлогын найдвартай эх үүсвэр болж байна. Хонины нэхийний үнэ хонь, ямааны өлөн гэдэсний үнэтэй ойролцоо, хонины ноосны үнээс өндөр байгаа нь орлогын эх үүсвэр болохуйц бүтээгдэхүүн болгож хөгжүүлбэл зохистой. Нэхийний борлуулалтын хэмжээ болон малын борлуулалтын хэмжээ харилцан өөр өөр байгаа нь амьдаар борлуулсан малын тооноос шалтгаалж зөрүү үүсч байна.

Хүснэгт 3-19 Малчин өрхөд ноогдох бусад мал аж ахуйн бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээ, нэгж үнэ

(дээд эгнээ: борлуулалтын хэмжээ, доод эгнээ: үнэ:төгрөг)

Сум (хариулсан хүний тоо)	Ноолуур (кг)	Хонины ноос (кг)	Тэмээний ноос (кг)	Адууны шир (ш)	Үхрийн шир (ш)	Тэмээний шир (ш)	Нэхий (ш)	Ямааны арьс (ш)	Хонь, ямааны өлөн(ш)
Адаацаг (n=44)	69.2 104,875	120.7 1,597	1.3 7,500	1.0 9,471	0.6 6,233	0.0 -	7.4 2,300	15.3 19,987	14.3 2,245
Гурвансайхан (n=52)	58.9 100,766	158.2 1,395	3.8 10,000	0.3 10,875	0.8 12,250	0.1 8,000	29.7 3,069	20.6 16,952	39.1 2,911
Бигэр (n=44)	72.2 91,758	39.4 1,213	18.0 4,357	0.1 12,200	0.1 15,000	0.1 4,822	1.0 2,847	2.3 14,438	1.5 2,000
Цогт (n=43)	83.3 91,886	82.8 1,147	18.5 5,556	0.1 8,100	0.2 10,500	0.0 -	4.9 1,328	5.6 14,270	5.8 1,058

Эх сурвалж: Судалгааны баг

(8) Тэжээл

Өөрсдөө бэлдсэн тэжээл (хадлан) Бигэр сум хамгийн их, бусад сумууд маш бага байна. Адаацаг сумын бүх тэжээлээ худалдан авдаг. Худалдан авдаг тэжээлийн хамгийн их нь өвс, удаах нь хивэг, ногоон тэжээл зэрэг байна. Үнийн хувьд ногоон тэжээл болон болц дутуу улаан буудай өндөр ч гэлээ хивэг, хорголжин тэжээлийн үнээс онцын ялгаагүй байна. Худалдан авч буй тэжээлийн хувьд, ногоон тэжээл, болц дутуу улаан буудай, хорголжин тэжээл худалдан авсан хэмжээ нь Говь-Алтай аймгийн 2 суманд Дундговь аймгийн 2 сумтай харьцуулахад 10-ны 1-тэй тэнцэх хэмжээтэй байна. Энэ нь Говь-Алтай аймагт улаан буудайн тариалалтын талбай бага байдгаас шалтгаалж байна. Нөгөө талаас, Дундговь аймагт ч мөн улаан буудай тариалдаггүй боловч хөрш зэргэлдээ Төв аймагт 66,008 га талбайд тариалалт хийгддэг тул Говь-Алтай аймаг, Дундговь аймгийн тэжээл худалдан авсан хэмжээ ялгаатай байгаа нь зах зээлээс хэр хол ойр байгаагаас шалтгаалсан байж болзошгүй.

Хүснэгт 3-20 Малчин өрхөд ноогдох тэжээл (өвс)-ийн хэмжээ, худалдаж авсан тэжээлийн хэмжээ болон үнэ

(дээд эгнээ: хэмжээ (кг), доод эгнээ: үнэ (мян.төг/Тонн))

Сум (хариулсан хүний тоо)	Өөрсдөө бэлдсэн тэжээл (хадлан)	Худалдаж авсан тэжээл				
		Өвс	Хивэг	Ногоон тэжээл	Улаан буудай	Хорголжин
Адаацаг (n=44)	0	1,059	402	230	57	104
	-	593	840	1,050	840	823
Гурвансайхан (n=52)	67	1,334	582	327	104	107
	-	671	730	966	1,253	934
Бигэр (n=44)	464	996	455	21	11	14
	-	779	843	888	1,200	938
Цогт(n=43)	75	781	410	17	10	21
	-	803	854	1,009	1,064	828

Эх сурвалж: Судалгааны баг

Тэмдэглэл: Худалдаж авсан үнэ өвс 20кг/боодол, хивэг 25 кг/уут, ногоон тэжээл 20 кг/уут, улаан буудай 25 кг/уут, хорголжин тэжээл 40кг/уутаар тооцов.

3.3.3 “Зудыг урьдчилсан таамаглаад малаа олноор нь төхөөрсний үр дүнд, махны үнэ огцом буурсан” болон “Мал төхөөрөх, түгээлтийн чанарын менежмент муу байгаа нь үнэ бууруулж байна”


Уур амьсгалын ногоон санд хүлээлгэн өгөх CN-д заасан үйл ажиллагаа нь “Нарны эрчим хүч ашигласан мах хөргөж хадгалах систем (PV систем)-ийг нэвтрүүлэх”-ийн урьдаар “Зудаас урьдчилсан таамаг мэдээ хүлээж аваад малаа олноор нь төхөөрсний үр дүнд, махны үнэ огцом буурсан” болон “Мал төхөөрөх болон түгээлтийн чанарын менежмент муу байгаа нь үнэ бууруулж байна” гэсэн нөхцөл байдалтай холбоотойгоор малчдын дасан зохицоход чиглэсэн арга хэмжээ, УБ хотын махны зах зээлийн үнийн судалгааг хийв.

Малчид ердийн үедээ малаа төхөөрч махалдаг харьцаа нь, сүргийн 20-25% байдаг, зудаас урьдчилан сэргийлж малаа төхөөрч махлах харьцаа нь сүргийн 30-35% хүртэл нэмэгддэг байна. Малчдын судалгаанаас зудаас урьдчилан сэргийлэх үед малаа төхөөрч махлах нь нэмэгддэг ч, нэг дор олноор нь төхөөрдөг гэж хэлэхээргүй байна. Мөн зудаас урьдчилан сэргийлж төхөөрсөн малын ихэнх нь, өвлийг давахааргүй тарга тэвээрэг муутай малыг түрүүлж төхөөрдөг. Туранхай малын махны үнэ хямд байдаг (малчдаас авсан судалгаагаар).

Махны захын үнэ ханш, улирлаас шалтгаалан өөрчлөгддөг бөгөөд зун үнэтэй, намар хямд болдог. 2021 оны зудын нөлөөгөөр нас гүйцсэн малын хорогдол 3,010,000 тоо толгой, 2019 онд 112,000 тоо толгой, 2020 онд 2,060,000 гэх мэтээр харьцангуй ихэссэн байна (Статистикийн үндэсний хорооны мэдээнээс). Махны зах зээлийн үнэ ханш 2020 оноос илүү нэмэгдэх хандлага харагдаж байгаа бол, 2021 оны зудын урьдчилсан таамгаар малаа махлан борлуулсан нь, үнэ огцом буурах нөхцөл байдал ажиглагдаагүй (Зураг 3-12).


Зураг 3-13-г үзүүлсний дагуу, гулууз махны жин, худалдан авах үнэ хоорондоо харилцан хамааралтай. Гулууз махны жин хөнгөн туранхай малыг, гулууз махны жин хүнд тарган малыг харьцуулахад үнэ хямд болдог. Мөн 2022 онд зудаас урьтаж баруун аймгуудын нутгаас туранхай мах УБ хотын махны зах зээлд нийлүүлсэн, борлуулах үнэ хэсэгтээ буурсан. Энэ үед зүүн бүс нутгаас тарган мах зах зээлд нийлүүлэхэд, зүүн бүс нутгийн махны үнэ ердийнхөөс үнэтэй болсон (хотын махны ченжийн яриа). Үүнээс үзэхэд малын жин болон малын гарал үүслээс шалтгаалан махны үнэ хэлбэлздэг нь ойлгомжтой байна.

Өнөөгийн Монголын махны зах зээлийн үнэ ханшинд тээвэрлэлтийн хэмжээ ихээхэн нөлөөлж байгаа. Хятад улс өөх багатай туранхай мах авахыг хүсдэг тул тийш нийлүүлэх махны хэмжээ нэмэгдсэн, үнэ хямд мах захад нийлүүлэх болсон тул үнэ хямдрах хандлагатай байгаа. 2020 оноос 2022 он хооронд ковидын нөлөөгөөр Хятад улс руу экспортлох нь хязгаарлагдсан тул зах зээлийн үнэ нь нэмэгдэх хандлагатай байна.



Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо

Зураг 3-12 Махны зах зээлийн үнэ, улирлын өөрчлөлт




Эх сурвалж: Хүчит шонхор захын махны ченж

Зураг 3-13 Гулууз махны жин (кг), худалдаалах үнэ (төг)-ийн харилцан хамаарал

3.4 Малчдын мал борлуулалтад тулгарч буй асуудал


Малчдын мал борлуулалтын асуудал нь, хариултын хамгийн их нь 1) Үнэ хямд тогтворгүй, 2) Шууд худалдан авагч олддоггүй, 3) Хадгалахад хэцүү, 4) Зах зээлээс алслагдсан, тээвэрлэлт хүндрэлтэй, 5) Мэдлэг мэдээлэл дутмаг гэсэн байна. Судалгаанд хамрагдсан сумуудын хариултыг Зураг 3-14-т (1-4) үзүүлэв.




① Адаацаг сум



② Гурвансайхан сум



③ Бигэр сум



④ Цогт сум

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-14 Мал борлуулахад тулгарч буй асуудал

Дундговь аймгийн хоёр сум “Үнэ хямд тогтворгүй” гэж ихэнх нь хариулсан байна. Дараагийн хариулт олон байсан нь Адаацаг суманд “Шууд худалдан авагч олддоггүй”, “Хадгалахад хэцүү” гэсэн байна. Гурвансайхан суманд “Хадгалахад хэцүү” гэсэн байна. Адаацаг сум аймгийн төвөөс 120 км зайтай оршдог, зам нь нарийн даваа гүвээтэй, хэрэглэгчид, тэр дундаа зуучлагчдад шууд борлуулах боломж хомс байгаа нь зах зээлийг хөгжүүлэх, хадгалах хэрэгцээ шаардлага үүсэх шалтгаан болсон гэж үзсэн. Гурвансайхан сум аймгийн төвөөс 75 км зайтай оршдог, зам нь тэгш тал хээр тул нүүхэд харьцангуй хялбар. Гурвансайхан сумын төвийн хоршоо нь малаа цуглуулаад УБ хотын махны компани (Мах импекс ХХК) гэрээ хийсэн тул, зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх шаардлага бага. Хоршоо малаа цуглуулдаг учраас хадгалах тухайд шаардлага их гэж хариулсан байна.

Говь- Алтай аймгийн хоёр сум хоёул “Шууд худалдан авагч олддоггүй” гэж дийлэнх нь хариулсан байна. Ялангуяа Бигэр сум ийнхүү хариулсан нь бүх хариултын талаас илүү хувийг эзэлж байна. Нөгөөтэйгүүр, Дундговь аймагт зонхилж байсан “Үнэ хямд бөгөөд тогтворгүй” гэж хариулсан хүн байгаагүй. Үнийн хувьд асуудалтай гэж үзэхгүй байгаа шалтгааны тухайд, Говь- Алтай аймаг нь УБ хотоос 1000 км зайд оршдог, хот руу махаа борлуулахад тээврийн асуудал гардаг тул махны ченжийн үүрэг их гэж үзэв. Ялангуяа, Цогт сумын хувьд “Мэдлэг мэдээлэл дутмаг” гэж дийлэнх нь хариулсан нь зах зээлийн мэдээлэл харилцаа холбооны хэрэгсэл асуудалтай гэж үзэж болох юм.

3.5 Засаг захиргаанаас малчдад гамшгаас урьдчилан сэргийлэх, дасан зохицох арга хэмжээ авахад үзүүлдэг дэмжлэг, тулгарч буй асуудал

Малын тэжээлийг өвөл хаврын улиралд шаардлагатай хэмжээгээ малчид өөрсдөө бэлтгэдэг ч зудын гамшиг тохиолдсон үед улс, аймаг, сумаас тухайн тэжээлийн нөөцөөс хангалт хийдэг тогтолцоотой. Гамшгийн үед тэжээлийн нөөцөөс малчдад хүсэлтийн дагуу хангалт хийдэг. Сумын хэмжээнд тэжээлийн нөөц дууссан үед аймгийн нөөцөөс хангалт хийж, аймгийн тэжээлийн нөөц дуусвал улсын нөөцөөс хангалт хийдэг. Дундговь аймаг нөөцийн 2 агуулахтай. Тус аймгийн хэмжээнд нөөцөлж буй өвсний хэмжээ нөөцийн 2 агуулах нийлээд жил бүр 10

мянга орчим боодол өвс байна. Тэжээлийн улсын нөөцтэй холбоотой мэдээлэл нууцын зэрэглэлтэй байдаг.



Сумын тэжээлийн агуулах (Гурвансайхан сум)



Аймгийн тэжээлийн агуулах (Дундговь аймаг)



Улсын нөөцийн тэжээлийн агуулах (Мандалговь)

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-15 Тэжээлийн агуулах (Сум, Аймаг, Улс)

4-р бүлэг Мал аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ

4.1 Малчдын махны үйлдвэрлэл, түгээлтийн холбогдолтой төрийн бодлого

4.1.1 Монгол Улсын Засгийн газрын баримтлах чиглэл

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахыг зорьж байна. Ялангуяа, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангаж, чанарын өндөр түвшний мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, уур амьсгал, хүрээлэн буй орчин, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн арга хэлбэрийг хөгжүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын Засгийн газар нь хүнсний аюулгүй байдлын зохицуулалтыг боловсронгуй болгож, УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор “мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх”, “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох” гэсэн чиглэлийг үндэслэн Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-ыг баталсан.

Тус зохицуулалтад худалдах зориулалттай мах, махан бүтээгдэхүүнийг хяналтын байгууллагын бүртгэл, дүгнэлттэй мал төхөөрөх үйлдвэрт боловсруулж, лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээтэй байхаар заасан (Хүснэгт 4-1). Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх бөгөөд 3 жилийн шилжилтийн хугацааны дараа жинхэнэ утгаар хэрэгжүүлэх болно.

Хүснэгт 4-1 "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-аас (шинэ дүрэм)

- | |
|--|
| <p>1.1.1. Энэ техникийн зохицуулалтаар хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлох, импортлоход тавигдах шаардлагыг тогтооно;</p> <p>1.1.2. Энэ техникийн зохицуулалтыг нийтийн хэрэгцээнд зориулан мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө;</p> <p>1.3.4. “мал төхөөрөх үйлдвэр” гэж хяналтын байгууллагын бүртгэл, дүгнэлттэй, хүнсний хэрэгцээнд зориулан мал төхөөрөх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;</p> <p>2.4.3. малын эмч бэлтгэлийн мал бүрд эрүүл мэндийн бүртгэл хөтөлсөн байх.</p> <p>3.4.1. үйлдвэрийн барилга байгууламжийн байршлыг тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаар Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3-т заасны дагуу эрүүл ахуйн дүгнэлт гаргуулсан байх;</p> <p>3.7.1. мах хөргөх, хөлдөөх, хадгалах технологийн шаардлагыг хангахуйц тоног төхөөрөмжтэй байх;</p> <p>4.10.2. хүнсэнд тэнцсэн гулууз мах, дотор эрхтнийг хөргөх өрөөнд богино хугацаанд шилжүүлж, 24-48 цагийн хугацаанд махны гүний температурыг (0-4)⁰C, pH-ийг 5.4-6.0 хүртэл бууруулах,</p> |
|--|

- 4.10.3. Хөлдөөх өрөөний температур -25°C , эсхүл -35°C ,
- 5.2.1. мах боловсруулах үйлдвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны газар нь энэ техникийн зохицуулалтын 1.3.4-т заасан үйлдвэрт бэлтгэсэн, хөргөсөн, эсхүл хөлдөөсөн, мал эмнэлгийн гэрчилгээтэй, шаардлагатай тохиолдолд лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээтэй махыг үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээнд ашиглах;
- 5.2.5. үйлдвэрийн аргаар төхөөрснөөс бусад махны хувьд мал эмнэлгийн гэрчилгээгүй, лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээгүй, импортын махны хувьд лабораторийн шинжилгээний дүн, импортын гэрчилгээгүй тохиолдолд нийтийн хэрэгцээнд нийлүүлэхгүй байх;
- 7.3. Төхөөрөх, боловсруулах үйлдвэрт ажиллах малын эмч, махны технологич, хөргөлтийн инженер нь холбогдох мэргэжлээр их, дээд сургууль төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй байна. Малын эмч нь итгэмжлэлтэй, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх.

4.1.2 Хүнс, мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хууль тогтоомж

Монгол Улсын хүнс, мал аж ахуйтай холбоотой гол хууль тогтоомжийг доор жагсаав.

(1) Хүнсний тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. 2012 онд шинэчилсэн. 11 дүгээр зүйлд хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ХХААХҮЯ), аймаг, нийслэл, дүүрэгт аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хүнсний асуудал хариуцсан төрийн байгууллагын нэгж, сум, тосгонд хүнсний асуудал хариуцсан албан хаагч хэрэгжүүлнэ гэж заасан. Уг хуулинд монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг "стратегийн хүнс" гэж тодорхойлсон. Энэхүү стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална. Уг журмын төслийг ХХААХҮЯ-аас 2012 онд боловсруулж албан ёсны цахим хуудсандаа байршуулсан ч өнөөг хүртэл батлагдаагүй байна. Энэхүү журмын төсөлд аймаг, нийслэлийн Засаг дарга нар тухайн нутаг дэвсгэрийн хүн амын өсөлттэй уялдуулан стратегийн хүнсний хэрэгцээ, нийлүүлэлтийн судалгаа хийж, дараа жилдээ улирал бүрээр нөөцлөх хүнсний нэр төрөл, хэмжээг тодорхойлох, түүний саналыг жил бүр 5-р сарын 1-ний дотор ХХААХҮЯ-д илгээх бөгөөд тус яам эдгээр саналыг нэгтгэн улсын хэмжээний стратегийн хүнсний нөөцийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг нэгтгэсэн нэгдсэн санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, хөрөнгийг тухайн санхүүгийн жилийн орон нутгийн төсөвт тусгах шийдвэрийг хоёрдугаар улиралд багтаан гаргахаар тусгасан. Шийдвэр гарсны дараа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хүнсний нөөц бүрдүүлэх, хүнсний нөөцийн чанар, аюулгүй байдал, хадгалалт, хуваарилалт, нөхөн бүрдүүлэлт зэрэгт хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна. Дээрх журамд хүнсний гол нэрийн бараа, тэдгээрийг нийлүүлэх, хадгалах үүрэг бүхий аж ахуйн нэгж, хүнсний нөөцийг худалдах, түгээхэд тавигдах шаардлагыг тусгажээ.

(2) Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль

Энэ хуулийн зорилго нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 2017 онд батлагдсан уг хууль нь мал, амьтны эрүүл мэнд, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх, нийгмийн эрүүл ахуйг сахих, чөлөөт худалдааг дэмжих харилцааг зохицуулах юм. Мөн мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын тогтолцоо, санхүүжилтийн талаар тусгажээ.

(3) Малын генетик нөөцийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтаны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 2017 онд батлагдсан.

(4) Малын тоо толгойн албан татварын тухай хууль

Энэ хуулийн зорилт нь малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 2020 оны 11-р сард батлагдаж, 2021 оны 1-р сараас мөрдөгдөж эхэлсэн. Малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч болно. Албан татвар ногдуулах малын тоо толгойг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно гэж заасан. Нэг малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байдаг бөгөөд албан татварын хэмжээг тухайн өрхийн харьяалагдах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно. Малчдын амьжиргааг дэмжих зорилгоор ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.

(5) Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль

Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 2004 онд батлагдсан. Энэхүү хуулиар төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих тухай заасан. Мөн мал, махны үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх; мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх; нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх зэрэг үүрэг хариуцлагын талаар тусгасан.

(6) Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль

Энэ хуулийн хүрээнд мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна гэж заасан. Амьтан, ургамал түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журмыг ХХААХҮЯ эсвэл нутгийн захиргааны байгууллага батална. Энэ хуулиар амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход импортлогч улстай тохиролцсон хорио цээрийн нөхцөл, эсхүл хорио цээрийн талаархи Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцсэн байх; экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх талаар заасан.

(7) Генетик нөөцийн тухай хууль

Энэ хуулиар генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэх, хадгалах, хамгаалах зэрэг асуудлыг зохицуулдаг. Мөн мал, амьтан, ургамал, түүхий эд зэргийг хилээр нэвтрүүлэхэд аюулгүй, зохистой орчин бүрдүүлэх, тээвэрлэхээс өмнө холбогдох технологиор цэвэрлэж ариутгах, тээвэрлэхэд тавигдах шаардлага, ариутгал халдваргүйжүүлэлттэй холбоотой дүрэм журмыг гаалийн байгууллага боловсруулж батлах талаар заасан.

(8) Гамшгаас хамгаалах тухай хууль

Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулийг 2017 онд шинэчилсэн найруулгаар баталж, урьдчилсан саргийлэх арга хэмжээг өргөжүүлсэн. Гамшгийн өмнөх үйл ажиллагаагаар гамшгийн эрсдэлийг үнэлэх; гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх; гамшгийн эрсдэлийг бууруулах; гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах; гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх; гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах; гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг тусгасан. Энэ хуулиар “гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох хэмээн тодорхойлсон. Гамшигийн үеийн яаралтай арга хэмжээний хувьд гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах; голомтын бүсийг тогтоох; эрэн хайх, аврах; хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх; гамшгийн хор уршгийг арилгах зэргийг тусгасан. Энэ хуульд гамшгийн үеийн удирдлага, ялангуяа төв болон орон нутгийн удирдлага, онцгой байдлын байгууллагын бүрэн эрхийг нарийвчлан тусгасан.

(9) Улсын нөөцийн тухай хууль

Энэ хуулиар улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориултаар нөөцийн бараа, материалыг ашиглана хэмээн заасан. Нөөцийн барааны худалдан авалтыг тендерийн хуульд нарийвчлан заасан байдаг.

Нөөцийн зарим бараа, материалыг хадгалах стандарт, технологийн шаардлага хангасан агуулах бүхий хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр хадгалуулж болох бөгөөд энэхүү хадгалуулах нөөцийн бараа, материалын жагсаалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Нөөцийн бараа, материалыг хадгалах гэрээнд нөөцийн бараа, материалын чанар, стандарт, хадгалах хугацаа, төлбөр, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанар, талуудын хүлээх хариуцлага, мэдээ тайлангийн талаар тодорхой тусгасан байна.

(10) Хоршооны тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хоршоог үүсгэн байгуулах, хоршооны гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, хяналт, үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд 2021 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан. Хоршоо байгуулахын тулд ес буюу түүнээс дээш оршин суугч шаардлагатай. Хоршоо болон хуулийн этгээд хамтран хоршоо байгуулж болно. Хоршооны гишүүдийн 51 хувийг гишүүд эзлэх ёстой. Хоршооны дүрэмд .хоршооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг; .хоршооны зорилго, үйл ажиллагааны чиглэл; .хоршоонд элсэх, хоршооноос гарах, хасах нөхцөл, журам, хоршооны гишүүний эрх, үүрэг, хариуцлага; хоршооны гишүүний оруулах хувь хөрөнгийн хэмжээ, хугацаа зэрэг асуудлыг тусгах бөгөөд Бүх гишүүдийн хурлаар батална.

(11) Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад орших бөгөөд 2011 онд батлагдсан. Энэ хуулиар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг ХХААХҮЯ батална хэмээн заасан. Үүнтэй холбогдуулан ХХААХҮ-ын сайдын 2013 оны А/35 дугаар тушаалаар уг жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалтад ноолуур, ноос, мал /адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа/, үхрийн мах, хонины мах, ямааны мах, адууны мах, халуунаар боловсруулсан хүнсний мах, арьс шир зэрэг малын гаралтай бүтээгдэхүүнийг хамруулсан.

4.2 Малчдын мах үйлдвэрлэлийн өнөөгийн байдал ба хэрэгцээ

4.2.1 Орон нутаг дахь мах үйлдвэрлэл

Маж үйлдвэрлэлийн жилийн хэмжээ (нийт малын тоо)-ний 2017 оноос 2021 он хүртэлх дундаж нь Дундговь аймагт 20,135 тн, Говь-Алтай аймагт 20,417 тн (Монгол Улсын статистик мэдээ) байна. Сум тус бүрээр харахад, Адаацаг сум 1,559 тн, Гурвансайхан сум 1,444 тн, Бигэр сум 952 тн, Цогт сум 1,478 тн байна (Монгол Улсын статистик мэдээ).

Нэг малчин өрх жилд дунджаар борлуулж буй хонины тоо Дундговь аймагт 50-60, Говь-Алтай аймагт 10-30 толгой байна (малчдын судалгаанаас). Нэг толгой хонины борлуулах үнэ 120,000 төг байгаа ба энэ нь УБ хотод борлуулагдаж буй 250,000 төг-тэй харьцуулахад тавин хувь хямд байгаа болно.

Сүргийн бүтцийн тухай 3.2.2 мал борлуулатын өнөөгийн байдал-д үзүүлсэнчлэн, Дундговь аймагт хонь ямаа нийт сүргийн 90 хувийг эзэлж, тоо толгойн хувьд ижил харьцаатай байна. Говь-Алтай аймагт хонь ямаа мөн ижил нийт сүргийн 90 хувийг эзэлж байгаа бол харьцааны хувьд 4:6 буюу ямааны тоо толгойн эзлэх хувь их байна. Энэ нь Говь-Алтай аймаг зах зээлээс алслагдсан байдаг тул хадгалахад хялбар тээвэрлэлтийн ачаалал бага учир ноолууры түлхүү үйлдвэрлэж, борлуулдагтай холбоотой. Гэхдээ ямааны зах зээлд орох эргэлт нэг жилд ганцхан удаа байдаг бол хонийг хэрэгцээтэй үедээ борлуулах боломжтой учир цаашид нийлүүлэлтийн гинжин хэлхээ сайжирсанаар махны чиглэлийн хонины тоо толгой өсөх магадлалтай (орон нутаг дахь аман судалгаанаас).

Сумын түвшинд хөлдөөгчтэй агуулахтай газар ховор учир, гадаа хадгалах боломжтой сэрүүний улиралд буюу 10 сараас хойш ихэвчлэн малыг нядалж борлуулдаг. Борлуулах малын тоог малчин өөрөө шийдэх ба үүнд сум гэх мэт орон нутгийн захиргаанаас ямар нэгэн удирдамж заавар байхгүй.

Малчдад тулгамдаж буй гол асуудал нь, малчдын дийлэнх нь аймаг болон сумын төвөөс алслагдсан газарт зах зээлээс хол байдаг хэрэглэгчид шууд хүргэх боломжгүй учир борлуулах малын тоо, үнэ тогтворгүй байдаг явдал юм (орон нутаг дахь аман судалгаанаас).

4.2.2 Орон нутаг дахь махны түгээлт


Малчид дараах 5 сувагаар малаа борлуулж байна.

- 1) Орон нутаг (аймаг)-ийн махны зах болон махны компанид амьдаар нь эсвэл нядлаад хүргэж өгөх
- 2) Махны том компаний төлөөлөгчид худалдах
- 3) УБ хотын нядалгааны газарт хүргэж өгөх
- 4) Сумын хоршоо нь малыг бөөгнүүлээд нядалгааны газар болон махны компаний төлөөлөгчид борлуулах
- 5) Махны ченжид борлуулах

Үүнд, орон нутагт төхөөрсөн малыг тээвэрлэхдээ нийслэлээс хэр хол зайд оршиж байгаагаас шалтгаалан тэвэрлэлтийн арга хэлбэр өөр өөр байна. УБ хотоос 300 км-ийн зай дотор байгаа тохиолдолд төхөөрсөн малын махыг хөргөж, загсааж тээвэрлэх нь түгээмэл бөгөөд 300 км-ээс илүү зайд алслагдсан тохиолдолд хөлдөөж тээвэрлэж байна (ХХААХҮЯ-ны мэдээллээр). Дундговь аймаг УБ хотоос 300 км-ийн зай дотор оршдог бөгөөд хөргөж, загсаасан байдлаар тээвэрлэх боломжтой юм. Нөгөөтэйгүүр, Мандалговь хотын мах бэлтгэдэг ААН-үүд БНХАУ руу экспортоор гаргадаг мах ихээр бэлтгэдэг бөгөөд экспортын зориулалтын махыг хөлдөөж тээвэрлэдэг. Говь-Алтай аймгийн хувьд УБ хотоос 1000 км-ийн зайд алслагдсан тул малыг амьдаар нь тээвэрлэх явдал түгээмэл бөгөөд малыг төхөөрсөн тохиолдолд махыг нь хөлдөөж тээвэрлэж байна.

Малыг аль сувагаар борлуулах нь малчны орчин нөхцлөөс шалтгаална. Дундговь аймгийн хувьд хувьдаа ачааны машинтай гэх мэт тээвэрлэх боломжтой хүн л нядалгааны газар болон мах боловсруулах үйлдвэрийн төлөөлөгчид шууд малаа хүргэж өгч чадна. Зарим нэг хоршоод малчдын малыг цуглуулаад нядалгааны газар болон гэрээт махны компаний төлөөлөгчид

хүргэдэг. Дундговь аймгийн Гурвансайхан сумын хоршоо нь УБ хотын томоохон махны компани болох Мах импекс ХХК-тай гэрээтэйгээр малаа нийлүүлж байна. Адаацаг сумын хоршоо малчдаас малыг нь цуглуулж байгаа ч гэрээтэйгээр борлуулдаг махны компани байхгүй.



Эх сурвалж: UNCTD, Fostering Integration of the Mongolia Downstream Value Chain of Meat into Regional Value Chains¹⁴ зарим хэсгийг өөрчилсөн

Зураг 4-1 Махны түгээлтийн шат дараалал

Дундговь аймгийн төвд мал төхөөрөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани 3, мах борлуулалтын компани 6 байна. Мах борлуулалтын улирал болоход аймгийн төвд 20 орчим ченжүүд ирж татан авалт хийдэг. Аймгийн төвд мах борлуулдаг компаниуд нь ихэвчлэн өөрсдийн хөлдөөгч агуулахтай. Үүнээс хамгийн том нь өөрсдийн нядалгааны газартай мөн 40 тн багтаамжтай хөлдөөгчтэй контейнер 1, 20 тн багтаамжтай энгийн контейнер 3 эзэмшдэг ба 2000 хонины махыг хадгалах хүчин чадалтай. Хятад руу экспортлодог ба өөрсдийн эзэмшлийн хөлдөөгчтэй ачааны машинаар тээвэрлэдэг.

Аймгийн төвд махны борлуулалт хийдэг бусад жижиг аж ахуйн нэгжийн хувьд өөрсдийн эзэмшилдээ хөлдөөгчтэй агуулахтай байх ба аймгийн төвийн нядалгааны газрыг ашигладаг. Жилдээ ойролцоогоор 5,500 толгой хонь борлуулж аймгийн хэрэглэгчдэд нийлүүлдэг. Хөлдөөсөн болон түүхий махын үнийн зөрүү бага боловч түүхий махны авах сонирхолтой хүмүүс олон. Хөлдөөгчний багтаамж нь 1 тонн ба 5 жилийн өмнө 40 сая төгрөгний өртөгтэйгээр барьсан байна. Хөлдөөгчний цахилгааны зардалд сард дунджаар 1 сая төг зарцуулдаг.

Говь-Алтай аймгийн төвд 3 аж ахуйн нэгж мах борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс 1 нь өөрсдийн нядалгааны газартай ба жилдээ 50 тн махыг УБ хотын зах зээлд нийлүүлэх болон гадаад руу экспортлодог. Мөн 100 тн багтаамжтай хөлдөөгчтэй. Малчид өөрсдөө хонио амьдаар нь хүргэж ирдэг. Хувиараа мах борлуулдаг хүмүүсийн хувьд, хөлдөөгчтэй контейнертой, 300 хоньны мах, 100 үхрийн мах хадгалах боломжтой. Малчдаас амьд хониноос гадна махаа мөн авчирч өгдөг.

¹⁴ <https://unctad.org/meeting/fostering-integration-mongolia-downstream-value-chain-meat-regional-value-chains>



Дундговь аймаг дахь хувийн мал төхөөрөх газар



Зүүн талын зурагтай ижил



Мах борлуулалтын жижиглэнгийн худалдаа



Жижиглэнгийн худалдаа эрхлэгчийн махны хөлдөөгчний дотор тал

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 4-2 Мандалговь дахь махны худалдаа

4.3 Махны нийлүүлэлтийн гинжин хэлхээний өнөөгийн байдал ба хэрэгцээ

4.3.1 Гарал үүслийг мөшгих тогтолцоо (traceability system)-ны хөгжүүлэлт

МЭЕГ-т MAHIS (Mongolia Animal Health Information System) буюу Монголын малын эрүүл мэндийн мэдээллийн системээс гаргасан гарал үүсэл мөшгих тогтолцоог 2019 оноос нэвтрүүлэн ажиллаж байна. Мал эмнэлгийн нэгдсэн систем нь сум тус бүрийн малын эмч нарын үзлэг оношлогоо болон орон нутаг хоорондын шилжих хөдөлгөөнөөс үүдсэн гарал үүслийг тодорхойлсон мэдээлэл голлон бүртгэгддэг. Уг системийн явц нь дараах үндсэн агуулгатай.

- (1) Малчин үзлэгт оруулах малаа сумын малын эмч (хувийн хэвшил)-д хүргэж өгнө.
- (2) Малын эмч малын эрүүл мэндийг шалгаад, шинжилгээний дүнг эрүүл ахуйн сертификат болгож шинжилгээний хуудаст тэмдэглэнэ. Шинжилгээний хуудаст үзлэг шинжилгээний ID болон QR кодыг хавсаргасан байна. Нэг шинжилгээний хуудаст малчин тус бүрийн малын үзлэг шинжилгээний дүн тэмдэглэгдэнэ.
- (3) Шинжилгээний дүнг мал эмнэлгийн ерөнхий газрын хяналтын байцаагч шалгаж зөвшөөрөл олгоно.
- (4) Малын бусад орон нутаг руу тээвэрлэх бол нэвтрэх хаалган дээр байрлах цагдаа шинжилгээний хуудас дахь QR кодыг уншуулж, малын шинжилгээнд зөв хамрагдсан эсэхийг нягтална. Хулгайд алдагдсан болон шинжилгээнд хамрагдаагүй тохиолдолд малыг нэвтрүүлэхгүй. (нэмэлт: уг системийг нэвтрүүлсэнээр малын хулгай 40 хувь багассан гэсэн тоо бий)

Мал эмнэлгийн ерөнхий газар нь малын тогтмол хийгдэх үзлэг шинжилгээ, вакцинжуулалтын мэдээллийг цахимжуулж байна. Энэхүү мэдээлэл нь, (1)-д дурдсанчлан сумын малын эмчид дамжих бөгөөд үзлэгт хамрагдсан малыг нядалгаанд орсон тохиолдолд тухайн мэдээлэл ахин шинэчлэгдэнэ. QR код мөн өөрчлөгдөнө. Орон даяар үйл ажиллагаа явуулдаг нийт 600 гаруй аж ахуйн нэгжийн нядалгааны газар, мах боловсруулах үйлдвэр МАНИС-т бүртгэлтэй байна. Шинээр батлагдсан хуульд малыг нядалгаанд оруулахын өмнө заавал үзлэгт хамруулсан байх ёстой гэж заасан учир МАНИС-н үндсэн ажиллагаа одооноос эхэлнэ гэж үзэж байна.

Махны жижиглэн худалдаанд махны боодол бүр дээр QR кодыг наасан байх ба хэрэглэгч тухайн QR кодыг уншуулахад үйлдвэрлэсэн газар, малчны болон хийгдсэн үзлэг шинжилгээний мэдээлэл, нядалгаанд орсон хугацаа гэх мэт мэдээлэлүүдийг шалгах боломжтой. Хүнсний жижиглэнгийн худалдааны сүлжээ дэлгүүр e-Mart-д дэлгүүрийн аппликейшныг ашиглан дэлгүүрт байгаа QR кодыг уншуулахад тухайн бүтээгдэхүүний эрүүл ахуйн гэрчилгээг харах боломжтой үйлчилгээг туршилтаар нэвтрүүлсэн (Зураг 4-3). Энэхүү үйлчилгээ нь e-Mart-тай гэрээтэй ажилладаг Төв аймагт үйлдвэрлэсэн маханд л үйлчилж байгаа ба 2022 оны 12 сарын байдлаар эрүүл ахуйн гэрчилгээний линк нь холбогдохгүй гэх мэт систем хараахан бүрэн ажиллагаанд шилжээгүй байна.



Баруун талын QR кодоор апп-г татах ба зүүн талын QR кодоор эрүүл ахуйн гэрчилгээг харна.

Төв аймагт үйлдвэрлэсэн үхрийн махны лангуу (emart)

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 4-3 QR код ашиглан гарал үүслийг мөшгих тогтолцоог нэвтрүүлсэн байдал

4.3.2 Махыг борлуулсаны дараах хөргүүртэй тээвэрлэлтийн өнөөгийн байдал

Дундговь аймгийн Мандалговь сум (аймгийн төв)-д 6 аж ахуйн нэгж, Говь-Алтай аймаг аймгийн Алтай сум (аймгийн төв)-д 3 аж ахуйн нэгж махны худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба тус бүр хөлдөөгчтэй агуулахтай байна. Мөн махны наймаачид (ченж)-ын дийлэнх нь өөрсдөө хувьдаа хөлдөөгчтэй агуулахтай байна. Дундговь аймгийг зарим аж ахуйн нэгж хөлдөөгчтэй ачааны машин эзэмшдэг.

УБ хотын махны зах (хүчит шонхор хүнсний зах)-н зэрэгцээ хувийн эзэмшлийн хөлдөөгч агуулах байдаг ба -35°C хэмд түргэн хөлдөөгч, -17°C хэмд хөлдөөж хадгалах боломжтой. УБ хотын махны компаниуд хөлдөөгчтэй ачааны машинтай.

Доор, махны тээвэр ложистик чиглэлийн аж ахуйн нэгж, байгууламжийн зургийг харуулав.



**УБ хотын Хүчит шонхор зах дахь
махны худалдаа**



**Хүчит шонхор захын дэргэд байрлах хувийн
компаний эзэмшлийн хөлдөөгчтэй агуулах**



**Хувийн хэвшлийн махны компаний
(Precom ХХК) контейнер нядалгааны газар**

Эх сурвалж: Судалгааны баг




Precom ХХК-ий хөлдөөгчтэй ачааны машин

Зураг 4-4 УБ хотын махны зах ба махны компани

(1) Хөлдөөгчтэй агуулахын хэрэгцээ

Малчдын дунд хийсэн судалгааны дүнгээс, зудын урьдчилсан мэдээг ашиглан малаа борлуулахад тулгамдаж буй асуудал нь хадгалалтын асуудал ба сумын түвшинд хөлдөөгчтэй агуулахын хэрэгцээ их байгаа нь тодорхой болсон. Аймгийн түвшинд ч хөлдөөгчтэй агуулахын хэрэгцээ шаардлага өндөр байна. Нөгөөтэйгүүр, мах бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг ААН болон хувь хүмүүс, зуучлан борлуулагч нар хувьдаа хөлдөөх төхөөрөмж эзэмшин ашиглаж байна. Тухайлбал, аймгийн төвийн томоохон мах бэлтгэгч ААН нь Хятад руу экспортын зориулалтаар мах бэлтгэдэг бөгөөд хөлдөөгчтэй агуулах болон хөлдөөгчтэй ачааны автомашиныг үйл ажиллагаандаа өргөнөөр нэвтрүүлсэн байна. Сум орон нутаг дахь махны эргэлтийн хувьд бол дээр дурдсан аймгийн түвшинд бий болсон махны түгээлтийн дэд бүтэцтэй уялдуулах, эсвэл өөр төрлийн зах зээлийг зорих гэх зэрэгт чиглэсэн бодлого шаардагдаж байна.


Хөлдөөгчтэй агуулахыг мах хадгалах, сүү, сүүн бүтээгдэхүүн хадгалах, арьс шир хадгалах гэсэн зориулалтаар ашиглана (Зураг 4-5). Махны хадгалалт нь намар нядалгаа хийгдээд хавар борлуулах хүртэлх хугацаанд голчлон байх ба зуны улиралд агуулахын ажиллагаа буурна. Сул зогсолттой үеийн зардал өндөр учир агуулахыг жилийн туршид ажиллагаатай байлгах зайлшгүй шаардлагатай. Малчдын зүгээс сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах хэрэгцээтэй гэж байгаа ч сүү сүүн бүтээгдэхүүний үнэ хямд учир нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж нийлүүлэх шаардлагатай.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 4-5 Хөлдөөгчтэй агуулахын ашиглах зориулалт

Агуулахын хяналтыг Дундговь аймгийн тухайд малчдын бүлэг, хоршоонд хариуцуулах нь зүйтэй гэж үзэж байгаа ба Говь-Алтай аймагт сумын дарга гэх мэт орон нутгийн удирдлага хариуцах нь зүйтэй гэж үзэж байна (Зураг 4-6). Нөгөөтэйгүүр, судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргаанаас малчдын бүлэг болон хоршоо, хувийн хэвшилд хариуцуулах нь зүйтэй гэсэн санал их байна. Энэ нь орон нутгийн захиргаа нь засгийн эрх солигдохтой холбоотой хариуцсан хүн нь солигдох тохиолдол олон, ажил хүлээлцэхэд хүндрэлтэй байдаг нь гол шалтгаан юм.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 4-6 Хөлдөөгчтэй агуулахын хяналт тавих этгээд

4.3.3 Махны экспорт

(1) Экспортын зах зээл

Үхрийн мах (хөлдөөсөн)-ны экспортын хэмжээ нь 2000 оны эхний хагаст 10 мянган тонн давж байсан боловч малын шүлхий өвчин гарсны улмаас 2013 онд 0 болтлоо буурсан. 2014 онд ахин

экспортолж эхэлсэн ба гол экспортлогч орон нь Орос юм. 2018 онд 1,055 тн мах экспортлосон бол 2019 оноос хойш энэ хэмжээ өсөөгүй тогтсон үзүүлэлттэй байна.

Ямааны болон хонины махны хувьд хэдэн зуун тонн-д хэлбэлзэж байсан ч шүлхий өвчний нөлөөгөөр 2014 онд 0 болж, 2015 оноос ахин экспортолж эхэлсэн ба голчлон Иран болон Вьетнам зэрэг орнууд руу экспортолж байна. 2019 онд 7,012тн мах экспортлосон боловч 2021 оны байдлаар 1,692 тн хүртэл буурсан.

Адууны махны экспорт шүлхий өвчний нөлөө байхгүй тогтмол байгаа ба ихэвчлэн Хятад улс руу экспортолж байна. 2018 онд экспортын хэмжээ 32,201тн хүртэл өссөн ч 2021 онд 6,959 тн болсон байна.

Боловсруулсан мах (дулааны аргаар боловсруулсан мах¹⁵) ны экспорт 2013 онд ердөө 0.2 тн байсанаас 2018 онд 29,222тн хүртэл өссөн боловч 2021 онд 13,478тн хүртэл буурсан. Гол экспортлогч орон нь Хятад улс ба махны төрлөөр нь авч үзвэл ямаа, хонины мах 86%, үхрийн мах 14% байна.

Махын экспортын хэмжээнд шүлхий өвчний тархалт гол нөлөөтэй. Мөн 2020-2021 онд Хятад улс корона вирустай холбоотойгоор хил хаасан зэргээс шалтгаалан махны экспорт их хэмжээгээр буурсан.

“Монгол мал үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 онд махны экспортын хэмжээг 50,000 тн-д хүргэх зорилт тавьсан боловч 2021 оны байдлаар 8,600 тн байна.

(2) Халал мах

Монгол улсаас Иран улс руу халал махын 2017 оноос экспортолж эхэлсэн ба тухайн жилдээ 1,302тн махыг экспортлосон. Халал махыг бэлтгэхдээ олон улсан хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашигладаг ба импортлогч орноос мэргэжилтэн тухайн үйлдвэр дээр ирж шалгалт, хяналт тавьдаг. Монголд үйл ажиллагаа явуулж буй халал мах экспортлох эрхтэй үйлдвэр нь Darkhan Meet Food ХХК, Makh Market ХХК, Eco Food Trading ХХК, Zerger International ХХК зэрэг компаниуд байна.

4.4 Цаашид тулгамдаж буй асуудал

Монгол улсын малын тоо өөрийн орны махны дотоодын хэрэгцээнээс давсан байгаа ч гадаадын зах зээл дэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь хамгийн чухал асуудал болж байна. Махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд шүлхий гэх мэт малын өвчнийг устгах, мах боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн шаардлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Дэлхий дахинд махны хэрэглээ цаашид 10 жилийн хугацаанд хөгжиж буй орнуудыг голчлон нэмэгдэх төлөвтэй байгаа тул Монгол улсын махны экспортыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Хөгжингүй орнуудад мал аж ахуйн байгаль орчинд үзүүлэх нөлөө, амьтны халамжийн асуудалтай холбоотойгоор махны талаар сөрөг ойлголт бий боловч бэлчээрийн мал аж ахуйтай Монгол орны хувьд энэ төрлийн шүүмжлэлд өртөх магадлал бага. Монгол улсын засгийн газар урт хугацааны зорилтын хүрээнд нүүдлийн мал аж ахуйн соёлыг хадгалах, органик бөгөөд брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортыг нэмэгдүүлэхийг зорьж байгаа ба малын тоо толгой, төрлийг зохистой түвшинд хүргэх, малын өвчний хяналтыг нэмэгдүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Цаашид олон улсын түвшинд нийцсэн эрүүл ахуйн хяналт, бэлчээрийн нөөцийг тогтвортой хадгалах тогтолцоог бий болгох нь зүйтэй.

¹⁵ шүлхий өвчин гарсан байсан ч экспортлогч орны зөвшөөрөлтэй үйлдвэрт боловсруулсан бол экспортлох боломжтой.

5-р бүлэг Хандивлагч байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага

5.1 Энэхүү судалгаанд хамрагдсан салбарт хэрэгжиж буй донор орнуудын хамтын ажиллагаа

Монгол улсын засгийн газар олон улсын байгууллага, донор орнуудтай хамтран Humanitarian Country Team (НСТ) дотор кластер үүсгэн хүмүүнлэгийн ажлуудыг хийж байна. Үүнтэй уялдаад, “Хүнсний аюулгүй байдал ба хөдөө аж ахуй” хүмүүнлэгийн кластер дахь төрийн удирдлагыг ХХААХҮЯ-д төвлөрүүлэн, НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллага оролцогч талуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар нь Монгол улсын дэд сайд болон Онцгой байдлын хорооны даргын захирамжийн 5-д заасны дагуу зудын эрсдлийн үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж байна. Энэхүү ажлын хэсэгт Монгол улсын онцгой байдлын хороо, ХХААХҮЯ-аас, Мал эмнэлгийн ерөнхий газар, ХНХҮГазар, УЦУОСМХүрээлэн, ОБЕГГазар, НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллагын мэргэжилтнүүд оролцож байна. Ажлын хэсэг нь зудын эрсдлийн үнэлгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг хэлэлцэн, ганд нэрвэгдсэн Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймгуудад судалгаа явуулж, зудын эрсдлийн үнэлгээг хэрэгжүүлсэн.

Хүснэгт 5-1 Монгол дахь кластер болон хариуцсан байгууллагуудын жагсаалт

No	Кластер/Салбарууд	Удирдах байгууллага	Засгийн газрын гол холбоос
1	Кластер дундын зохицуулалт	RCO/HC	DP Office; NCC
2	Хоол тэжээл	UNICAF	Ministry of Health (MoH)
3	Ус ариун цэвэр	UNICAF	National Water Committee (NWC)
4	Боловсрол	UNICAF and Save the Children	Ministry of Education and Science (MoES)
5	Эрүүл мэнд	WHO	Ministry of Health (MoH)
6	Түр орогнох байр	ICRC (IFRC)	Ulaanbaatar City Governor's Office
7	Хамгаалал (Жендерг суурилсан хүчирхийлэл болон хүүхэд хамгаалал)	UNFPA and UNICAF	Ministry of Labour and Social Protection (MoLSP)
8	Хүнсний аюулгүй байдал болон хөдөө аж ахуй	FAO	Ministry of Food, Agriculture and Light Industries (MOLLI)
9	Ложистик	UNICAF	Ministry of Road and Transportation (MoRT), Civil Aviation Authority (CAA), Mongolian General Customs Administration (MCA)
10	Онцгой үеийн харилцаа холбоо	UNICAF	DDC
11	Зуслангийн зохицуулалт болон менежмент	IO	Ulaanbaatar City Emergency Management Agency (UB CEMA)

Эх сурвалж: ОБЕГ-аас авсан материалаас

5.2 Хандивлагч байгууллагуудын хэрэгжүүлж буй холбогдох төсөл, хөтөлбөрийн агуулга

Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн төслүүд болон зээл тусламжийн байгууллагуудын (хоёр улс хоорондын дэмжигч байгууллага, олон улсын байгууллага, ТББ) одоо хэрэгжүүлж буй төслүүдийг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв. Газар дээрх уулзалт ярилцлагаар АХБ-ны дэмжлэгтэйгээр ОБЕГ-ын гамшгийн талаарх мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмж, чадавхийг бэхжүүлэх зорилгоор зээлийн төсөл боловсруулж байгаа, мөн Азийн гамшгаас хамгаалах төв (АГХТ) нь БОАЖЯ-тай хамтарч цаг агаарын гамшгаас хамгаалах (зуд, ган, үер) таамаглалын чанарыг сайжруулахтай холбоотой техникийн дэмжлэг үзүүлэх замаар Байгаль орчны яам болон Уур амьсгалын ногоон сангийн төслийн тендерт оролцохоор бэлтгэж байгаа мэдээлэлийг авсан. АГХТ-ийн төсөлд ОБЕГ, ХХААХҮЯ-ыг холбогдох байгууллагаар хамруулах төлөвлөгөөтэй байна.

(1) Уур амьсгалын ногоон сангийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд, уур амьсгалын өөрчлөлт

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
1.	АХБ	ТА 6859-MON: Монгол Улсын байгаль орчин, байгалийн нөөцийн салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, олон нийтийн мэдлэг чадавхийг сайжруулах техник тусалцааны төсөл	<p>Хугацаа: 2021-2024</p> <p>Хариуцах байгууллага: БОАЖЯ</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв (УАӨСХАТ)</p> <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <p>Үр дүн 1: УАӨСХАТ-ийн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлага, стратегийн төлөвлөгөө боловсруулах чадавхийг сайжруулах.</p> <ul style="list-style-type: none"> УАӨСХАТ-ын мэдлэг, удирдлага, техникийн ур чадварыг дээшлүүлэхэд зориулсан стратегийн төсөл болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах. УАӨСХАТ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих бичиг цаасны болон техникийн тоног төхөөрөмж (шаардлагатай бол мэдээлэл, харилцаа холбооны технологийн техник, программ хангамж, албан тасалгааны тавилга гэх мэт) худалдан авахад туслах. Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэлийн удирдлага, дасан зохицох арга хэмжээний үр нөлөөг хянах хяналт-шинжилгээ, дүгнэлт, NDC-ийн тайлагналын талаарх удирдамж боловсруулах. Эдгээр удирдамжид үндэслэн уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэлийн удирдлага, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хяналт/тайлагнал/баталгаажуулалтын талаар ТОТ хийж, NDC-ийн тайлагна болон уур амьсгалд дасан зохицох төслийн дүгнэлийг үр дүнтэй гүйцэтгэх талаар төслийн менежерүүдийг чиглүүлнэ. <p>Үр дүн 2:</p> <p>Үндэсний зорилт (NDC) дасан зохицох зорилгыг бодлого, стратегийн төлөвлөгөө, төсөлд нэгтгэх удирдамжийг боловсруулан гаргана.</p>	УАӨСХАТ-ийн чадавхийг дээшлүүлэх замаар засаглалыг бэхжүүлэх тул холбогдох бодлогын баримт бичигт тусгах, хяналт тавих зэрэг зохицуулалтыг хийж, харилцан үр дүнг сайжруулах.

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
			<ul style="list-style-type: none"> • АХБ-ны зээлийн багцад үндэслэн (а) усны нөөцийн менежмент, (б) биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийг сэргээх, (в) эко аялал жуулчлал гэсэн гурван чиглэлээр тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой дасан зохицох зохих арга хэмжээг тодорхойлно. • Сонгогдсон аймгуудад төсөл хэрэгжүүлэх урьдчилсан ТЭЗҮ-ийг хийх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төрийн бодлогыг бэхжүүлэх, санхүүгийн механизмыг дэмжих • Дасан зохицох арга хэмжээний чадавхийг судлах, төсөл боловсруулах. • NDC-ийн уур амьсгалын эмзэг байдлын дүгнэлт, дасан зохицох үнэлгээ, дасан зохицох төсөлд жендэрийн чиг хандлагыг тусгах, NDC-ийн хэрэгжилтийн тайлан, Парисын хэлэлцээрийн хяналт-шинжилгээ, тайлагнах, баталгаажуулах зохицуулалтын дагуу хоёр жил тутам хариуцлагын тайлан гаргах зэрэг асуудлаар улс орнуудын цаг уурын үндэсний төвүүд болон төрийн сайдын төлөөлөгчдийг (ус, байгаль орчин, хөдөө аж ахуй, санхүү зэрэг) чадавхжуулах хөтөлбөрийг боловсруулна. • Төслийн бүсээс сонгогдсон аймаг (Архангай, Баянхонгор, Сэлэнгэ) дахь NDC-ийн дасан зохицох зорилтуудыг иж бүрэн газар зохион байгуулалт, орон нутгийн дасан зохицох иж төлөвлөгөөнд нэгтгэх. • Бусад хөгжлийн түншүүд болон АХБ-тай сурсан сургамжаа хуваалцах. <p>Үр дүн 3: Дасан зохицох арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд байгаль орчныг хамгаалах ухамсартай иргэний нийгмийг зохион байгуулах.</p> <ul style="list-style-type: none"> • УАӨСХАТ болон АХБ хамтран санал цуглуулах зарлалыг нийтэлж, удирдан зохион байгуулж, CSO-ын санаачилгыг шалгаж, сонголт хийх, шагнаж урамшуулах удирдах хороог байгуулна. 	
2.	НҮБ-н Хөгжлийн хөтөлбөр	Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь УАНС-гийн төсөл	<p>Хугацаа: 2021-2028</p> <p>Хариуцах байгууллага: БОАЖЯ</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь төлөөлөгчийн газар</p> <p>Хүлээгдэж буй үр дүн: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөмтгий дөрвөн аймгийн малчдын нийгмийн дасан зохицох чадавхийг бэхжүүлэх зорилгоор, а) Аймгийн түвшинд газар, ус ашиглалтын уур амьсгалд суурилсан төлөвлөлтийг тогтворжуулах, б) экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээ, в) уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй амьжиргаа эрхлэх малчидын чадавхийг бэхжүүлэх. Уг төслийг Уур амьсгалын өөрчлөлтийн байгалийн нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах, мал аж ахуйн салбарт шаардлагатай өөрчлөлтүүдийг дэмжих зорилгоор Байгаль</p>	<p>Усны нөөцийг баталгаажуулах замаар бэлчээрийг бий болгох, удирдахад чиглэсэн төсөл.</p> <p>Бэлчээрийг баталгаажуулах тал дээр зорилго нь давхцаж байгаа боловч усны нөөцийг баталгаажуулах арга барилтай холбоотой.</p> <p>Хэрэгжүүлэх газар нь давхарцаагүй.</p>

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
			<p>орчны яамнаас хэрэгжүүлэх бөгөөд ХХААХҮЯ, ялангуяа Монгол мал үндэсний хөтөлбөртэй нягт хамтран ажиллаж, нэгдсэн арга барилаар хэрэгжүүлнэ.</p> <p>Үр дүн 1: Уур амьсгалын мэдээллийг үндэсний болон орон нутгийн түвшинд газар, ус ашиглалтын төлөвлөлтөд тусгах</p> <p>Үр дүн 2: Цөөхөн малтай малчдын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус, хөрсний менежментийн чадавхийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувь нэмэр оруулах нөөцийн менежментийг бэхжүүлнэ.</p>	
3.	АХБ	<p>FP154: Аймаг, сум хөгжүүлэх Хөрөнгө оруулалтын хөтөлбөр (ACXXOX) (ASDIP)</p> <p>УАНС-гийн төсөл (2021 онд батлагдсан/ УИХ-ын шийдвэр хүлээж буй)</p>	<p>Хугацаа: 2жил</p> <p>Хариуцах байгууллага: Ministry of Finance, Ministry of Construction and Urban Development (MCUD), the Development Bank of Mongolia (DBM), the Asset Management Company of Development Bank of Mongolia (AMC-DBM)</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: MCUD, MOFALI, AMC-DBM</p> <p>Төслийн агуулга:</p> <p>Монголын бэлчээрийн доройтол, хэт их мал хариулах явдалтай тэмцэх зорилготой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай хотыг байгуулах, орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад хангалттай үйлчилгээ үзүүлэх. Мөн малын тоог хязгаарлан бэлчээрийг тогтвортой удирдах малчдын бүлэгийг дэмжих, хөдөө аж ахуйн бизнесийн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх зэрэг арга хэмжээ авна. Зорилтот бүс нь Баян-Өлгий, Ховд, Увс, Дорнод, Сүхбаатар Говь-Алтай, Завханыг санал болгож байна.</p>	<p>Бэлчээрийг сайжруулахад хамаатай.</p> <p>Дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүжилт, малчдад үзүүлэх татаасын тухайд зөвхөн үр дүнгээ харах болно.</p>
4.	Дэлхийн Зөн Монгол	Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малчдын амьжиргааг дэмжих төсөл	<p>Хугацаа: 2021-2023</p> <p>Хариуцах байгууллага: ХХААХҮЯ, ОБЕГ</p> <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <p>Төслийг Дэлхийн Зөн байгууллагаас санхүүжүүлж, Увс (Өмнөговь, Тариалан, Түргэн, Сагил 4 сум) болон Говь-Алтай (Бугат, Дэлгэр, Тайшир, Чандмань 4 сум) аймгийн орон нутгийн засаг захиргаа, хөдөө аж ахуйн салбар, онцгой байдлын газар, мал үржүүлгийн газартай хамтран хэрэгжүүлж байна.</p> <p>Төсөл нь мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, өрхийн газар тариалан эрхлэгчидийн бүлгийг бүрдүүлэх замаар ядуу малчдын дасан зохицох чадвар, амьжиргаа, тэжээллэг байдлыг сайжруулах зорилготой юм.</p> <p>Төслийн арга хэмжээ нь эмзэг бүлгийн нийгэмд хүүхдүүдийг зохистой хоол тэжээлээр хангаж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, улмаар хүүхдүүд болон тэдний гэр бүлийн тогтвортой сайн сайхан байдалд хувь нэмэр оруулна.</p>	<p>Малчдын амьжиргааг дээшлүүлэх үйл ажиллагааны хувьд хамааралтай.</p> <p>Энэхүү төслийн үр дүнг харж Малчдын ухамсрыг дээшлүүлнэ</p>

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
5.	Дэлхийн Зөн Монгол	“Уур амьсгалд тэсвэртэй орон нутаг” төсөл	<p>Хугацаа: 2022-2025</p> <p>Хариуцах байгууллага: ХХААХҮЯ, ОБЕГ</p> <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <p>Энэ төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Хүмүүнлэгийн тусламжийн газраас санхүүжүүлж буй бөгөөд УБ хот (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг), Дорнод аймаг (Хэрлэн, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Баяндун, Халхгол сум), Дундговь (Сайнцагаан, Эрдэнэдалай, Хулд сум), Дорноговь (Сайншанд, Хатанбулаг, Их хэт сум), Говь-Алтай (Есөнбулаг, Бигэр, Төгрөг сум), Увс (Улаангом, Өлгий, Давст сум)-д хэрэгжүүлж байна. Энэ нь гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулж, амьжиргааг дээшлүүлэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлснээр ард иргэдийг уур амьсгалаас үүдэлтэй гамшигаас сэргээн босгох чадварыг дээшлүүлэх зорилготой юм. Уг төсөл нь ВНА-ын Онцгой байдлын хэрэглээний удирдамжийн дэд салбар болох гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын төлөвлөлт, хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Төслийн үндсэн үйл ажиллагаа нь байгууллагын гамшгаас хамгаалах менежментийг сайжруулах, салбарын онцлогт тохирсон арга барилыг ашиглан иргэдийн ур чадварыг дээшлүүлэх, бэлчээрийн мал аж ахуйг чиглүүлэх явдал юм. Мөн хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийг бэхжүүлэх, олон нийтэд түшиглэсэн эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд туслах зорилготой юм.</p>	<p>Шууд хамааралгүй.</p> <p>Мал эмнэлгийн чадавхижуулахтай холбогдох үр дүнгээ харах болно.</p> <p>Говь-Алтай аймгийн зорилтот газар давхцаж байгаа тул хамтран ажиллах талаар анхаарна.</p>
6.	Дэлхийн Банк / НҮБ-ын харьяа ХАА-н газар	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	<p>Хугацаа: 2020-2024</p> <p>Хариуцах байгууллага: ХХААХҮЯ</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын харьяа ХАА-н газар</p> <p>Төслийн агуулга: Уг төслийн зорилго нь төсөл хэрэгжүүлэх бүс нутгийн мал сүргийн эрүүл мэнд, ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадвартай болгоход оршино.</p> <ul style="list-style-type: none"> - Мал эмнэлгийн тогтолцоо, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүйн стандартыг бий болгох зэрэг асуудалыг шийдвэрлэнэ - Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нартай хамтран ажиллах замаар хөрөнгө оруулалтын болон санхүүгийн орчныг сайжруулна - Нийтийн өмч, үйлчилгээг бий болгох стратегийн хөрөнгө оруулалт хийх, малчид, малчидын бүлгүүдийн зах зээлд гарах байдлыг сайжруулах зорилгоор хувийн хэвшилтэй хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ 	<p>Үйл ажиллагаа нь харилцан хамааралтай учир мэдээлэл цуглуулах, хамтран ажиллах боломжийг судална.</p>


	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
			<ul style="list-style-type: none"> - Төрийн гол байгууллагуудыг бэхжүүлэх замаар хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх тогтолцоог дэмжинэ. - Хүний нөөцийн хөгжил, мал аж ахуйн салбарын хөгжил хоорондын дээд түвшиний бодлого хөтөлбөртэй уялдаа холбоог сайжруулна. - Малын эрүүл мэнд, үржил, тэжээл, зах зээлийн хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалтыг зохицуулах - Хүнсний аюулгүй байдал, байгаль орчныг харгалзан нэмүү өртгийн сүлжээний өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын экспортыг дэмжих. <p>Хэрэгжүүлэх газар нь 12 аймаг болон 80 сум (Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Төв, Увс, Өвөрхангай, Завхан, УБ)</p>	

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Зудын гамшгийг эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаанууд

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
1.	АХБ	ТА 6534-MON: Гамшгийн аюулыг эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэх нэгдсэн системийг хөгжүүлэх	<p>Хугацаа: Сангийн яамнаас санал болгож буй</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: ОБЕГ, ЦУОШГ, ШУА</p> <p>Үйл ажиллагааны агуулга:</p> <p>Энэхүү төсөл нь эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэх нэгдсэн систем (EWS) хөгжүүлэх дараах 8 үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сэрэмжлүүлэг мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх 2. Тоон радио холбооны системийг хөгжүүлэх 3. Телевиз, радиогийн шууд нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх 4. Гар утасны дохиоллын мэдээлэл дамжуулах системийг хөгжүүлэх 5. Жирийн иргэдийн гар утас руу шууд мэдээлэл илгээх систем, холбогдох техник хангамж, программ хангамжийг хөгжүүлэх 6. Иргэд, онцгой байдлын албаны чадавхийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох 7. Дуут дохио цамхагийн системийг суурилуулах 8. Дотоод дохиоллын системийн засвар үйлчилгээ 9. Хөдөлгөөнт холбооны системийг хөгжүүлэх (тээврийн хэрэгсэл) 	Төслийн үр дүнг гар утасны мэдээлэл дамжуулах системийг боловсруулахад ашиглах.

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
2.	Дэлхийн зөн Монгол	Монгол дахь гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ (DAAM)	<p>Хугацаа: 2022-2023</p> <p>Санхүүжүүлэгч байгууллаг: Aktion Deutschland Hilft</p> <p>Хамрагдах орон нутаг: Зудын эрсдэлтэй 8 бүсээс эрсдэл өндөртэй 3 бүсийг сонгоно.</p> <p>Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас Германы Aktion Deutschland Hilft (ADH) тусламжийн байгууллагын санхүүжилтээр 2022 оны 10-р сараас эхлэн Монгол Улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагаа (DAAM) төслийг эхлүүлж байна. Олон нийтийн түвшинд гамшгийн бэлэн байдал, гамшгийн өмнөх үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх зорилгоор сонгогдсон эмзэг бүсүүдэд урьдчилан таамаглах үйл ажиллагааны протокол байгуулахаар Дэлхийн зөн олон улсын байгууллагаас сонгогдсон зургаан орны нэг нь Монгол Улс юм.</p>	
3.	НҮБ Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP)	Монгол Улсын амьжиргааг хамгаалахын тулд мобайл дата системийг сайжруулах	<p>Хугацаа: 2019-2020</p> <p>Санхүүжүүлэгч байгууллага: WFP</p> <p>Хэрэгжүүлэгч байгууллага: Mercy Corps, ОБЕГ</p> <p>Холбогдох байгууллагууд: NSO, NAMEM, MOFALI, MRCS</p> <p>Энэхүү төсөл нь гар утсанд суурилсан технологийг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангахад чиглэсэн дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Таблет, ухаалаг утас ашиглан гар утсанд суурилсан судалгаа • Дуудлагын төв, SMS эсвэл IM-ээр алсын зайны судалгаа • Чатбот болон интерактив дуут хариулт • Мерси Корпосын " Leveraging Tradition and Science -2 (LTS2)" төслийн хүрээнд бүтээсэн SMS систем нь Монгол Улсын нийт гар утас хэрэглэгчдэд 14 төрлийн цаг агаар, бэлчээр, хадлан, улаан буудайн зах зээлийн үнийн талаарх мэдээллийг түгээх (Төсөл дууссаны дараа уг системийн хяналтыг ОБЕГ-т шилжүүлнэ) • Урьдчилан сэрэмжлүүлэх SMS мессежийг олон нийтэд түгээх (жишээ нь, өвлийн шуурга, үер усны аюулын сэрэмжлүүлэг) <p>Монгол Улсын Засгийн газар болон дээрх агентлагууд сансрын хиймэл дагуулын мэдээг ашиглан улс орон даяар зудыг хянах SMS-д суурилсан системийг бий болгосон. Дэлхийн хүнсний хөтөлбөр нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Мерси Кортай хамтран гар утсанд суурилсан тандалтын системийг өргөжүүлж, зудын нөлөөлөл, нөхцөл байдлын бодит тухайн цаг хугацаанд нь хянах хяналтын платформыг (PRISM) бий болгосон.</p> <p>PRISM нь шийдвэр гаргагчдыг төлөвлөлт, хариу арга хэмжээг боловсруулахад хамгийн сүүлийн үеийн эрсдэл, нөлөөллийн дүн шинжилгээг</p>	

	Байгууллагынэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
			<p>хийсэнээр уур амьсгалаас үүдэлтэй хохирлын нөлөөллийг бууруулах зорилготой юм.</p> <p>ҮСХ, ОБЕГ, ХХААХҮЯ, ЦУОШГ-ын зайнаас тандан судлах байгууллагуудтай хамтран "Шууд дамжуулалтын мэдээлэл, нөхцөл байдлын мониторинг хийх сансрын ажиглалтын мэдээллийн технологийн платформ"-той холбоотой нийт 44 аюул, эмзэг байдал, эрсдэл, чадавхийн үзүүлэлтүүдийг баталсан байна.</p> <p>Ган гачиг гэх мэт ург хугацааны гамшгийн тохиолдоход, PRISM нь өнгөрсөн мэдээлэл дээх үндэслэн өнөөгийн нөхцөл байдлын тоймыг гаргаж, тэрхүү мэдээллийг эмзэг бүлгийн мэдээлэлтэй нэгтгэсний үндсэн дээр эрсдэлтэй бүс нутгийг тодорхойлно. Хүнд гамшгийн тохиолдсон үед PRISM нь эрсдэлд өртөж болзошгүй нөхцөлд байгаа хүмүүсийн тоон статистикийг хурдан гаргаж, засгийн газар болон хүмүүнлэгийн түншүүдэд хүмүүсийг ослын газар явуулахгүйгээр гамшгийн цар хүрээг үнэлэх боломжийг олгодог. PRISM доторх мэдээллийг төрийн байгууллагууд, хүмүүнлэгийн ажилтнууд болон олон нийтэд шууд хүргэх боломжтой.</p>  <p style="text-align: center;">Зураг 5-1 PRISM</p>	
4.	Монголын улаан загалмай нийгэмлэг	Монголын хүнд нөхцөлд буй малчдад зориулсан цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт	<p>Хугацаа: 2018 он</p> <p>Санхүүжүүлэгч байгууллага: Английн улаан загалмайн нийгэмлэг</p> <p>ЦУОШГ болон УЦУОСМХ, Японы Нагоягийн их сургууль хамтран боловсруулсан зудын эрсдлийн газрын зураг нь цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн (FbF) үндэслэл болох мэдээллээр хангадаг. Монгол орны хувьд зудын эрсдэл нь хур тунадасны хэмжээ, гангийн эрсдэл, бүс нутгийн агаарын температур зэрэг шинжлэх ухааны 14 үзүүлэлтийг үндэслэн тодорхойлдог. FbF хөтөлбөрийг хэрэгжүүлснээр малын хорогдолоос өмнө малчдад мэдээллийг хүргүүлж, урьдчилсан арга хэмжээ авах боломжтой. Малчдыг дэмжих хамгийн тохиромжтой үе нь мал сүрэг доройтохоос өмнө байх ба малын хорогдолгүй байх, малчдын амьдралд зудын үзүүлэх нөлөөллийг бууруулах боломж бүрдүүлнэ гэж найдаж байна.</p> <p>Төслийн хүрээнд 12 аймгийн 40 эмзэг бүлгийн 2000 малчин өрхөд 240 мянган төгрөг, эрдэс гэжээлийн багц олголоо.</p>	

Эх сурвалж: Судалгааны баг

(3) Бусад хандивлагч байгууллагын боловсруулж буй төслийн санал

	Байгууллагын нэр	Төсөл, хөтөлбөр	Агуулга	Уялдаа холбоо, хамтран ажиллах боломж
1.	АХБ	ТА 6534-MON: Гамшгийн аюулыг эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэх нэгдсэн системийг хөгжүүлэх	Хугацаа: Сангийн яамнаас санал болгож буй Хэрэгжүүлэгч байгууллага: ОБЕГ, ЦУОШГ, ШУА Үйл ажиллагааны агуулга: Энэхүү төсөл нь эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэх нэгдсэн систем (EWS) хөгжүүлэх дараах 8 үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 1. Сэрэмжлүүлэг мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх 2. Тоон радио холбооны системийг хөгжүүлэх 3. Телевиз, радиогийн шууд нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх 4. Гар утасны дохиоллын мэдээлэл дамжуулах системийг хөгжүүлэх 5. Жирийн иргэдийн гар утас руу шууд мэдээлэл илгээх систем, холбогдох техник хангамж, программ хангамжийг хөгжүүлэх 6. Иргэд, онцгой байдлын албаны чадавхийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох 7. Дуут дохио намхагийн системийг суурилуулах 8. Дотоод дохиоллын системийн засвар үйлчилгээ 9. Хөдөлгөөнт холбооны системийг хөгжүүлэх (тээврийн хэрэгсэл)	Төслийн үр дүнг гар утасны мэдээлэл дамжуулах системийг боловсруулахад ашиглах.
2.	Азийн гамшгаас урьдчилан сэргийлэх төв	Зудын урьдчилсан мэдээний нарийвчлалыг сайжруулах технологийн дэмжлэг	Хугацаа: 2024- (2023 онд Уур амьсгалын ногоон санд санал болгохоор хэлэлцэж буй) Санхүүгийн эх үүсвэр: GCF/USAID Хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, (УЦУОСМХ), Төслийн саналын агуулга: УЦУОСМХ-ий зудыг урьдчилан таамаглах чадавхийг бэхжүүлэх (одоо ашиглаж буй урьдчилан таамаглах загварыг сайжруулах)-д чиглэсэн технологийн дэмжлэг, урьдчилан таамаглахад шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр (компьютер, сервер гэх мэт) хангах, хойд бүсийн зудын урьдчилсан мэдээний нарийвчлалыг сайжруулахад холбогдох туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	Сайжруулсан цаг агаарын мэдээллийг ашиглах.

Эх сурвалж: Судалгааны баг

5.3 Япон улсын Байгаль орчны яамнаас үзүүлж буй дэмжлэг

Япон улсын засгийн газар “Япон улсын засгийн газрын уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнөөс үүссэн алдагдал болон хохирол (lose,damage)-г дэмжих багц”¹⁶-г зарласан. Энэхүү багцад, (1) Японы талаас үзүүлэх гамшгаас урьдчилан сэргийлэхээс авахуулаад гамшгийн үеийн дэмжлэг, гамшгийн эрсдлийн даатгал гэх мэт цогц дэмжлэг, (2) knowledge base системд мэдлэг мэдээлэл хуваалцах, (3) НҮБ болон улс орнуудын хоорондын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах, (4) төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрэн дэх уур амьсгалтай холбоотой үйлчилгээ, технологийг бусад гадаадын улсуудад нэвтрүүлэхийг дэмжих зэрэг нь хамрагдана.

Байгаль орчны яаманд цөлжилтийн эсрэг арга хэмжээнд шинжлэх ухааны талаас хувь нэмрээ оруулах зорилготой цөлжилтийн эсрэг арга хэмжээг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна¹⁷. Монгол улсын хувьд, “Хуурай сэрүүн бүс дэх нутгийн иргэдийн оролцоотойгоор бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хэлэлцэх (2012-2015)”, “Цөлжилт ба уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхыг сайжруулах-Монгол улсын говийн бүсэд-(2007-2011)” зэрэг төслүүд хэрэгжсэн.

¹⁶ https://www.env.go.jp/press/press_00826.html

¹⁷ https://www.env.go.jp/nature/shinrin/sabaku/index_1_6.html

6-р бүлэг Төслийн үнэлгээний үр дүн

6.1 Одоо байгаа төлөвлөгөөнд өгөх үнэлгээ

ЖАЙКА байгууллага уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний хувьд малчдад учирч буй зудын хохирлоос урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах зорилгоор (1) зудын урьдчилсан мэдээний үнэн зөвийг сайжруулж, үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх; (2) зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр дүнтэй ашиглах, (3) нарны эрчим хүчийг ашигласан мах хөлдөөх, хадлалах систем (PV систем) нэвтрүүлэх, (4) эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээлтийг сайжруулах гэсэн 4 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан төлөвлөгөө бүхий төслийн CN-г УАНС-д дэвшүүлсэн.

Энэхүү судалгаагаар Хүснэгт 6-1-д үзүүлсэнчлэн энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг нягталж, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ тухай хэлэлцсэн.

Хүснэгт 6-1 УАНС-д дэвшүүлсэн CN төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа болон энэхүү судалгааны хүрээнд нягтлагдсан агуулга

	CN төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа	Судалгааны хүрээнд нягталсан агуулга
Үйл ажиллагаа①	Зудын урьдчилсан мэдээний үнэн зөвийг сайжруулж, үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх	Малчдын зудад дасан зохицох чадварыг сайжруулахад чиглэсэн ойлголт, үйл ажиллагааг тодорхой болгох, зудын урьдчилсан мэдээлэл дамжуулалтын байдал
Үйл ажиллагаа②	Зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр дүнтэй ашиглах,	Малчдын зудын урьдчилсан мэдээг хэрхэн хүлээн авч буй болон дамжуулж буйг судалж, программ хөгжүүлэлтийг хэлэлцэх, үр дүнтэй шинэ аргачлалыг санал болгох
Үйл ажиллагаа③	Нарны эрчим хүчийг ашигласан мах хөлдөөх, хадлалах систем (PV систем) нэвтрүүлэх	PV систем нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал, үр ашиг, тогтвортой байдлыг тоймлох
Үйл ажиллагаа④	Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээлтийг сайжруулах	Малчдын мал бэлтгэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээг ахин хэлэлцэх

6.1.1 Зудын урьдчилан таамаглах нарийвчлалыг сайжруулах, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр өгөөжтэй ашиглах

(1) Зудын урьдчилан таамаглах нарийвчлалыг сайжруулахад өгөх үнэлгээ

Зудын урьдчилсан мэдээлэл нь хэмжээ, чанар, давтамжийн хувьд хангалттай байгаа ба урьдчилсан мэдээллийн чанарыг сайжруулахаас илүүтэй малчид тухайн мэдээллийг ашиглан шаардлагатай арга хэмжээг авсанаар зудын хохирлыг багасгах боломжтой гэж үзэж байна (УЦУОСМХ-ий мэдээллээс). Зудын урьдчилан таамаглах мэдээллийн түгээхэд нэн чухал ач холбогдолтой байдаг нь өөрийн байгаа байршил нутаг гамшгийн эрсдэл маш өндөр болон өндөр эрсдэлтэй бүс нутагт хамаарч байгаа эсэх юм. Малчдын хувьд өөрсдийн туршлага дээр үндэслэн өгөгдсөн мэдээллийг сонгож, шаардлагатай авах ёстой арга хэмжээг сонгодог (малчдын судалгаанаас). Сүүлийн жилүүдэд ухаалаг утасны апп-р дамжуулан түгээж буй цаг агаарын урьдчилсан мэдээний үнэн зөв байдал сайжирч, салхины чиглэл, салхины хурд зэрэг цаг агаарын мэдээллийг үнэ төлбөргүйгээр хүлээн авах гэх мэт малчдын хүлээн авах боломжтой цаг агаарын мэдээллийн төрөл нэмэгдэж байна. Тиймээс урьдчилсан мэдээний нарийвчлалыг сайжруулах хэрэгцээ мэдээлэл дамжуулагч тал болон хүлээн авагч тал аль аль

нь шаардлагатай гэж үзэхгүй байна (УЦУОСМХ-ий мэдээлэл, малчдын судалгаанаас). Өнөөг хүртэл Мерси Корпс байгууллагаас хөгжүүлэлтийг нь хийн ОБЕГ-с бүс нутгийн хэмжээнд нарийвчилсан зудын мэдээллийг төлбөртэй гар утасны үйлчилгээгээр хангадаг байсан бол тухайн үйлчилгээ нь ч дата шинэчлэл нь ч зогссон байна. Одоогийн байдлаар малчдын талаас бага хувь нь ухаалаг гар утастай байгаа тул малчдаас ирэх мэдээлэлд үндэслэн урьдчилсан мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах хэмжээнд мэдээллийн хэрэгслүүд өргөн тархсан гэж хэлэхэд хэцүү. Тиймээс зудын урьдчилан таамаглах мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах гэхээсээ илүүтэйгээр гамшгийн эрсдэл өндөртэй бүсүүдэд малчид тухайн нөхцөлд тохирсон төрөл бүрийн дасан зохицох арга барилыг сонгох боломжтой учир зудын эрсдлийн мэдээллийг үнэн зөв дамжуулах, мэдээлэлд үзүүлж буй хариу үйлдлийн дагуу арга хэмжээ авах гэх мэт хоорондын уялдаа холбоо бүхий мэдээллийн түгээх хүлээн авах тогтолцоог бий болгох шаардлагатай.

(2) Тулгамдаж буй асуудал

Одоогийн байдлаар цаг агаарын гамшгийн эрсдлийн мэдээллийг захиргааны байгууллагаас (аймгийн цаг уурын газар, аймгийн онцгой байдлын газар гэх мэт) SMS мессежээр сум болон багийн даргаар дамжуулан малчдад илгээж байна. Мэдээлэл хүрсэн эсэхийг сум, багийн дарга нар малчин нэг бүр рүү утасдаж лавладаг. Богино хугацааны урьдчилсан мэдээ, яаралтай мэдээллийг сумын болон багийн дарга гэх мэт хүний хүчинд түшиглэн цаг алдалгүй дамжуулахад хүндрэлтэй байдаг. Мэдээллийг SMS-ээр дамжуулах нь мэдээллийг хурдан бөгөөд өргөн хүрээнд түгээх боломжтой хэдий ч илгээгч тал малчид мэдээллийг хүлээн авсан эсэхийг баталгаажуулах боломжгүй. Иймд малчид цаг агаарын гамшгийн мэдээ, тэр дундаа зудын урьдчилсан мэдээг найдвартай хүлээн авах механизмыг бий болгож, үр дүнтэй тэмцэх арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Малчдын дунд ухаалаг утас эзэмших хувь бага, гар утас эзэмших хувь өндөр (малчдын судалгаанаас үзэхэд) тул фэйсбүүк гэх мэт аппликейшн ашиглахаас илүүтэй SMS ашиглах нь мэдээлэл дамжуулахад илүү үр дүнтэй байдаг. Мессеж ашиглан мэдээлэл найдвартай дамжуулсан эсэхийг баталгаажуулах тогтолцоог бий болгох шаардлагатай.

6.1.2 Нарны эрчим хүч ашигласан мах хөргөх, хадгалах систем (PV систем)-ийг нэвтрүүлэх тухай

(1) PV системийн үнэлгээ

1) Туршилтаар ашиглаж буй PV систем


Зураг 6-1 нь одоо Монголд туршиж буй PV систем юм. Энэ нь хөргөлтийн компрессорыг асаах үеийн эрчим хүчийг хангахын тулд дизель генератор, грид хүчдэлтэй холбогдсон. Түүнээс гадна нарны эрчим хүчийг шөнийн цагаар гаргаж болдоггүй тул нарны эрчим хүчний хангамж нь PV системд ашиглагддаг эрчим хүчний 53%-ийг эзэлдэг. Мөн нарны эрчим хүч үйлдвэрлэх нь Монгол улсад өргөн хэрэглэгддэг бөгөөд одоо туршиж буй энэхүү PV системд Монголд байгаа тоног төхөөрөмжийг суурьлуулах боломжтой (МУИС-ийн профессор Амарбаяр).

Одоо Монголд ашиглагдаж байгаа PV системийн тоног төхөөрөмж нь Хятад, Герман, Швейцар улсад үйлдвэрлэсэн байна (Зураг 6-2, Хүснэгт 6-2).



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 6-1 Туршилтаар ашиглаж буй PV систем



Эх сурвалж: Hitachi Power Solutions XXK HP¹⁸

Зураг 6-2 Нарны эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмж

Хүснэгт 6-2 Монголд авах боломжтой нарны эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмж

	Тоног төхөөрөмжийн нэр	Гол үйлдвэрлэг (улс)	Нэмэлт
1)	Нарны хавтан	Jinko Solar (Хятад)	1Mw-д 27 цент
2)	Power conditioner	SMA (Герман)	Эрчим хүчний сүлжээнд цахилгааныг нийлүүлдэг хэсэг. Нэг ширхэг нь 20 сая иений үнэтэй. Өртөг нь нарны хавтантай ижил.
3)	Цахилгаан хураагч	SMA	Хавтанг холбогч
4)	Хяналтын систем (эрчим хүчний тоолуур)	ABB (Швейцар)	
5)	Холбох, дамжуулах кабель	(Хятад)	
6)	Өсгөгч трансформатор	(Хятад, Филиппин)	Гар аргаар засвар үйлчилгээ хийх шаардлагатай

Эх сурвалж: Судалгааны баг

¹⁸ <https://www.hitachi-power-solutions.com/energy/wind-solor/solar-power/system/index.html>


2) PV системийн дотоод дахь зах зээлийн хэрэгцээ болон нэвтрүүлэх, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай арга хэмжээ

Монгол Улсад нарны эрчим хүч үйлдвэрлэх бизнес 2017-2018 онд өргөжин хөгжиж байсан бол 2019 онд хуулийг шинэчлэн батлагдсанаар хувийн хэвшлийн санаачлагаар бус засгийн газрын санаачлагаар Эрчим хүчний яамнаас уг тоног төхөөрөмжийн үзүүлэлт, суурилуулалтын байршлыг шийдвэрлэдэг болсон. Өмнөх судалгааны үр дүнгээс харахад PV системийн ашигт ажиллагааг хангахын тулд үйлдвэрлэсэн цахилгаанаа худалдах нь зүйтэй гэж үзэж байсан ч Монголд цахилгааны төлбөр хямд тогтоосон байдаг мөн нарны эрчим хүч нь цахилгаан эрчим хүчнээс илүү үнэтэй байдаг тул ашиг олох нь хүндрэлтэй (нарны эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн компаниудын мэдээллээс).

3) PV систем нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал

Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны технологийн журам" (шинэчилсэн найруулга)-д 2023 оны 1-р сарын 1-нээс маханд нийлүүлэх малыг тусгай зөвшөөрөлтэй нядалгааны газарт нядалгаанд оруулна гэж заасан. Малчид зудын эсрэг арга хэмжээ болгон малаа эрт нядалгаанд оруулах, борлуулах хугацааг тохируулахын тулд нядалгааны байртай байх шаардлагатай тул зөвхөн хөлдөөгчийг суурьлуулсан ч амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд үр дүн өгөөгүй. Мөн шинэ хуульд махыг хөлдөөх температур $-25\text{--}35^{\circ}\text{C}$ гэж заасан бөгөөд одоогийн PV системийн -15°C -ийн температур нь шинэ хуулийн заалтуудад нийцэхгүй байна. Үүнээс гадна шинэ хуулинд малын эмч нарын хяналт шалгалт, хоол хүнс, хөргөлтийн техникчийг томилохоор заасан ба сумын түвшинд ийм тоног төхөөрөмжийг ажиллуулахад шаардагдах үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардлыг нягтлах шаардлагатай байна.

Зураг 6-3-т шаардлагатай тоног төхөөрөмжийг үзүүлэв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 6-3 Шаардлагатай тоног төхөөрөмж

4) PV системийн менежментийн туршилтын тооцоо

PV системийн үнэ нь холбогдох тоног төхөөрөмж зэрэг нэг багцын үнэ 20 сая иен (худалдагчийн тооцооллоос). Нэг хонины зах зээлийн үнэ 250,000 төг (10,000 иен) байна гэж үзвэл зөвхөн PV системийн анхны хөрөнгө оруулалтад 2000 хонь шаардлагатай болно. Энэ нь PV системд хадгалах боломжтой хонины тоо 350 (20 тн контейнер)-с бараг 6 дахин их юм. Нэг малчин өрх жилд 300 орчим мал борлуулдаг гэж үзвэл малчид болон малчдын бүлэгт PV системийг нэвтрүүлэх нь өндөр зардалтай. Түүнээс гадна PV систем нь тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, нарны хавтанг засварлах, удирдах, эрчим хүчний конденсаторуудын элэгдэл (Японд хуулиар 6 жил гэж тогтоосон) кабель муудсанаас болж солих зэрэг маш их зардал шаарддаг. Тиймээс энэ нь малчдад зардал өндөр, бусад орон нутгуудад нэвтрүүлэхэд ч хүндрэлтэй.

Энгийн хөлдөөгчтэй контейнерын үнэ нь 2 сая иен орчим байдаг ба малчид мал борлуулсан орлогоос авах боломжтой, сумын түвшинд нэвтрүүлэхэд нь эдийн засгийн хувьд ачаалал багатай, бодитой юм. Үүнээс гадна хөлдөөгчтэй контейнер нь -35°C хүртэл температурт хөлдөөх боломжтой байгаа нь хуулийн заалтанд нийцэж байгаа учир сумын түвшинд нэвтрүүлэхэд хөлдөөгчтэй контейнер хамгийн тохиромжтой гэж үзэж байна.

PV системийг нарны эрчим хүчээр цэнэглэж болох боловч, нийт шаардлагатай эрчим хүчний тал хувьд л хүрэлцэнэ. Монгол улсад цахилгааны төлбөр багаар тогтоодог. Засвар үйлчилгээний болон менежментийн зардалд эзлэх цахилгаан эрчим хүчний зардлын хувь нь бага байдаг. Хүснэгт 6-3-т хөлдөөгчтэй контейнерын цахилгаан эрчим хүчний өртөгийг үзүүлэв. Үүнээс өдрийн цагаар нарын эрчим хүчээр орлуулж болох цахилгааны зардал нь жилдээ 3,950,760 төг байгаа ба нэг хонины борлуулах үнийг 250,000 төг гэж тооцвол 16 хоньтой тэнцэх бөгөөд нарны эрчим хүчийг ашиглах нь зардал хэмнэхэд төдийлөн үр ашигтай биш байна.

Хүснэгт 6-3 Хөлдөөгчтэй контейнерын цахилгааны зардлын тооцоо

20 тн контейнер

Цаг	Ажиллах хугацаа		Нэгж үнэ (төг/ц)	Эрчим хүчний хэрэглээ (kwh)	Цахилгааны зардал (төг)		
					өдөр	сар	жил
Өдөр	06:00-17:00	11	164	6.00	10,824.00	324,720.00	3,950,760.00
Орой	17:00-22:00	5	256	6.00	7,680.00	230,400.00	2,803,200.00
Шөнө	22:00-06:00	8	105	6.00	5,040.00	151,200.00	1,839,600.00
Нийт					23,544.00	706,320.00	8,593,560.00
Татвар(10%)					25,898.40	776,952.00	9,452,916.00

Эх сурвалж: Судалгааны баг

40 тн контейнер

Цаг	Ажиллах хугацаа		Нэгж үнэ (төг/ц)	Эрчим хүчний хэрэглээ (kwh)	Цахилгааны зардал (төг)		
					өдөр	сар	жил
Өдөр	06:00-17:00	11	164	10.00	18,040.00	541,200.00	6,584,600.00
Орой	17:00-22:00	5	256	10.00	12,800.00	384,000.00	4,672,000.00
Шөнө	22:00-06:00	8	105	10.00	8,400.00	252,000.00	3,066,000.00
Нийт					39,240.00	1,177,200.00	14,322,600.00
Татвар(10%)					43,164.00	1,294,920.00	15,754,860.00

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Тулгамдаж буй асуудал

Малчид зудын урьдчилсан мэдээнд үндэслэн малаа нядалж, сумын түвшинд хөргүүрт хадгалах нь Монгол Улсын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний түгээлтийг сайжруулж, нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлнэ гэж найдаж байна. Нөгөөтэйгүүр, PV систем зэрэг нарийн тоног төхөөрөмжийг сумын түвшинд нэвтрүүлэхэд малчид өөрсдөө удирдаж, авч явуулах нь хүндрэлтэй (ХХААХҮЯ, орон нутагт хийсэн ярилцлагаас). Малчдын зудын таамаглалд дасан зохицох үйл ажиллагаа болгож мал нядлахаас илүү малын тэжээл бэлтгэл голчилж байна (малчдын судалгаагаар). Малчдын дасан зохицох үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд Монголын талын хэрэгцээ шаардлагад тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан Говь-Алтай аймгийн Бигэр сумд жимсний мод тариалахад ашигладаг усалгааны усыг хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн талбай руу өргөтгөх төлөвлөгөөг гаргасан бол Цогт суманд усалгааны нөхцөлд тэжээл тариалах төлөвлөгөөг боловсруулж байна (орон нутагт хийсэн аман судалгаанаас). Хэдийгээр Дундоговь аймагт малын тэжээл тариалах талаар тодорхой төлөвлөгөө байхгүй ч малын тэжээл бэлтгэхийн тулд нүүдэлчид өөрсдөө бэлчээр дээрээ хашаа барихыг зөвлөж байна, мөн хашсан талбайн хэмжээ аажмаар өргөжиж байна (орон нутагт хийсэн аман судалгаанаас).

Нөгөөтэйгүүр, нүүдлийн мал аж ахуйн нь бэлчээрийг сэлгэн нүүдэллэдэг тул тогтсон газар тэжээл тариалах нь уламжлалт мал аж ахуйд нийцэхгүй гэж үздэг. Гэвч сүүлийн жилүүдэд Монгол орны бэлчээрийн экосистем алдагдаж байгаа нь уур амьсгалд томоохон нөлөө үзүүлэхээс гадна бэлчээрийн өвсний чанар муудаж, улмаар махны салбар бүхэлдээ уналтад ороход хүргэж байгаа тул Монгол улсын экосистемийг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн хэвшлээс өөрчлөх шаардлага гарч байна (Махны холбооны мэдээллээс). Мөн боловсрол, эмнэлгийн тусламж үйлчилгээнд ойр байхын тулд гэрийн эзээр л бэлчээрт гарч гэр бүлийн бусад гишүүд тогтсон газраа суурин байх нь элбэг байдаг (орон нутагт хийсэн аман судалгаанаас). Нийгмийн тогтолцооны өөрчлөлтийг дагаад Монголын бэлчээрийн мал аж ахуй ч өөрчлөгдөж, олон төрлийн бэлчээрийн аж ахуйг бий болгох талаар анхаарч байна. Эдгээр зорилгын үүднээс бэлчээрийн ашиглалтын төлөвлөгөөг эргэн харж, малын тэжээлээр өөрийгөө хангах боломжтой бэлчээрийн ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна. Үүний үр дүнд малын тэжээлийн бэлчээрээс хараат байдлаас ангижрах, бэлчээрийн экосистемийг сэргээх механизмыг бий болгох эрэлт хэрэгцээ гарч байна. Тэжээлийн нөөцийг баталгаажуулахын тулд бэлчээрийн ургамлыг хамгаалах шаардлагатай. Нам бут сөөг тарих гэх мэт үндсэн эх ургамлыг сэргээх шаардлагатай. Ингэж ургамлыг хамгаалахын тулд малчид өөрсдөө ургамлын нөхөн сэргэлтийн байдалд хяналт тавих зэрэг бэлчээрийн бодит үнэлгээг хийх замаар малчдын ойлголт, сэтгэхүйг өөрчлөх шаардлагатай.

Түүнчлэн махны үнэ малын жингээс ихээхэн хамааралтай учир зөвхөн борлуулалтын зохицуулалтаас хамаарсан улирлын үнийн зөрүү нь орлогыг нэмэгдүүлэхэд үр дүнгүй байна. Малын борлуулалтаас олох ашгийг нэмэгдүүлэхийн тулд малыг эрүүл, тарга сайн авахуулах нэн чухал ба малын тэжээлийг бэлддэг болох нь бэлчээрийн доройтлоос хамгаалаад зогсохгүй нэмүү өртөг өндөр шингэсэн үйлдвэрлэлд нөлөөтэй байж, энэ нь нүүдэлчдийн амьжиргааг дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

6.1.3 Хүнсний аюулгүй байдлыг өндөр хэмжээнд хангах шаардлагатай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба түгээлтийг сайжруулах

(1) Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний түгээлтийг сайжруулахад өгөх үнэлгээ

Монгол улсын засгийн газар шинэ хуулиар мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн шинэ сүлжээг бий болгохыг зорьж байна. Монгол улсын мал аж ахуйн үйлдвэрлэл дотоодын хэрэглээнээс давсан тул цаашид гадаадад экспортлох, олон улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг шинэ хуульд үндэслэн шинээр бий болгохын тулд зөвхөн хөлдөөгч суурилуулахаас гадна мал нядалгааны болон боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх нь зүйтэй. Сумын хэмжээнд засвар үйлчилгээ хийх боломжтой, хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авах боломжтой байгууламжуудыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр, уламжлалт аргаар бэлтгэсэн махыг хэрэглэхийг эрхэмлэдэг тодорхой тооны хэрэглэгчид байгаа тул ийм төрлийн зах зээлд нийлүүлэх зохицуулалтыг хийх мөн шаардлагатай байна (Махны холбооны мэдээллээс).

Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг шинэ хуульд үндэслэн дахин бүрэлдүүлэхэд байгууламжийн менежментийн хүний нөөцийг хөгжүүлэх нь нэн чухал. Техник мэргэжлийн зэрэг эзэмшүүлэхэд чиглэсэн их, дээд сургуулиудын төрөлжсөн сургалтуудыг сайжруулж, тухайн салбарын ажилчдад техникийн байнгын удирдлагаар хангаж, мэргэжлийн зэргээ ахиулдаг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

1) Зардлын тооцоо

Мал нядалгааны газар байгуулах тухай асуудлыг шинээр батлагдсан хуульд тусгасан бөгөөд барих зардлыг тухайн мужид хуваарилсан бүтээн байгуулалтын зардлаас гаргах нь зүйтэй. Сумын түвшинд барьж, удирдах боломжтой хэмжээг тооцоходоо Японы зэрлэг амьтны мах боловсруулах байгууламжийг (ангийн мах) жишиг болгон ашиглаж болно. Маш энгийн хийцтэй байгууламж ойролцоогоор 3 сая иен (75 сая төг) бөгөөд, харин тодорхой стандартын дагуу баригдсан байгууламж 50 орчим сая иен (1.25 тэрбум төг) байдаг.

Хөлдөөгчний хувьд энгийн хөлдөөгчтэйг контейнер байрлуулах нь зүйтэй бөгөөд үнэ нь 50 орчим сая төг өртөгтэй байна. Хөлдөөгчтэй контейнеыг малчид болон хоршоо голлон хариуцах тул малчдын хөрөнгөөр, сумын төсвөөс худалдаж авах нь зүйтэй.

Шинээр батлагдсан хуулинд, хүнсний технологич, хөргөлтийн техникч гэсэн 2 мэргэжилтэн томилон ажлуулна гэж заасан ба үүнд зарцуулагдах хүний нөөцийн зардал сард 2,860,706.25 төг байна (Хүснэгт 6-4).

Хүснэгт 6-4 Хүний нөөцийн зардлын тооцоо

		Сарын цалин (төг)	Жилийн цалин (төг)
Хүнсний технологич	Цалин	1,200,000.00	14,400,000.00
	Амралтын өдрийн тэтгэмж	71,425.00	857,100.00
Хөргөлтийн техникч	Цалин	1,200,000.00	14,400,000.00
	Амралтын өдрийн тэтгэмж	71,425.00	857,100.00
Нийт		2,542,850.00	30,514,200.00
Нийгмийн даатгал (12.5%)		317,856.25	3,814,275.00
Нийт дүн		2,860,706.25	34,328,475.00

Эх сурвалж: Судалгааны баг

2) Үйл ажиллагааны тооцоо

Нэг тоо толгой хонины борлуулах үнийг 250,000 төг, 20 тн багтаамжтай контейнерт 350 гулууз, 40 тн багтаамжтай контейнерт 700 гулууз хадгалах боломжтой гэж үзэн орлого зарлагын тооцоог гаргасан (Хүснэгт 6-5). Энэхүү үйл ажиллагааны тооцоогоор цахилгааны бүх зардал нь цахилгаан эрчим хүчээр тооцсон бөгөөд тоног төхөөрөмжийн анхны хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээтэй холбоотой зардлууд ороогүй байна.

20 тн багтаамжтай контейнерт 350 хонины мах хадгалах боломжтой ба үүнээс 167 нь ашиглалтын зардалтай тэнцэнэ. Үлдсэн нэг хонинд ногдох орлого 130,420 төг болно. 40 тн контейнерт 700 хонины мах хадгалах боломжтой ба үүнээс 193 нь ашиглалтын зардалтай зарцуулагдана гэж тооцвол үлдсэн нэг хонинд ногдох орлого 181,207 төг болно. Ашиглалтын зардалд хүний нөөцийн зардлын эзлэх хувь өндөр ба багтаамж өндөртэй 40 тн-н контейнерыг суурьлуулсанаар нэг тоо толгой хонинд ноогдох орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Контейнер том байх тусмаа бүтээгдэхүүнийг оруулж гаргах, үлдэгдлийг хянахад хүндрэлтэй болох, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зардал өндөр гэх мэт асуудлууд байж болох ч сумын түвшинд хөлдөөгчтэй контейнер суурьлуулах нь малчид мал борлуулж орлого олох бүрэн боломжтой.

Хүснэгт 6-5 Хөлдөөгчтэй контейнерын орлого, зарлагын тооцоо (төг)

Контейнерын төрөл	Тооцоо	Зардал	Үнийн дүн (төг)
20 тн контейнер	1. Орлого	Хонь борлуулах	87,500,000
	2. Үйл ажиллагааны зардал	Цахилгаан	9,452,916
		Хүний нөөц	32,400,000
		Дүн	41,852,916
3. Ашиг		45,647,084	
40 тн контейнер	1. Орлого	Хонь борлуулах	175,000,000
	2. Үйл ажиллагааны зардал	Цахилгаан	15,754,860
		Хүний нөөц	32,400,000
		Дүн	48,154,860
3. Ашиг		126,845,140	

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Тулгамдаж буй асуудал

Хонины нийт орлого нь борлуулалтын үнийн дүнгийн 70 орчим хувьтай тэнцэж байгаа ч хуульд заасан стандартын дагуу бэлтгэсэн мах учир нь бусад махнаас ялгагдах давуу тал болно. Түүнчлэн гарал үүслийг мөрдөх тогтолцоог нэвтрүүлэхэд хялбар, бүс нутгийн брэндийг бий болгох боломжтой болж, нэмүү өртөг өндөртэй мах нийлүүлснээр борлуулалтын сувгийг тэлэх боломж бүрдэнэ.

Сумын түвшинд мах нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгосноор худалдан авагчийн зах зээлээс борлуулагчийн зах зээл рүү шилжих, мал борлуулах боломжийг бүрдүүлэх, малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой. Мал борлуулах боломж нэмэгдснээр малын тоог цөөрүүлэх боломж нэмэгдэж, улмаар бэлчээр ч сэргэнэ гэж үзэж болно.

6.2 Энэхүү судалгааны үр дүн ба тулгамдаж буй асуудлын эсрэг авах арга хэмжээ

Одоогийн төлөвлөгөөг нягталж үзсэний үр дүнд зарим урьдчилсан нөхцлүүдийг шинэчлэх шаардлага бий болох нь тодорхой болсон. Хүснэгт 6-6-д төслийн агуулгыг өөрчлөлттэй холбогдох агуулга бүхий судалгааны үр дүн, тэдгээрт үндэслэн санал болгож буй шинэ үйл ажиллагааг харуулав. Шинэ төлөвлөгөө нь дараах гурван үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд тус бүрийн тодорхой агуулгыг дараагийн бүлэгт тайлбарлах болно.

Үйл ажиллагаа-1: Зудын урьдчилан таамаглах мэдээллийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа-2: Малын тэжээл бэлтгэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа-3: Технологийн журамд үндэслэсэн, мах түгээлтийн системийг бий болгох

Хүснэгт 6-6 Одоо байгаа төлөвлөгөөний тухай судалгааны үр дүн ба шинээр дэвшүүлэх үйл ажиллагааны санал

Одоо байгаа төлөвлөгөөний CN агуулга	Одоо байгаа төлөвлөгөөний үйл ажиллагааны агуулга	Энэ удаагийн судалгааны үр дүн	Шинээр дэвшүүлэх үйл ажиллагааны санал
<p><u>Component1:Малчдын дасан зохицох чадавх</u> Activity1-1 : Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг МХТ-ийн тусламжтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх Activity1-2: Бүтэц зохион байгуулалтын дэмжлэг Activity1-3: Нарны эрчим хүч ашигласан хөргөлттэй агуулах Activity1-4: Өндөр чанартай махны үйлдвэрлэл Activity1-5: Малын эмч нарын чадавхыг бэхжүүлэх Activity1-6: ХАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ</p> <p><u>Component2:Засаг захиргааны чадавх</u> Activity2-1: Зудын эрсдэлийг урьдчилан тооцоолох нарийвчлал Activity2-2: Засаг захиргааны хэрэгжүүлэх зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ Activity2-3: Орон нутгийн засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлэх зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ</p>	<p>Үйл ажиллагаа ①: Зудын урьдчилсан мэдээний үнэн зөвийг сайжруулж, үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх</p> <p>Үйл ажиллагаа ②: Зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр дүнтэй ашиглах</p> <p>Үйл ажиллагаа ③: Нарны эрчим хүчийг ашигласан мах хөлдөөх, хадлалах систем (PV систем) нэвтрүүлэх</p> <p>Үйл ажиллагаа ④: Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээлтийг сайжруулах</p>	<p>• Малчдад мэдээлэл хүрч байгаа ба үнэн зөв байдалд асуудал байхгүй.</p> <p>• Гамшиг болохоос өмнө урьдчилсан мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулсан ч малчид зудын эсрэг арга хэмжээгээ өөрчлөхөд хүндрэлтэй.</p> <p>• Илгээгч тал мэдээлэл баталгаатай илгээгдсэн эсэхийг нягтлах боломжтой болсноор мэдээллийг илгээгч болон хүлээн авагч тал аль аль нь нягтлах боломж бүрдэх ба гамшигийн эрсдэлийг багасгах боломжтой.</p> <p>• Махны үнэ малын жингээс ихээхэн хамааралтай ба зуд болохоос урьдчилж малын нядалгаанд оруулах малын тоо өсөлт нөлөөлсөн гэж үзэх хангалтгүй.</p> <p>• Малаа эрүүл бойжуулж, тарга сайн авахуулж, өндөр үнээр борлуулах нь орлого нэмэгдүүлэхэд илүү үр дүнтэй.</p>	<p><u>Үйл ажиллагаа -1:</u> <u>Зудын урьдчилсан мэдээний үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх</u> <u>Үйл ажиллагаа 1-1: Илгээгч болон хүлээн авагчийн хооронд мэдээлэл дамжуулах хоёр талын баталгаажуулалтыг хийх SMS функцийг сайжруулснаар төр, малчдын хоорондын харилцаа холбоог сайжруулах.</u> <u>Үйл ажиллагаа 1-2: Малчдын мэдээллийн санг хөгжүүлснээр мэдээлэл дамжуулах үр ашгийг дээшлүүлэх</u></p> <p><u>Үйл ажиллагаа-2:</u> <u>Малын тэжээл бэлтгэх замаар мал аж ахуйн салбарыг бэхжүүлэх</u> <u>Үйл ажиллагаа 2-1: Сумын хэмжээнд бэлчээрийн ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж бэлчээрийн газрыг оновчтой ашиглах</u> <u>Үйл ажиллагаа 2-2: Хадлангийн газрыг тогтоож, хадлан бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах замаар тэжээлийг төрөлжүүлэх, тэжээл хангамжийг тогтвортой болгох</u> <u>Үйл ажиллагаа 2-3: Ургамлыг хамгаалах замаар бэлчээрийг нөхөн сэргээх, хяналт тавих</u></p>
		<p>• Шинээр батлагдсан мах түгээлтийн технологийн журамд нийцсэн махны үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог бүрдүүлснээр малчдын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.</p>	<p><u>Үйл ажиллагаа-3:</u> <u>Технологийн журамд үндэслэн мах түгээлтийн системийг бий болгох</u> <u>Үйл ажиллагаа 3-1: Технологийн журамд нийцсэн мал нядалгааны газар, хөргүүртэй агуулахыг сумын хэмжээнд байгуулж, махны шинэлэг байдлыг хадгалах технологи бүхий мах нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгох</u> <u>Үйл ажиллагаа 3-2: Мал эмнэлгийн нэгдсэн системд холбогдсон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх</u> <u>Үйл ажиллагаа 3-3: Хүнсний технологчдыг бэлдэх</u></p>

7-р бүлэг Шинээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал

Дээр дурдсан үр дүнд тулгуурлан дараах шинээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санал болгож байна.

7.1 Төслийн хүрээ

(1) Төслийн зорилго

Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдаг малчдын зудыг тэсвэрлэх чадварыг бэхжүүлж мал аж ахуйн тэсвэрлэх чадавхыг бий болгох

(2) Үр дүн

Үр дүн 1: Засаг захиргаа болон малчдын цаг уурын гамшигт дасан зохицох чадавх бэхжинэ.

Үр дүн 2: Бэлчээр сэргэж өндөр нэмүү өртөг бүхий мал үйлдвэрлэл хэрэгжинэ.

Үр дүн 3: Зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон борлуулалт хэрэгжинэ.

(3) Үйл ажиллагаа

Үйл ажиллагаа 1: Зудын урьдчилсан мэдээ ашиглалтын чадавхыг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 1-1: Мэдээ илгээгч болон хүлээн авагч талын аль аль нь мэдээлэл дамжуулсныг нягтлах боломжтой SMS функцийг сайжруулж засаг захиргаа болон малчдын хоорондын мэдээлэл харилцааг сайжруулах

Үйл ажиллагаа 1-2: Малчдын мэдээллийн сан байгуулж мэдээлэл дамжуулах үр ашгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 2: Малын тэжээл бэлтгэлийг сайжруулж мал аж ахуйн чадавхыг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2-1: Сумын түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж бэлчээрийг зохистой ашиглах

Үйл ажиллагаа 2-2: Хадлангийн газрыг тодорхой болгож хадлан бэлдэх, тэжээлийн ургамал тариалах замаар малын тэжээлийг төрөлжүүлж тэжээл бэлтгэлийн тогтвортой байдлыг хангах

Үйл ажиллагаа 2-3: Ургамал хамгааллыг хэрэгжүүлж бэлчээрийн нөхөн сэргэлтийг хангах, хяналт мониторингийг хэрэгжүүлэх

Үйл ажиллагаа 3: Технологийн шинэчилсэн журамд нийцсэн махны хангалт нийлүүлэлтийн тогтолцоог байгуулах

Үйл ажиллагаа 3-1: Шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулахыг сумын түвшинд байгуулж, шинэлэг чанарыг хадгалах технологи бүхий махны нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгох

Үйл ажиллагаа 3-2: Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбосон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх

Үйл ажиллагаа 3-3: Хүнсний технологич бэлтгэх

(4) Хамрах бүс нутаг

Монгол Улсын Дундговь аймаг, Говь-Алтай аймаг

(5) Төсөл хэрэгжүүлэх хугацаа

2025 – 2030 он (5 жил)

(6) Төсөл хамтран хэрэгжүүлэх байгууллага


ХХААХҮЯ, БОАЖЯ, УСЦУОСМХ, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Дундговь аймгийн ЗДТГ, Говь-Алтай аймгийн ЗДТГ

Зураг 7-1-д төслийн хүрээ болон Зураг 7-2-т төслийн үйл ажиллагааны ерөнхий агуулгыг үзүүлэв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-1 Шинээр хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагааны ерөнхий агуулгын бүдүүвч



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-2 Үйл ажиллагааны ерөнхий агуулга

7.2 Үйл ажиллагаа 1: Зудын урьдчилсан мэдээний ашиглалтын чадавхыг бэхжүүлэх

Зудаас хамгаалах зохистой арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд зудын урьдчилсан мэдээнд тулгуурлан малчид авч хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээний сонголтыг нэмэгдүүлэх нь нэн чухал байна. Малчид бие даан хэрэгжүүлэх зудаас хамгаалах арга хэмжээнээс гадна улс болон орон нутгийн засаг захиргаанаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг цаг тухайд нь хүлээлт болон хомсдол үүсгэхгүйгээр малчдад хүргэхийн тулд засаг захиргаа болон малчдын хоорондын мэдээлэл харилцааг улам бэхжүүлж, мэдээлэл дамжуулах болон удирдах тогтолцоог сайжруулна.

7.2.1 Үйл ажиллагаа 1-1: Мэдээ илгээгч болон хүлээн авагч талын аль аль нь мэдээлэл дамжуулсныг нягтлах боломжтой SMS функцийг сайжруулж засаг захиргаа болон малчдын хоорондын мэдээлэл харилцааг бэхжүүлэх

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд SMS илгээх, хүлээн авах функцийг сайжруулж, засаг захиргааны байгууллагаас илгээсэн мессежийг малчид хүлээн авсан эсэхийг мэдэх боломжтой SMS баталгаажуулалтын системийг хөгжүүлж нэвтрүүлнэ.

(1) Агуулга

Харилцаа холбооны оператор компаниудад байдаг SMS илгээсэн эсэх статусын мэдээлэл (Хүснэгт 7-1)-ийг багийн засаг даргад хангаж байдаг системийг хөгжүүлж нэвтрүүлнэ. Статусын мэдээллийн дотор засаг захиргааны байгууллагаас илгээсэн мессежийг хүлээн аваагүй малчид (Хүснэгт 7-1-д үзүүлснээр, “уншсан” статусаас бусад малчид)-ыг тодорхой болгож, тус бүрээр нь хянаж, шаардлагатай мэдээлэл хүргэх боломжтой орчныг бүрдүүлнэ. Ингэснээр засаг захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх тусламж (нүүлгэн шилжүүлэх бүсийг тодорхой болгох, нөөцийн тэжээлийн нөхцөл байдал, гамшгийн үеийн шуурхай удирдлагын талаарх мэдээлэл гэх зэрэг)-ийг малчдад найдвартай хүргэхэд зохистойгоор нөлөөлж, малчдын зудын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний сонголт нэмэгдэх зохистой орчин бүрдэнэ.

Мэдээлэл дамжуулах үйл явцын бодит жишээг авч үзвэл, Дундговь аймгийн 8,000 малчин өрх рүү утсаар залгах ($60 \text{ төг/мин} \times 8,000 \text{ өрх} = 480,000 \text{ төг}$) болон дан SMS илгээх ($20 \text{ төг/мин} \times 8,000 \text{ өрх} = 160,000 \text{ төг}$) тохиолдлыг харьцуулаад үзэхэд нэг удаа мэдээлэл дамжуулахад 320,000 төгрөг хэмнэх боломжтой байна.

Хүснэгт 7-1 SMS статусын мэдээллийн төрөл

Статусын мэдээлэл	Агуулга
Илгээсэн байна	Хүлээн авагчид мэдээлэл очсон боловч уншаагүй байна
Илгээгээгүй байна	Хүлээн авагчид мэдээлэл хүрээгүй байна. Утсаа унтраасан, эсвэл сүлжээгүй байна
Алдаа	Утасны дугаар буруу гэх мэт
Уншсан	Хүлээн авагч мэдээллийг хүлээн авсан


Эх сурвалж: Судалгааны баг

(2) Үйл ажиллагаа

- ① Харилцаа холбооны оператор компанитай хамтран SMS статус уншдаг програм боловсруулах.
- ② Багийн даргыг шаардлагатай компьютер, дагалдах төхөөрөмжөөр хангах.
- ③ Мэдээллийн технологийн сургалтад багийн даргыг хамруулж статусын мэдээллийг хянах мэдлэг чадварыг бүрдүүлэх.

Зураг 7-3-т үйл ажиллагааны ерөнхий дүр зургийг үзүүлэв.

Статусын мэдээлэл багийн даргын компьютерт автоматаар сууж, хүснэгт (эксел)-ээр удирдаж хянана. Эксел хүснэгтийн загварыг Хүснэгт 7-2-т үзүүлэв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-3 SMS функцийн сайжруулалтын үр дүн

Хүснэгт 7-2 Багийн даргын хөтлөх хяналтын эксел хүснэгт

Малчны нэр	Холбоо барих мэдээлэл	Мэдээллийн төрөл	Мэдээлэл хүлээн авсан эсэх	Малчинтай холбогдохын тулд авах арга хэмжээ
		<ul style="list-style-type: none"> Дунд, урт хугацааны урьдчилсан мэдээ Ойрын хугацааны урьдчилсан мэдээ Шуурхай мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> Илгээгдсэн Илгээгдээгүй Алдаа Уншсан 	<ul style="list-style-type: none"> Утсаар дахин холбоо барих Өөрийн биеэр очих Ойр орчмын малчинтай холбоо барих Бусад

Эх сурвалж: Судалгааны баг

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-3-т SMS функцийг сайжруулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг үзүүлэв.

Хүснэгт 7-3 SMS функцийг сайжруулахад шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Програм хангамж хөгжүүлэлтийн зардал	Харилцаа холбооны оператор компанийн статусын мэдээлэл хүлээн авч илгээх зориулалтын файл болгох програм боловсруулах	20,000	1	20,000	
Тоног төхөөрөмжийн зардал	Багийн даргын компьютер	700	10	7,000	5 баг / 1 сум 2 сум / аймаг
Сургалтын зардал		1,000	6	6,000	2 сум / аймаг 3 жил
Нийт				33,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.2.2 Үйл ажиллагаа 1-2: Малчдын мэдээллийн сан байгуулж мэдээлэл дамжуулах үр ашгийг нэмэгдүүлэх

Энэхүү үйл ажиллагаагаар малчдын үндсэн мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан байгуулж ашиглана.

(1) Агуулга

Засаг захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлдэг арга хэмжээг бэхжүүлэхийн тулд малчдын мэдээллийн сан байгуулж, түүнийг ашиглах малчдын мэдээллийн системийн хөгжүүлэлтийг хийнэ. Жил бүрийн статистикийн мэдээлэл болон малчдын үндсэн мэдээллийг SMS илгээснийг нягтлах системтэй холбож, зудын эсрэг арга хэмжээтэй уялдуулахыг зорино. Мөн, малын тэжээлийн бэлтгэлийн байдал, өвс тэжээлийн зах зээлийн мэдээллийг нэгтгэж, МЭЕГ-ын МАНИС системтэй холбоно.

(2) Үйл ажиллагаа

- ① Мэдээллийн санд оруулах мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоож, мэдээллийн сан байгуулах.
- ② Сумын түвшинд систем ашиглахад хэрэглэх гарын авлага боловсруулж, мэдээллийн сангийн ашиглалтыг хэвшүүлэхэд чиглэсэн заавар боловсруулах.
- ③ Сумын ЗДТГ-ын албан хаагч нарыг сургагч багш болгоход чиглэсэн сургалт (сургагч багш бэлтгэх сургалт, багийн засаг дарга нарт зориулсан сургалт)-ыг үе шаттайгаар зохион байгуулах.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-4 Багийн засаг дарга нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтад шаардагдах хөрөнгө оруулалт


Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зардал	Компьютертэй ажиллах сурах бичиг, мэдээллийн хяналт удирдлагын гарын авлага боловсруулах	5,000	2	10,000	2 сум / аймаг
Сургалтын зардал		1,000	6	6,000	2 сум / аймаг 3 жил
Нийт				16,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.3 Үйл ажиллагаа 2: Малын тэжээл бэлтгэлийг сайжруулж мал аж ахуйн чадавхыг бэхжүүлэх

Зуд гэх мэтийн цаг уурын аюулт үзэгдлээс үүдэх эрсдэлийг бууруулахын тулд байгалийн бэлчээрийн хараат байдлыг багасгаж, бэлчээрийн экосистемийг сэргээх шаардлагатай байна.

Үүний тулд, дан ганц бэлчээрт тулгуурлаагүй мал аж ахуйд чиглэсэн малчдын хандлагыг бий болгож, олон төрөлт малын тэжээл бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх замаар бэлчээрийн экосистемийг сэргээнэ. Зураг 7-4-т үйл ажиллагааны ерөнхий агуулгыг үзүүлэв.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-4 Үйл ажиллагаа 2-ын ерөнхий агуулга

7.3.1 Үйл ажиллагаа 2-1: Сумын түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж бэлчээрийг зохистой ашиглах

Бэлчээрийн бодит нөхцөл байдлыг дахин нягталж, хадлангийн газар болон тэжээлийн ургамал тариалах боломжтой болон ургамал хамгаалал хийх бүс нутгийг тодорхой болгож бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах.

(1) Агуулга

Малын тэжээлийн хангамж, бэлтгэлийг тогтвортой байлгахын тулд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулна. Уг төлөвлөгөөг малчдын оролцоотой боловсруулж, ингэснээр дан ганц бэлчээрт тулгуурлахгүй олон төрөлт малын тэжээлийн бэлтгэлд чиглэсэн малчдын хандлагыг бий болгохыг зорино.

(2) Үйл ажиллагаа

- ① Малчдын оролцоо бүхий сургалт зохион байгуулах.
- ② Бэлчээрт агуулагдах олон талын үр өгөөжийг дахин нягталж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах.
- ③ Малчдын мал аж ахуйд ашигладаг газар нутгийг бэлчээр (отрын бэлчээрийг хамруулна), хадлангийн газар, тэжээл тариалалтын талбай, ургамал хамгааллын бүс нутаг гэж ангилна.
- ④ Бүс нутаг тус бүрт шаардагдах

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-5 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Сургалтын зардал	Сургалт (воркшоп)-ын зардал	5,000	2	10,000	2 сум / аймаг
Нийт				10,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.3.2 Үйл ажиллагаа 2-2: Хадлангийн газрыг тодорхой болгож хадлан бэлдэх, тэжээлийн ургамал тариалах замаар малын тэжээлийг төрөлжүүлж тэжээл бэлтгэлийн тогтвортой байдлыг хангах

Дан ганц бэлчээрт тулгуурлахгүй, олон төрлийн малын тэжээл бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Малчид малын тэжээл худалдаж авахад жилд 1 сая орчим төгрөг зарцуулдаг бөгөөд энэ нь үйл ажиллагааны нийт зардлын 25%-ийг эзэлж байна. Иймээс, малын тэжээлийн хэрэгцээг өөрсдөө хангаснаар зардал хэмнэгдэх ач холбогдлыг малчдад ойлгуулж, урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг хэвшүүлэхэд чиглэсэн аж ахуйн хэв маягийг шинэчлэхэд нөлөө үзүүлнэ.

(1) Агуулга

7.3.1-д заасны дагуу боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд үндэслэн бэлчээрийг хашаажуулах, малчид хоорондоо тохиролцож тогтоосон хадлангийн газрыг хамгаалах, малын тэжээлийн ургамал тариалах, хэт доройтсон бэлчээрийн ашиглалтыг хязгаарлах гэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

(2) Үйл ажиллагаа

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд үндэслэн малын тэжээл бэлтгэх үйл ажиллагаанд анхаарсан бэлчээр ашиглалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Одоогийн байдлаар хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагааг доор дурдав.

- ① Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг тодотгох.
- ② Шалгуур үзүүлэлтийг тогтоож зохих хоршоог сонгож авах.
- ③ Өвөлжөө орчмын хадлангийн газрыг хамгаалах, ургамал хамгааллын зорилгоор хашаажуулах.
- ④ Бэлчээрийн өвс, малын тэжээлийн ургамал тариалалтыг туршилтын журмаар суманд хэрэгжүүлэх.
- ⑤ Малчдад тэжээлийн ургамал тариалалтын технологийн талаар сургалт зохион байгуулах.
- ⑥ Талбай томтой хадлангийн газар болон тэжээлийн ургамал тариалахад ашиглах газар тариалангийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний компани байгуулах боломжийн талаар судлах.
- ⑦ Сум, баг, хоршоо нь үйл ажиллагааны хяналт мониторингийг хэрэгжүүлэх.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-6 Малын тэжээл бэлтгэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Тоног төхөөрөмжийн зардал	Өвөлжөө орчмын газрыг хашаажуулах	2,000	40	80,000	20 газар / сум 2 сум / аймаг
Тоног төхөөрөмжийн зардал	Бэлчээрийн өвс, тэжээлийн ургамлын үр	2,000	2	4,000	2 сум / аймаг
Сургалтын хэрэглэгдэхүүний зардал	Тариалалтын технологийн гарын авлага боловсруулах зардал	5,000	2	10,000	2 сум / аймаг
Сургалтын зардал	Тариалалтын технологийн сургалт	50,000	6	300,000	2 сум / аймаг 3 жил
Нийт				394,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.3.3 Үйл ажиллагаа 2-3: Ургамал хамгааллыг хэрэгжүүлж бэлчээрийн нөхөн сэргэлтийг хангах, хяналт мониторингийг хэрэгжүүлэх

Говийн бүс нутагт хаврын улирлын хүчтэй салхинаас үүдсэн шороон шуурганы хор уршиг их байна. Өнөөдрийг хүртэл бутлаг ургамлын тархацаар элсний нүүдлийг хязгаарладаг байсан боловч бэлчээр доройтохын зэрэгцээ бутлаг ургамлыг малын тэжээл болон түлш болгон ашигласнаар ургамлын тархац багасч элсний нүүдэл илүү эрчимжиж, ялангуяа говийн бүсийн нутагт шороон шуурга үүсэх шалтгаануудын нэг болоод байна. Ийм учраас, бутлаг ургамлын тархацыг нэмэгдүүлж өвс ургамал илэрхий доройтсон бүс нутгийн хөрс хамгааллыг хэрэгжүүлнэ.

(1) Агуулга

Говийн бүс нутгийн уугуул бутлаг ургамал болох заг, хайлаас зэргийг тариалж, элсний нүүдэл, цөлжилтийг тогтоох зэргээр хөрсийг хамгаалж, бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Мөн, Үйл ажиллагаа 2-2-ын хүрээнд хэрэгжүүлэх хадлангийн газар, тэжээлийн ургамал тариалах талбайн ойр орчимд бутлаг ургамал тариалж, элсний нүүдлийг зогсоож, газрын зохистой ашиглалтыг хангана. Ургамлын нөхөн сэргээх үйл ажиллагаанд малчдын өөрсдийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх нь нэн чухал бөгөөд ургамлын хяналт мониторингийг малчид өөрсдөө хийж гүйцэтгэх нь ойлголт ухамсрыг дээшлүүлэхэд чухал түлхэц болно.

(2) Үйл ажиллагаа

- ① Тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу малчдыг бүлэг болгон хуваах.
- ② Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд заасны дагуу өвс ургамал ихээр доройтсон бэлчээрт ургамалжуулалт хийх.
- ③ Тэжээлийн ургамал тариалалтын газрыг хамгаалах зорилгоор ойр орчимд бутлаг ургамал тариалж, салхи шуурганаас хамгаалах бага хэмжээний ой, төгөл бий болгох. Бутлаг ургамлын хувьд тухайн бүс нутгийн цаг уурын онцлогийг харгалзаж хайлаас зэрэг жимст мод тариалах талаар судлах.
- ④ Ургамал хамгаалал, хяналтын сургалтыг зохион байгуулж, ургамалжуулалт ойжуулалт хийсний дараах ургамлын нөхөн сэргээлтийн явцыг малчид болон хоршооны гишүүд ухаалаг утсаар дүрсжүүлж баримтжуулснаар хяналт мониторингийг хийж гүйцэтгэх.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-7 Малын тэжээл бэлтгэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Тоног төхөөрөмжийн зардал	Бутлаг ургамлын суулгац, ойжуулалтын үйл ажиллагааны зардал	2,000	2	4,000	2 сум / аймаг
Сургалтын зардал	Ойжуулалт хийсний дараах ургамлын хяналт мониторинг	50,000	6	300,000	2 сум / аймаг 3 жил
Нийт				304,000	1 аймаг ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.4 Үйл ажиллагааг 3: Технологийн шинэчилсэн журамд нийцсэн махны хангалт нийлүүлэлтийн тогтолцоог байгуулах

Монголын мал аж ахуйн нөөц баялаг нь их бөгөөд дэлхий дахинд хүнсээр хангадаг гол улс орнуудын нэг болох нөхцөл бололцоог агуулдаг боловч нөгөөтэйгүүр олон улсын стандартын шаардлага хангаж чаддаггүй, чанарын түвшин доогуур байгаа нь дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар хараахан муу байгааг харуулж байна.

Тиймээс, уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл болон зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас шинээр боловсруулан баталсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтад нийцүүлсэн мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээг сумын түвшинд байгуулж, мөшгих системийг бэхжүүлж, хүнсний технологич бэлтгэх ажлыг хэрэгжүүлнэ. Зураг 7-5-д уг үйл ажиллагааны ерөнхий агуулгыг үзүүлэв.

Мөн, шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн мах, махан бүтээгдэхүүний хангалт нийлүүлэлтийн тогтолцоог байгуулснаар малчид малаа борлуулах зохистой орчин нөхцөл бий болж, улирлаас үл хамааран мал болон махаа өндөр үнээр борлуулж малын нэг тоо толгой тутмаас ногдох ашгийг нэмэгдүүлж, малын тоо бус чанарт шилжих хандлага ухамсрыг малчдын дунд бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулна.



- Зөвшөөрөл бүхий мал төхөөрөх үйлдвэр байгуулах
- Хөргөлтийн агуулах (хөлдөөгч) байгуулах
- Гарал үүслийн гэрчилгээг QR коджуулах

Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-5 Үйл ажиллагаа 3-ын ерөнхий агуулга

7.4.1 Үйл ажиллагаа 3-1: Шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулахыг сумын түвшинд байгуулж, шинэлэг чанарыг хадгалах технологи бүхий махны нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгох

Энэхүү үйл ажиллагаагаар сумын түвшинд махны хангалт нийлүүлэлтийн гинжин хэлхээг байгуулна.

(1) Агуулга

Сумын түвшинд мал төхөөрөх байгууламж болон хөргөлтийн агуулах байгуулж, малчдын бэлтгэсэн борлуулах зориулалттай махыг хадгалах гэсэн загвар жишээг бий болгоно. Мал төхөөрөх байгууламж болон хөргөлтийн агуулахын техникийн үзүүлэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан УИХ-ын 36-р тогтоолын дагуу батлагдсан шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн байна.

(2) Үйл ажиллагаа

- ① Ерөнхийлөгчийн санаачилсан УИХ-ын 36-р тогтоолын дагуу батлагдсан шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн, зөвшөөрөл бүхий мал төхөөрөх байгууламж болон хөргөлтийн агуулахыг суманд байгуулна. Мал төхөөрөх байгууламжийг Японы зэрлэг амьтан төхөөрч боловсруулах байгууламж (Жибиэ)-ийн адилаар энгийн хялбар

хийцтэй байхаар зохицуулна. Зэрэгцэн байрлах хөлдөөгчийн хувьд хөлдөөгч бүхий энгийн контейнер суурилуулна.

- ② Тодорхой шалгуурын дагуу үйл ажиллагаа хариуцан явуулах хоршоог сонгож авах.
- ③ Тээвэрлэлтийн тухайд хувийн хэвшлийн мах бэлтгэх, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг ААН-тэй хамтарч бага хүүтэй зээл болон санхүүгийн тусламж гэх зэргийг ашиглаж хөргөлт, хөлдөөгчтэй тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- ④ Хүнс болон хөргөлтийн тоног төхөөрөмжийн мэргэжлийн боловсон хүчинг дотоодод мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүмүүсээс бүрдүүлнэ. Хүн хүчний зардлыг эхний 3 жилийн хугацаанд төслөөс хариуцах бөгөөд бие даан ашиг олохын хирээр зардлыг хоршоо хариуцдаг болох.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-8 Сумын түвшинд мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулах байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Байгууламж байгуулах зардал	Мал төхөөрөх байгууламж	400,000	2	800,000	2 сум / аймаг
Тоног төхөөрөмжийн зардал	Хөлдөөгч бүхий контейнер	40,000	2	80,000	2 сум / аймаг
Тоног төхөөрөмжийн зардал	Офис	50,000	2	100,000	2 сум / аймаг
Тоног төхөөрөмжийн зардал	Хөлдөөгчтэй автомашин	0	0	0	Хувийн хэвшлийн ААН-тэй хамтрах
Хүн хүчний зардал	Мал төхөөрөх байгууламж, хөлдөөгчийн технологич	10,000	12	120,000	2 сум / аймаг, 2 хүн / сум, 3 жил
Нийт				1,100,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.4.2 Үйл ажиллагаа 3-2: Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбосон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх

Экспорт болон жижиглэн борлуулахад чиглэсэн брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор мал төхөөрөх үед сумын түвшинд мэдээлэл оруулж, МЭЭГ-ын Мал эмнэлгийн нэгдсэн систем (MAHIS)-тэй холбогдсоноор бэлтгэсэн газраас боловсруулалт хүртэлх бүхий л дамжлагыг мөшгих боломжтой гарал үүслийн мэдээллийн систем байгуулна.

(1) Агуулга

Сумаас мал гаргах үед сумын малын эмч үзлэгийн гэрчилгээ гаргаж өгөх боловч уг гэрчилгээ болон вакцин хийлгэсэн тухай баримт бичиг гэх зэрэг нь ихэнхдээ цахимжуулаагүй байдаг тул ялангуяа гадаад руу экспортлох үеийн мөшгих тогтолцоог бүрдүүлэхэд саад учруулах нэг хүчин зүйл нь болоод байна. Иймээс, тухайн малд вакцин хийсэн эсэх тухай тэмдэглэгээг төхөөрөх үед нь цахимжуулж өмнө дурдсан малчдын мэдээллийн сан болон Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбож, мал төхөөрөх үед тухайн малын маханд ногдуулах QR кодоор

вакцины мэдээлэл, эрүүл ахуйн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ гэх зэргийн мэдээллийг гаргаж ирэх боломжтой мөшгих системийг бий болгоно.

(2) Үйл ажиллагаа


- ① Мал төхөөрсний дараа үзлэг хийж дуусангуут QR код ногдуулснаар тухайн бэлтгэсэн мах (гулууз мах)-ыг таних мэдээллийн системийг нэвтрүүлнэ. Экспорт болон жижиглэн борлуулах дэлгүүрт уг QR кодыг уншуулж холбогдох бүхий л гэрчилгээг харах боломжтой болох юм.
- ② QR кодыг уншуулснаар МЭЕГ-ын Мал эмнэлгийн нэгдсэн систем (MAHIS)-ийн эрүүл ахуйн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ гэх зэргийн мэдээллийг харах боломжтой болгож системтэй холбоно.
- ③ Одоогийн байдлаар Мал эмнэлгийн нэгдсэн системд нэгтгээгүй байгаа цаасан дээрх вакцины гэрчилгээ гэх зэргийг мал төхөөрсний дараах үзлэгийн үед скан хийж системд нэгтгэж, дээр дурдсан QR кодоор дамжуулж харах боломжтой болгох.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-9 Гарал үүслийн мэдээллийн системд шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Тоног төхөөрөмжийн зардал	QR код хэвлэх принтер	10,000	2	20,000	2 сум / аймаг
Тоног төхөөрөмжийн зардал	Мэдээлэл оруулах компьютер, сканер	3,000	2	6,000	2 сум / аймаг
Сургалтын зардал	Мэдээлэл оруулах сургалт	10,000	2	20,000	2 сум / аймаг
Нийт				46,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 7-6 Газар үүслийн мэдээллийн системийн бүтэц, зохион байгуулалт

7.4.3 Үйл ажиллагаа 3-3: Хүнсний технологич бэлтгэх

Сум дээр байгуулах мал төхөөрөх байгууламжийг удирдан ажиллуулах технологичийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. Хүний нөөцийг хөгжүүлэхэд Японы их, дээд сургууль болон хувийн хэвшлийн компанитай хамтарсан сургалт зохион байгуулах талаар судална.

(1) Агуулга

Шинээр батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-д мал төхөөрөх байгууламж болон хөргөлтийн агуулахад хүнсний технологич, хөргөлтийн инженер ажиллуулахаар заасан байна. Нөгөөтэйгүүр, мэргэжлийн мэдлэг туршлагатай боловсон хүчин дутмаг байна.

Шинэ хууль журмын дагуу махны хангалт нийлүүлэлтийн гинжин хэлхээг байгуулж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэхийн тулд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байранд томилогдсоны дараа мэргэжлийн сургалт зохион байгуулах гэх зэргээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

(2) Үйл ажиллагаа

- ① ХААИС болон ШУТИС-ийн хүнсний технологийн танхимд хүнсний боловсруулалт, хөргөлтийн технологийн мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, боловсронгуй болгох.
- ② Ажилд томилогдсоны дараа ч мэргэжлийн боловсон хүчний мэдлэг чадварыг байнга дээшлүүлэхэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж аймаг, суманд сургалт зохион байгуулах. Сургалт зохион байгуулахдаа ХХААХҮЯ болон МЭЕГ-тай хамтарч, холбогдох хууль журмын биелэлтийг хангах.
- ③ Мэргэжлийн боловсон хүчний тогтвортой ажиллах нөхцлийг хангахын тулд жилийн туршид үйл ажиллагаа явуулах шаардлагатай бөгөөд махнаас гадна мал аж ахуйн бусад дайвар бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах талаар үйл ажиллагаа хэрэгжүүлэх.

(3) Хөрөнгө оруулалт

Хүснэгт 7-10 Хүнсний технологич бэлтгэхэд шаардагдах хөрөнгө оруулалт

Зардлын нэр	Агуулга	Нэгж үнэ (ам.доллар)	Тоо ширхэг	Нийт (ам.доллар)	Тэмдэглэл
Сургалтын хэрэглэгдэхүүний зардал	Их, дээд сургуулийн мэргэжлийн хичээлийн хөтөлбөр, сургалтын материал боловсруулах, багш томилох зардал	300,000	3	900,000	
Сургалтын зардал	Ажилд томилогдсон мэргэжлийн боловсон хүчинд зориулсан сургалт	50,000	1	50,000	
Сургалтын зардал	МАА-н бусад бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн сургалт	50,000	1	50,000	
Нийт				1,000,000	1 аймагт ногдох зардал

Эх сурвалж: Судалгааны баг

7.5 Төслийн зардал

Хүснэгт 7-11-д үйл ажиллагаа тус бүрээр 1 аймагт ногдох төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг үзүүлэв. Уг судалгаанд 1 аймгаас 2 сум хамрагдаж байгаа боловч зарим үйл ажиллагааны хувьд хэд хэдэн сумын иргэд үр өгөөжийг нь хүртэхээр байна. Мөн, зарим үйл

ажиллагааны тухайд, судалгаанд хамрагдсан 2 сумаар хязгаарлагдахгүй тухайн аймгийн бүх сумыг хамруулах талаар судлах шаардлагатай байна.

Мөн, энд үзүүлсэн шууд зардлуудаас гадна мэргэжилтэн томилох зардал болон орон нутгийн ажилтны хүн хүчний зардал, автомашины тээврийн зардал гэх зэрэг орон нутагт явуулах үйл ажиллагааны зардал жич шаардлагатай болно.

Хүснэгт 7-11 Төслийн нийт зардал (1 аймагт ногдох)

Үйл ажиллагаа	Дүн (ам.доллар)
1. Зудын урьдчилсан мэдээ ашиглалтын чадавхыг бэхжүүлэх	
1-1. Мэдээ илгээгч болон хүлээн авагч талын аль аль нь мэдээлэл дамжуулсныг нягтлах боломжтой SMS функцийг сайжруулж засаг захиргаа болон малчдын хоорондын мэдээлэл харилцааг сайжруулах	33,000
1-2. Малчдын мэдээллийн сан байгуулж мэдээлэл дамжуулах үр ашгийг нэмэгдүүлэх	16,000
Нийт	49,000
2. Малын тэжээл бэлтгэлийг сайжруулж мал аж ахуйн чадавхыг бэхжүүлэх	
2-1. Сумын түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж бэлчээрийг зохистой ашиглах	10,000
2-2. Хадлангийн газрыг тодорхой болгож хадлан бэлдэх, тэжээлийн ургамал тариалах замаар малын тэжээлийг төрөлжүүлж тэжээл бэлтгэлийн тогтвортой байдлыг хангах	394,000
2-3. Ургамал хамгааллыг хэрэгжүүлж бэлчээрийн нөхөн сэргэлтийг хангах, хяналт мониторингийг хэрэгжүүлэх	304,000
Нийт	708,000
3. Технологийн шинэчилсэн журамд нийцсэн махны хангалт нийлүүлэлтийн тогтолцоог байгуулах	
3-1. Шинэ техникийн зохицуулалтад нийцүүлсэн мал төхөөрөх байгууламж, хөргөлтийн агуулахыг сумын түвшинд байгуулж, шинэлэг чанарыг хадгалах технологи бүхий махны нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгох	1,100,000
3-2. Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбосон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх	46,000
3-3. Хүнсний технологич бэлтгэх	1,000,000
Нийт	2,020,000
Нийт дүн	2,903,000

Эх сурвалж: Судалгааны баг

7.6 Хамтран ажиллах байгууллагууд

Тавдугаар бүлэгт дурдсан олон улсын болон донор байгууллагуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хүрсэн үр дүн, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтийг харгалзан уг төслийн хүрээнд дараах байдлаар хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна.

7.6.1 Зудын мэдээлэл дамжуулах, хамтран ашиглах

Зудын мэдээлэл дамжуулах болон хамтран ашиглахад одоогийн байдлаар АХБ-ны санхүүжилтээр ОБЕГ нь Эрт зарлан мэдээлэх нэгдсэн систем байгуулах төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн үйл ажиллагааны нэг нь харилцаа холбооны оператор компанитай хамтарч үүрэн телефон руу мэдээлэл дамжуулах систем байгуулахаар төлөвлөгдсөн. Төсөл хэрэгжүүлэх тохиолдолд Үйл ажиллагаа 1-ийн хүрээнд бий болгохоор төлөвлөсөн SMS функцийг сайжруулсан системийн ОБЕГ болон харилцаа холбооны оператор компанийн

боловсруулах систем дээрх ажиллах орчин нөхцлийг нягтлах, малчдын мэдээллийн сан байгуулахад холбох, техникийн зохицуулалт хийх шаардлагатай.

Мөн, Азийн гамшгаас урьдчилан сэргийлэх төв (АГУСТ) нь ЦУОШГ болон УЦУОСМХ-тэй хамтарч зудын урьдчилсан мэдээллийн нарийвчлалыг сайжруулж, мэдээллийг шуурхай түгээхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл төлөвлөж байна. Тус төслийн хувьд Үйл ажиллагаа 1-ийн хүрээнд бий болгохоор төлөвлөж байгаа системийг ашиглахын тулд мэдээлэл хамтран ашиглах шаардлагатай.

7.6.2 Тэжээл бэлтгэл

Үйл ажиллагаа 2-ын хүрээнд хэрэгжүүлэх тэжээл бэлтгэлтэй холбоотой үйл ажиллагааны хувьд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага ба “Хүнсний аюулгүй байдал ба ХАА” кластерын гишүүн болох ХХААХҮЯ болон кластерын бусад гишүүн байгууллагуудтай мэдээлэл хуваалцах, “Дэлхийн зөн Монгол” байгууллагын уг судалгаатай адил нэг бүс нутагт малчдын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа болон байгууллагын чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагаатай уялдаж хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон АХБ-ны хэрэгжүүлж буй Уур амьсгалын Ногоон сангийн төслийн хүрээнд бэлчээр хамгаалал болон нөхөн сэргээлтэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

7.6.3 Малын хангалт нийлүүлэлтийн эргэлт

Үйл ажиллагаа 3-ын мал хангалт нийлүүлэлтийн эргэлтийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хувьд Дэлхийн Банк, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хэрэгжүүлж байгаа “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд малын мал сүргийн эрүүл мэнд, ашиг шим, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүйн стандартыг бий болгох, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн, тус төслийн хүрээнд Дундговь аймаг болон Говь-Алтай аймгийг туршилтын бүс нутаг болгон сонгон авч үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа тул төсөл төлөвлөх болон хэрэгжүүлэх тохиолдолд тус төслийн хүрсэн үр дүн болон үйл ажиллагааны явцтай уялдуулах талаар судлах шаардлагатай.

8-р бүлэг Бусад хамтын ажиллагааны агуулга

7-р бүлэгт энэхүү судалгаагаар тодорхой болсон асуудлуудаас УАНС-г ашиглан хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг танилцуулсан. 8-р бүлэгт УАНС-с тусад нь шийдвэрлэх шаардлагатай үлдсэн асуудлууд болон Япон улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх боломжтой хамтын ажиллагааны саналуудыг тусгана. Хүснэгт 8-1-д энэхүү судалгааны дүнд тодорхой болсон гол асуудлууд болон эсрэг арга хэмжээг нэгтгэн харуулав. Бусад хандивлагч орнуудаас хэрэгжүүлж буй дэмжлэг тусламж, УАНС-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслөөс гаднах арга хэмжээ нь Япон улсын дэмжлэгээр хэрэгжүүлэх тухай хэлэлцэх боломжтой үйл ажиллагаа юм.

Хүснэгт 8-1 Судалгааны гол үр дүн , тодорхой болсон асуудлууд ба Япон улсын дэмжлэгээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Одоо байгаа төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа	Үнэлгээний үр дүн (6-р бүлэг)	Арга хэмжээ авах шаардлагатай асуудлууд (2-4-р бүлэг)	Холбогдох асуудлуудын талаар хандивлагч нарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (5-р бүлэг)	УАНС-р дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ (7-р бүлэг)	Бусад, Япон улсын дэмжлэг шаардлагатай үйл ажиллагаа (8-р бүлэг)
①Зудын урьдчилсан мэдээний үнэн зөвийг сайжруулж, үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Зудын урьдчилсэн мэдээлэл нь хэмжээ, чанар, давтамжийн хувьд хангалттай. Одоогийн байдлаар малчдын 50 хүрэхгүй хувь нь ухаалаг гар утас хэрэглэдэг. Малчдын оршин суугаа газар болон бэлчээрийн бүс нутагт 3G ба түүнээс дээш сүлжээний орчин бий болоход хүндрэлтэй тул SMS ашиглан мэдээлэл хүргэдэг тогтолцоог хэсэг хугацаанд үргэлжилнэ. 	Урт хугацааны урьдчилсэн мэдээллийн систем хөгжүүлэх	ADB TA6534-MON (санал болгож буй) : Гамшгийн аюулыг эрт сэрэмжлүүлж, зарлан мэдээлэх нэгдсэн системийг хөгжүүлэх тухайд, гар утасны дохиоллын мэдээлэл дамжуулах системийг хөгжүүлэх, техник хангамжийн засвар үйлчилгээ WFP: Мобайл дата системийг боловсронгуй болгох (2019-2020): SMS-ээр мэдээлэл түгээх системийг хөгжүүлэх. Зудын нөлөөлөл ба нөхцөл байдлын удирдлагын платформыг (PRISM) бий болгох	—	—
②Зудын урьдчилсан мэдээний үр дүнг үр дүнтэй ашиглах	<ul style="list-style-type: none"> Ялангуяа богино хугацааны урьдчилсан мэдээ, яаралтай тусламжийн мэдээлэл нь сум болон багийн даргаар дамждаг гэх мэт хүний оролцоо их байгаагаас хамаарч мэдээлэл дамжуулах хурд, хүрээ хязгаарлагдмал байдаг. 	<ul style="list-style-type: none"> Мэдээллийг мессежээр дамжуулах → малчид хүлээн авсныг баталгаажуулах → сумын дарга, багийн даргаас хүлээн аваагүй хүмүүст утсаар холбогдох гэсэн одоо байгаа нөхцөл байдлыг сайтар тодорхой болгосны үндсэн дээр үр ашгийг дээшлүүлэх, системийг сайжруулах шаардлагатай. 	—	<ul style="list-style-type: none"> Малчдын мэдээллийн санг бүрдүүлэх (7.1.2) Зудын мэдээллийг SMS-ээр хүлээн авсныг баталгаажуулах системийг сайжруулах (7.1.1) 	—

Одоо байгаа төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа	Үнэлгээний үр дүн (6-р бүлэг)	Арга хэмжээ авах шаардлагатай асуудлууд (2-4-р бүлэг)	Холбогдох асуудлуудын талаар хандивлагч нарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (5-р бүлэг)	УАНС-р дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ (7-р бүлэг)	Бусад, Япон улсын дэмжлэг шаардлагатай үйл ажиллагаа (8-р бүлэг)
	<ul style="list-style-type: none"> Малчид урьдчилсан мэдээний үнэн зөвийг сайжруулахаас илүүтэй тухайн мэдээллийн дагуу зохих арга хэмжээ авах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. 	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл хүлээн авсны дараа төрөөс хэрэгжүүлэх хариу арга хэмжээ үйлчилгээг сайжруулах, хүлээн авах боломжийг сайжруулах шаардлагатай байна. Өвлийн улиралд малын хорогдлыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. 	—	<ul style="list-style-type: none"> Бүс нутгийн тэжээл бэлтгэх чадавхийг бэхжүүлэх (7.2.1, 7.2.2 Малын тэжээл бэлтгэх, 7.1.3 Ургамлыг нөхөн сэргээх) 	<ul style="list-style-type: none"> Тэжээлийн төв байгуулах (8.1) Зудын эрсдлийг хянах чадварыг сайжруулах (8.4)
			—		<ul style="list-style-type: none"> Өндөр үр ашигтай малын байрыг байгуулах (8.3)
<p>③ Нарны эрчим хүчийг ашигласан мах хөлдөөх, хадгалах систем (PV систем) нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> Малчид зудын эсрэг арга хэмжээ болгон малаа нядалхаас илүүтэй өвс тэжээл бэлтгэхийг илүүд үздэг. PV системээр суурьлуулах хөлдөөгчний температур нь -15°C байгаа нь 2022 онд Засгийн газраас шинээр баталсан тогтоолд заасан - хөлдөөлтийн температурын 25°C-35°C-тай нийцэхгүй байна. PV систем нь энгийн хөргөгчтэй контейнертой харьцуулахад эдийн засгийн үр ашиг нь бага. 	<ul style="list-style-type: none"> Сомын түвшинд хөлдөөгчийг нэвтрүүлсэн нь нүүдэлчдийн хувьд зардал бага байвал малын борлуулалтаас ашиг олох үр дүнтэй. Нөгөөтэйгүүр, шинэ хуульд мал нядалгааны гэрчилгээтэй үйлдвэрт боловсруулах, малын эмчийн үзлэгт оруулах, хөргөлтийн техникч томилох гэх мэтээр тусгаж, тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулахад засвар үйлчилгээ, менежментийн зардлыг нарийн нягт нямбай шалгах шаардлагатай. 	Дэлхийн банк: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд малын эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Сумын хэмжээнд мал нядалгааны газар, мах нийлүүлэлтийн сүлжээ байгуулах (7.3.1) Экспортод гаргах махны шинэлэг байдлыг хадгалах технологи бүхий хөргөлтийн агуулахыг нэвтрүүлэх (7.3.1) 	<ul style="list-style-type: none"> Экспортын зориулалттай махны шинэлэг байдлыг хадгалах технологи бүхий хөргөлтийн агуулахыг хоёр шатлалт зээлээр байгуулах (8.2)
<p>④ Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээлтийг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> Шинээр батлагдсан хуульд, зах зээлд нийлүүлэх мах, махан бүтээгдэхүүнийг баталгаат мал нядалгааны газарт боловсруулж, шинжилгээний бичигтэй байна 	<ul style="list-style-type: none"> Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг шинэ хуулийн заалтанд тулгуурлан шинээр бий болгохын тулд зөвхөн хөлдөөгч суурилуулахаас гадна мал 	Дэлхийн банк: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд ЖДҮ эрхлэгчидтэй хамтран хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, малчдын зах зээлд нэвтрэх боломжийг	<ul style="list-style-type: none"> Сумын хэмжээнд мал нядалгааны газар, мах нийлүүлэлтийн сүлжээ байгуулах (7.3.1) 	—

Одоо байгаа төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа	Үнэлгээний үр дүн (6-р бүлэг)	Арга хэмжээ авах шаардлагатай асуудлууд (2-4-р бүлэг)	Холбогдох асуудлуудын талаар хандивлагч нарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (5-р бүлэг)	УАНС-р дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ (7-р бүлэг)	Бусад, Япон улсын дэмжлэг шаардлагатай үйл ажиллагаа (8-р бүлэг)
	<p>заасан. Энэ нь 2023 оны 1 сараас эхлэн 3 жилийн хугацаатай хэрэгжинэ. Гэвч эдгээр байгууламжууд аймгийн төвүүдэд байрлаж байгаа ба, сумын хэмжээнд тохирох байгууламж байхгүй, малчид зах зээлээс алслагдсан тул махаа борлуулах хэмжээ, үнэ нь тогтворгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> МЭЭГ нь 2019 онд MAHIS-аас мөрдөх хяналтын системийг боловсруулжээ. Шинэ хууль хэрэгжиж эхэлснээр бүрэн хэмжээний үйл ажиллагаа эхэлнэ. Малын шүлхий өвчний улмаас махны экспортын хэмжээ тогтвортой бус, зорилтод хүрч чадахгүй байна. 	<p>нядалгааны болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, тэдгээр нь сумын түвшинд засвар үйлчилгээ хийх боломжтой байх зүйтэй.</p> <ul style="list-style-type: none"> Гарал үүслийг мөшгих тогтолцоо ч гол асуудлуудын нэг. 	<p>нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, олон нийтийн байгууллагуудын ү.а-г бэхжүүлэх.</p>		
			—	<ul style="list-style-type: none"> Хүнсний технологич бэлтгэх (7.3.3) 	—
			—	<ul style="list-style-type: none"> Мал эмнэлгийн нэгдсэн системтэй холбогдсон гарал үүслийн мэдээллийн системийг хөгжүүлэх (7.3.2) 	—
		<ul style="list-style-type: none"> Монголын бэлчээрийн экосистем алдагдаж байгаа тул, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн хэв шинжийг өөрчлөх шаардлагатай гарч байна. 	<p>ADB TA6534-MON төслийн хүрээнд 3 аймгийн газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсан. UNDP: 4 аймгийн газар болон усны ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсан. Дэлхийн зөн: Уур амьсгалд тэсвэртэй бэлчээрийн аж ахуйг дэмжих төслийн хүрээнд 2 аймгийн 4 сумыг хамруулсан</p>	<ul style="list-style-type: none"> Бүс нутгийн тэжээл бэлтгэх чадавхийг бэхжүүлэх (7.2.1, 7.2.2 Малын тэжээл бэлтгэх, 7.1.3 Ургамлыг нөхөн сэргээх) 	—
<ul style="list-style-type: none"> Малын шүлхий өвчин гэх мэт малын эрүүл ахуйн хяналтын хэрэгжилт одоо ч асуудалтай байна. Өргөн хүрээнд малын эрүүл ахуйн чадавхийг сайжруулах шаардлагатай. 	<p>Дэлхийн зөн: ХХЗХ төсөл хувийн мал эмнэлгүүдийг бэхжүүлэх</p> <p>Дэлхийн банк: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, малын эрүүл мэндийн хяналтын системийг сайжруулах.</p>	—	—		

Эх сурвалж: Судалгааны баг

Энэхүү бүлэгт дээр дурдсан агуулгыг үндэслэн дараах 4 дэмжлэг үйл ажиллагааны талаар танилцуулж тайлбар хийнэ.

Хүснэгт 8-2 Санал болгож буй дэмжлэг үйл ажиллагаа

	Салбар	Төслийн саналын нэр	Хамтын ажиллагааны хэлбэр
1	Тэжээлийн төв байгуулах	Тэжээлийн төв, сүлжээ байгуулах төсөл	Буцалтгүй тусламж
2	Экспортонд гаргах зориулалттай махны шинэ байдлыг хадгалах технологи бүхий хөргөлтийн агуулахыг байгуулах	Экспортонд гаргах зориулалттай махны нийлүүлэлтийн сүлжээний байгууламжийг хоёр шатлалтай зээлээр байгуулах төсөл	Иений хөнгөлөлттэй зээл
3	Өндөр үр ашигтай малын байрыг байгуулах	Зудны нөлөөтэй малын хорогдлыг бууруулах зорилгоор мал бойжуулалтын хяналтын сайжруулах төсөл	Техникийн хамтын ажиллагаа
4	Зудын эрсдлийг хянах чадварыг сайжруулах төсөл	Орон нутгийн удирдлагын зудын эрсдлийг хянах чадавхийг бэхжүүлэх төсөл	Техникийн хамтын ажиллагаа + Өвсний үндэс буцалтгүй тусламж

Эх сурвалж: Судалгааны баг

8.1 Тэжээлийн төв байгуулах

(1) Төслийн саналын нэр (хамтын ажиллагааны хэлбэр)

“Тэжээлийн төв, сүлжээ байгуулах төсөл“ Буцалтгүй тусламж

(2) Төслийн үндэслэл ба хэрэгцээ шаардлага

Малчид зудын гамшгийн талаар мэдээлэл аваад хамгийн түрүүнд авах арга хэмжээ нь өвс тэжээлийн хангамжийн асуудал байдаг. Монголын уламжлалт мал аж ахуй нь байгалийн бэлчээрт тулгуурласан нүүдлийн мал аж ахуй голлон зонхилдог боловч сүүлийн үед уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, бэлчээрийн даац хэтэрснээс үүссэн бэлчээрийн доройтол зэрэг асуудлууд ихээхэн тулгарч байгаа тул цаашид өвс тэжээл ашиглан малын үржүүлэгийн үр ашгийг дээшлүүлэхийн зэрэгцээ, бэлчээрийн ургамлын нөөцийг хамгаалах МАА-н тогтолцоог нэвтрүүлэх тухай хэлэлцэх зайлшгүй шаардлагатай байна. Гэтэл Монголд тэжээлийн тариалах тухай асуудал төдийлөн өргөн дэлгэр бус тэжээлийн хангамж хангалттай бус байна. Түүнчлэн газар тариалангийн хэв соёл бүрэн тогтоогүй байгаа Монгол орны хувьд малчдын өөсрдийн санаачлагаар тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй.

Тиймээс 7-р бүлэгт дэвшүүлсэн төслийн саналд заасан газар ашиглалтын төлөвлөгөөний дагуу тэжээл үйлдвэрлэх, нөөцлөх тэжээлийн төв байгуулж, бүс нутгийн хэмжээнд малчдын тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

(3) Төслийн зорилго

Энэхүү төсөл нь хэд хэдэн сумдаас очих боломжтой байршилд тэжээлийн төвийг байгуулагдснаар, малчдын тэжээлийн хүртээмж нэмэгдэж, ашиглалт сайжирна. Мөн зуд болсон тохиолдолд хорогдох байр болгон ашиглах боломжийг бүрдүүлснээр зудын эрсдлийг бууруулна.

(4) Төслийн үр шимийг хүртэгчид

ХХААХҮЯ, аймгийн ХАА-н газар, сумын захиргаа, төсөл хамрагдах аймгуудын малчид, тэжээлийн төвийг ашиглах боломжтой сумын малчид (үр шимийг шууд хүртэгчэд)

(5) Төсөлд хамрагдах орон нутгууд

Шинээр санал болгож буй төслийг хэрэгжүүлж, тэжээл үйлдвэрлэлийг тусгасан газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсан аймаг (одоогийн байдлаар, Дундговь аймаг, Говь-Алтай аймгийг төлөвлөж байна)

(6) Төслийн агуулга

1) Тэргүүн зорилго

Байгаль орчны нөлөөллийг багасгаснаар бэлчээрийг сэргээнэ.

2) Төслийн зорилго

10 тэжээлийн төвийг байгуулж, тогтвортой ашигласнаар зудын хохирлыг бууруулна.

3) Үр дүн

Үр дүн 1: Тэжээлийн төв байгуулагдана.

Үр дүн 2: Тэжээлийн төвийн бизнес загвар бий болж, үйл ажиллагааг тогтвортой хангахад шаардлагатай хүний нөөцийн чадавх бүрдэнэ.

4) Үйл ажиллагаа

- Тэжээлийн төв байгуулагдана.
- Шаардлагатай ХАА-н тоног хэрэгсэл хангагдана.
- Тэжээлийн төвийн загвар бий болно.
- Тэжээлийн төвийн менежментийн тогтолцоо бүрдэнэ.
- Тэжээлийн төвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хүний нөөцийн чадавхыг сургалтаар дамжуулан дээшлүүлнэ.

(7) Нийт зардал (Японы тал)

Судлах шаардлагатай.

(8) Төсөл хэрэгжүүлэх хугацаа

2030~2033 он (3 жил)

(9) Монголын талын хамтрагч байгууллага

ХХААХҮЯ, төсөлд хамрагдах аймгуудын ХАА-н газар

(10) Хөрөнгө оруулалт (input)

1) Японы тал

- Богино хугацааны мэргэжилтэн (Буцалтгүй тусламж BD, SV)
- 10 байршилд тэжээлийн төв байгуулах: $150,000\$ \times 10 = 1,500,000\$$
- 10 байршилд байгуулахад шаардлагатай, хадлан болон тэжээлийн ургамал тариалахад үрээр хангах: $10,000\$ \times 10 = 100,000\$$
- 10 байршилд байгуулахад шаардлагатай ХАА-н тоног төхөөрөмжийг хангах: $300,000\$ \times 10 = 3,000,000\$$
- 10 байршил тус бүр дээр гамшгийн үеийн хорогдох байр байгуулах: $150,000\$ \times 10 = 1,500,000\$$
- Soft component (тэжээл тариалах, ХАА-н тоног төхөөрөмж ажлуулах): 200,000\$

2) Монголын тал

- Хамтран ажиллагч байгууллагын томилох
- Засгийн газраас байршлыг тогтоож газрыг бэлдэх, барилгын зөвшөөрөл авах гэх мэт

(11) Бусад төсөл, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай улдаа холбоотой ажиллах, ажил үүргийн хуваарьлалт

ШУТИС нь БНХАУ, ОХУ, Канад, Өмнөд Солонгос, Япон зэрэг улсуудтай хамтран TMR¹⁹ тэжээлийн төв байгуулж, бүс нутгийг хамарсан тэжээл хангамжийн систем бүхий агро-экологийн бүсийг байгуулах төслийг хэрэгжүүлж байгаа ба тэжээлийн тариалалтын чиглэлээр хамтран ажиллах талаар хэлэлцэнэ.

8.2 Экспортонд гаргах зориулалттай махны шинэ байдлыг хадгалах, хөргөх агуулахыг хоёр шатлалтай зээлээр байгуулах

(1) Төслийн саналын нэр (хамтын ажиллагааны хэлбэр)

“Экспортонд гаргах зориулалттай махны шинэ байдлыг хадгалах технологи бүхий хөргөлтийн агуулахыг хоёр шатлалтай зээлээр байгуулах төсөл” Иений хөнгөлөлттэй зээл

(2) Төслийн үндэслэл ба хэрэгцээ шаардлага

2021 онд Монгол Улсын махны экспорт 8,000 тоннд хүрч, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зорилт болгож буй нэг жилийн экспортын хэмжээний 50,000 тонноос хол зөрүүтэй байна. 3.3 сая хүн амтай Монгол Улсын дотоодын хэрэгцээ хязгаарлагдмал тул малчдын орлогыг нэмэгдүүлж зах зээлийг тэлж, махны чанар болон үнийн баланс сайтай зах зээл рүү нэвтрэхийн тулд махны экспортыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай.

Монгол Улсын экспортын гол бүс нь Хятад боловч малын шүлхий өвчин гарахад Хятад руу хийх экспорт зогсдог тул махны экспорт жилээс жилд ихээхэн хэлбэлздэг. Нүүдлийн мал аж ахуйны хэлбэр зонхилсон, шүлхий өвчин гөрөөс гэх мэт зэрлэг амьтдын улмаас тархаж байгааг зэргээс хамаараад шүлхий өвчнөөс бүрэн сэргийлэхэд хүндрэлтэй. Тиймээс махыг шүлхий өвчний хорио багатай Ойрхи Дорнод руу экспортлох нь цаашид экспортыг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ойрхи Дорнодын махны зах зээлд хөлдөөсөн махны хэрэгцээ бага тул хөрш орнуудаас малыг амьдаар нь импортлоод дотооддоо нядлах нь элбэг. Гэвч Монголоос Ойрхи Дорнод руу малыг амьдаар нь тээвэрлэх боломжгүй учир хөлдөөхгүйгээр урт хугацаанд хөргөгчинд хадгалах боломжтой технологийг²⁰ нэвтрүүлж, зах зээлд өрсөлдөх чадвар өндөртэй махыг нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээг бий болгож, Ойрхи Дорнод руу экспортыг дэмжих нь зүйтэй.

(3) Төслийн зорилго

Энэхүү төсөл нь Монгол Улсын хэмжээнд мах экспортолж буй бизнес эрхлэгчид болон малчдын хоршоодод хөнгөлөлттэй хүүтэй зээл олгох замаар Ойрхи Дорнод руу хөргөсөн мах экспортлох нэмүү өртгийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

(4) Төслийн үр шимийг хүртэгчид

Төрийн санхүүгийн байгууллагууд, Ойрхи Дорнод руу мах экспортлогчид, малчдын хоршоо гэх мэт.

(5) Төсөлд хамрагдах орон нутгууд

Орон даяар

¹⁹ TMR: Total Mixed Retio үгийн товчлол бөгөөд ногоон тэжээл болон хүчит тэжээлийг зохистой харьцаагаар хольж тэжээх аргачлал.

²⁰ Түүхий махыг 180 хоног хадгалах боломжтой өндөр даралттай хөргүүр бүхий хөргөгч

(6) Төслийн хүрээ

1) Тэргүүн зорилт

Ойрхи Дорнод руу хөргөсөн түүхий махны экспортыг нэмэгдүүлснээр малчдын амьжиргааны түвшин дээшилнэ.

2) Төслийн зорилт

Түүхий махыг Ойрхи Дорнод руу экспортлох нэмүү өртгийн сүлжээ бий болно.

3) Үр дүн

Үр дүн 1: Монгол Улсын төрийн санхүүгийн байгууллага Ойрхи Дорнод руу түүхий мах экспортлоход шаардлагатай хөрөнгө оруулалтанд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн (хоёр шатлалт зээлийг ашиглах) боловсруулж, санхүүжилтийг хэрэгжүүлэх чадвартай болно.

Үр дүн 2: Зээлэнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд нь түүхий махыг удаан хугацаагаар хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай барилга байгууламжийг байгуулна.

4) Үйл ажиллагаа

- Монгол Улсын төрийн санхүүгийн байгууллагууд хоёр шатлалт зээлийн хүүгийн хэмжээ, зорилтот нөхцлийг тогтоож, үйл ажиллагааны удирдамжийг боловсруулна.
- Хоёр шатлалттай зээлийн үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх сургалтанд хамтрагч байгууллагуудын мэргэжилтнүүдийг хамруулна.
- Хоёр шатлалттай зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар санхүүгийн байгууллагын салбарын ажилтан бүрт тайлбар хийж, сургалт зохион байгуулна.
- Хоёр шатлалттай зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааг бүртгэх, хянах тогтолцоог боловсруулж салбар бүрт хэрэгжүүлнэ.
- Хоёр шатлалттай зээлийн санхүүжилтийн талаар мэдээлэл хийж, үнэлгээ хийсний үндсэн дээр бодит санхүүжилтийг хэрэгжүүлнэ.

(7) Нийт зардал (Японы тал)

Судлах шаардлагатай.

(8) Төсөл хэрэгжүүлэх хугацаа

2025~2030 он (5 жил)

(9) Монголын талын хамтрагч байгууллага

- Зээлдэгч: Монгол Улс
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэгч: Төрийн санхүүгийн байгууллага (төрийн өмчит арилжааны банк болох “Төрийн банк”-г төлөвлөж байна)

(10) Хөрөнгө оруулалт (input)

1) Японы тал

- ① Хоёр шатлалттай зээл: Махны экспортын нэмүү өртгийн сүлжээтэй холбоотой бизнес эрхлэгчид ба малчдын хоршоо гэх мэт аж ахуйн нэгжүүдэд дунд болон урт хугацааны зээлийг олгох. Зээлийг төрийн санхүүгийн байгууллага (төрийн өмчит арилжааны банк болох “Төрийн банк”-г төлөвлөж байна) –р дамжуулан олгох ба зээлийн хэмжээ 5 тэрбум иен.
- ② Консалтинг үйлчилгээ (үйл ажиллагааны хяналт, төрийн санхүүгийн байгууллагын чадавхийг сайжруулах гэх мэт) 4 сая иен

2) Монголын тал

- Хамтран ажиллагч байгууллагын томилох

(11) Бусад төсөл, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай улдаа холбоотой ажиллах, ажил үүргийн хуваарьлалт

ЖАЙКА байгууллага нь Монгол Улсад 2020 оноос эхлэн “Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, борлуулалтад нэмүү өртгийн сүлжээний тогтолцоог бий болгоход чиглэсэн мастер төлөвлөгөөг боловсруулж байгаа тул мал нядалгаа, махны боловсруулалтын тал дээр хамтран ажиллах тухай хэлэлцэнэ.

8.3 Өндөр үр ашигтай малын байрыг байгуулах

(1) Төслийн саналын нэр (хамтын ажиллагааны хэлбэр)

“Зудны нөлөөтэй малын хорогдлыг бууруулах зорилгоор мал бойжуулалтын хяналтыг сайжруулах төсөл” (Техникийн хамтын ажиллагаа)

(2) Төслийн үндэслэл ба хэрэгцээ шаардлага

Монголд хэдэн жилийн давтамжтайгаар их хэмжээний зуд болж, зудтай жилүүдэд малын тоо толгой ихээр хорогддог. 2021 оны байдлаар Монгол улсын хэмжээнд хонин толгойд шилжүүлсэн байдлаар 120 сая мал тоологдсон ба бэлчээрийн даац хэтэрсэн байгаа тул том хэмжээний зудын гамшиг тохиолдож, малын хохирол үүсэх нөхцөл хэзээ ч бий болж болох байдалд байна.

Зарим малчид малын хашаа саравчгүй, байсан ч ихэнх нь зөвхөн дээвэртэй, ханагүй, эсвэл зүгээр л хучсан төдий маш энгийн байгууламжууд олон байна. Ялангуяа дөнгөж төрсөн төл мал, тарга муутай тэжээлийн дутагдалтай мал хүйтний улмаас осгож эндэх тохиолдол элбэг ба энэ нь өвлийн улиралд мал осголтын нэг шалтгаан болж байгаа тул арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай.

(3) Төслийн зорилго

Энэхүү төсөл нь малчдын өвөлжөөнд байрлах малын байрны жишиг загварыг бий болгосноор өвлийн улирал дахь малын хорогдлыг бууруулна. Мөн захиргааны зүгээс малчдад өвлийн улиралд малыг зөв зохистой үржүүлэх арга зүй, зудын гамшигийг урьдчилан таамаглах үед авах арга хэмжээний талаар зааварчилгаа өгч ажилласнаар малын хохирлын эрсдлийг бууруулах, малчдын эрсдэл даах уян хатан чанарыг нэмэгдүүлэх зорилготой.

(4) Төслийн үр шимийг хүртэгчид

ХХААХҮЯ, аймгийн ХАА-н газар, төсөлд хамрагдах орон нутгийн малчид

(5) Төсөлд хамрагдах орон нутгууд

Зорилтот аймгуудын туршилтаар сонгогдсон сумдууд (Дундговь аймаг, Говь-Алтай аймаг)

(6) Төслийн агуулга

1) Тэргүүн зорилт

Зорилтот аймгийн малчдын зудын эрсдлийг даах уян хатан чанарыг нэмэгдүүлэх

2) Төслийн зорилт

Зорилтот аймгуудын туршилтаар сонгогдсон сумын малчдын өвлийн улирал дахь малын хорогдлыг бууруулах

3) Үр дүн

Үр дүн 1: Туршилтаар сонгогдсон сумдад өндөр үр ашиг бүхий малын байр бий болно.

Үр дүн 2: Туршилтаар сонгогдсон сумдад өвлийн улиралд малыг зөв зохистой үржүүлэх арга зүйг нэвтрүүлнэ.

Үр дүн 3: Туршилтаар сонгогдсон сумдад өвлийн улиралд малын тэжээл нөөцлөх технологийг нэвтрүүлнэ.

4) Үйл ажиллагаа

- Дулааныг шингээх, дулааныг хадгалах функц бүхийн өндөр үр ашигтай малын байрыг барих
- Өвлийн улирал дахь төл малын хорогдлоос сэргийлж 2-3 сартай төлийг тус тусад нь байршуулах төлийн байрыг суурьлуулах
- Өвлийн хүйтний улирал дахь малын стрессийг бууруулахад чиглэсэн мал үржүүлэгийн арга зүйн зааварчилгаа өгөх
- Өвлийн улиралд малын тэжээллэг байдлыг сайжруулахын тулд мал тэжээх аргачлалын зааварчилгаа өгөх
- Өвлийн улиралд тэжээл бэлтгэх, нөөцлөх арга техникийн зааварчилгаа өгөх

(7) Нийт зардал (Японы тал)

Судлах шаардлагатай.

(8) Төсөл хэрэгжүүлэх хугацаа

2024~2027 он (3 жил)

(9) Монголын талын хамтрагч байгууллага

ХХААХҮЯ, аймгийн ХАА-н газар

(10) Хөрөнгө оруулалт (input)

1) Японы тал

① Мэргэжилтэн илгээх

Богино хугацааны мэргэжилтэн: Төслийн ахлагч болон их дээд сургууль, мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн мэргэжилтнүүд, зөвлөхүүдийг илгээх

Урт хугацааны мэргэжилтэн: Төслийн зохицуулагч

② Техникийн дэмжлэг

- Малыг байрыг шинээр барих болон сэргээн засварлах (загвар болгож сонгосон суманд)
- Төлийн байрыг суурьлуулах. 1 өрхөд 1-г нийт 100 өрхөд суурьлуулна (1 нь 2,000\$ өртөгтэй ба нийт өртөг 200,000\$ байна)
- Өвлийн тэжээл нөөцлөхөд шаардлагатай хэрэгсэл (хамгаалалтын материал, дарш бэлтгэх хэрэгсэл гэх мэт)

2) Монголын тал

- ① Хамтран ажиллагч байгууллагын томилох
- ② Япон талын мэргэжилтнийг ажиллах орчноор хангах
- ③ Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах орон нутгийн зөвлөх, мэргэжилтэн
- ④ Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлууд
- ⑤ Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дата, холбогдох мэдээлэл

(11) Бусад төсөл, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай улдаа холбоотой ажиллах, ажил үүргийн хуваарьлалт

ЖАЙКА байгууллага нь Монгол Улсад “Төрийн болон хувийн хэвшлийн малын эмч нарын практик чадавхийг сайжруулах төсөл” (2020~2025он)-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хамтран ажиллагч байгууллагатай мал эмнэлэгийн зааварчилгаа өгөх тал дээр хамтран ажиллах тухай хэлэлцэнэ.

8.4 Зудын эрсдлийг хянах чадварыг бэхжүүлэх төсөл

(1) Төслийн саналын нэр (хамтын ажиллагааны хэлбэр)

“Орон нутгийн удирдлагын зудын эрсдлийг хянах чадавхийг бэхжүүлэх төсөл”
(Техникийн хамтын ажиллагаа + Өвсний үндэс буцалтгүй тусламж)

(2) Төслийн үндэслэл ба хэрэгцээ шаардлага

Монгол улсад сүүлийн жилүүдэд том хэмжээний зуд тодорхой хугацааны давтамжтай үүссэний улмаас мал их хэмжээгээр хорогдож хохирол учирсан. Малчид өөрсдөө зудын эсрэг арга хэмжээ авах шаардлагатай хэдий ч нөгөөтэйгүүр орон нутгийн удирдлагын байгууллагад зудын эрсдэлийг бууруулах тогтолцоог бий болгох нь чухал байна.

(3) Төслийн зорилго

Аймаг болон сумын захиргаа гэх мэт төрийн байгууллага малчдын зудын эрсдлийг бууруулахад шаардлагатай байгууламжийг байгуулж, ажлуулснаар орон нутгийн удирдлагын түвшинд зудын эсрэг арга хэмжээний чадамж сайжирч, малчдад хүрэх дэмжлэг үр өгөөжтэй бөгөөд үр дүнтэй болсноор орон нутаг дахь мал аж ахуйн хөгжлийг дэмжинэ.

(4) Төслийн үр шимийг хүртэгчид

ХХААХҮЯ, аймгийн ХАА-н газар, сумын захиргаа, төсөлд хамрагдах аймгийн малчид

(5) Төсөлд хамрагдах орон нутгууд

Зорилтот аймгуудын туршилтаар сонгогдсон сумдууд (Дундговь аймаг, Говь-Алтай аймаг)

(6) Төслийн агуулга

1) Тэргүүн зорилт

Орон нутаг дахь зудад тэсвэртэй мал аж ахуйн тогтолцоог бий болгох

2) Төслийн зорилт

Аймаг болон сумын захиргаа гэх мэт орон нутгийн удирдлагын зудын эсрэг авах арга хэмжээний чадавхыг сайжруулах

3) Үр дүн

Үр дүн 1: Орон нутгийн удирдлага зудын арга хэмжээг хэрэгжүүлэх чадамжтай болно

Үр дүн 2: Орон нутагт мал аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай байгууламжуудыг хөгжүүлнэ.

4) Үйл ажиллагаа

- Малын тэжээл боловсруулах байгууламж, түгээлтийн системийг бий болгох
- Өвлийн улиралд малыг хүлээн авах байгууламжийг байгуулах
- Мал нядалгаа, мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах

(7) Нийт зардал (Японы тал)

Судлах шаардлагатай.

(8) Төсөл хэрэгжүүлэх хугацаа

2026~2029 он (3 жил)

(9) Монголын талын хамтрагч байгууллага

ХХААХҮЯ, аймгийн ХАА-н газар

(10) Хөрөнгө оруулалт (input)

1) Японы тал

- ① Газар шорооны ажил, тоног төхөөрөмж нийлүүлэх: тэжээл боловсруулах байгууламж, хураах, боловсруулах ХАА-н тоног төхөөрөмж, малын байр, мал нядалгаа болон мах боловсруулах байгууламж (ХАА-н тоног төхөөрөмж: 150,000\$, малын байр, хашаа барих: 40,000\$, мал нядалгааны газар, мах боловсруулах байгууламж барих: 400,000\$)
- ② Зөвлөх үйлчилгээ/удирдлагын бүрэлдэхүүн хэсэг: зураг төсөл, барилгын хяналт/тоног төхөөрөмжийн ашиглалт/удирдлага зааварчилгаа (зориулалтын байгууламжинд малын тэжээл тариалах гарын авлага бэлтгэх: 10,000\$)

2) Монголын тал

Улсын зүгээс үйл ажиллагаа явуулах газрыг бэлдэх, барилгын зөвшөөрөл авах, цахилгаан татах гэх мэт бэлтгэл ажлыг хийж хангах, хамтрагч талын хүлээх үүргийг чандлан мөрдөх

(11) Бусад төсөл, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай улдаа холбоотой ажиллах, ажил үүргийн хуваарьлалт

ЖАЙКА байгууллага нь Монгол Улсад 2020 оноос эхлэн “Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, борлуулалтад нэмүү өртгийн сүлжээний тогтолцоог бий болгоход чиглэсэн мастер төлөвлөгөөг боловсруулж байгаа тул мал нядалгаа, махны боловсруулалтын тал дээр хамтран ажиллах тухай хэлэлцэнэ.